

ОРШИЛ

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх замаар эдийн засгийн тогтвортой хөгжилд, экологийн тэнцвэрт байдлыг хангах зарчим нь дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудал болоод байна.

Ой байгалийн бусад ургамал Монгол Улсын үндсэн хуульд зааснаар төрийн өмч, төрийн хамгаалалтад байдаг байгалийн баялгийн нэгэн чухал төрөл юм. Ой бол ургамал, амьтны өөрийгөө хамгаалах, харилцан үйлчлэх бүтэц юм. Ойн модод нь бичил цаг уур, хөрсний тусгай бүтэцтэй экосистемийг бий болгодог.

Өөр хоорондоо ба хүрээлэн байгаа орчинтойгоо нягт уялдаа холбоотойгоор харилцан үйлчлэлцэн, цаг агаар, хугацаа, хүмүүсийн үйл ажиллагааны улмаас хэлбэр, хэмжээ, тоо, агуулгаараа байнга хувьсан өөрчлөгдөж байдаг мод, сөөг, ургамал ба бусад амьд организмуудын цогцолбороос тогтсон тодорхой нэгэн (ландшафт) хэв төрхийн тогтцыг ой гэдэг ойлголтод хамруулдаг.

Ойн экологийн ач холбогдол нь ургамал, амьтны аймгийн байршин амьдрах тааламжтай орчин бүрэлдүүлэх, газрын хөрсийг эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, усны эх ундарга, нөөцийг нэмэгдүүлэх, агаарыг хүчилтөрөгчөөр сэлбэж цэвэршүүлэх шим мандлын гол хүчин зүйл нь болж байдагт оршино.

Монгол улс байгаль орчныг хамгаалах түүхэн уламжлал, хууль, ёс заншилтай бөгөөд араатан гөрөөс, жигүүртэн шувууны төлийг үл агнах, үүр ичээг эвдэхгүй байх, усны эхийг цэвэр ариун байлгах, ой модыг эмх замбараагүй огтлохгүй байх, газар шороог хөндөхгүй байх зэрэг хуульчилсан ёс заншилтай байжээ.

Ийнхүү байгаль орчиндоо хандахдаа нүүдэлчдийн аж амьдралын зан заншил, соёл иргэншлийн хэм хэмжээг хуульчлан зохицуулж хойч үедээ байгалийн баялаг, түүний унаган төрх байдлыг харьцангуй сайн хадгалан үлдээсэн дэлхийн цөөн орны нэг юм.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх замаар эдийн засгийн тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах зарчим нь дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудал болоод байна.

Байгалийн баялгаа зүй зохистой ашиглах нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой ч үүнтэй зэрэгцүүлэн байгаль орчноо хамгаалах асуудлыг ямагт хамт авч үзэх шаардлага тулгарч байна.

Байгаль орчин гэсэн цогц асуудлын хамгийн чухал хэсэг нь ойн баялаг юм. Ойн менежмент, зүй зохистой ашиглалт, хамгаалалт, ойн тогтвортой хөгжлийн талаарх бүх асуудлыг цогцоор шийдвэрлэхэд ойн талаарх цаг үеэ олсон судалгаа, мэдээ, мэдээлэл чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд ойг хамгаалах уламжлал алдагдаж, ой хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөж, нөөц нь эрс багасаж байна. Иймд ойг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв менежментээр явуулахын тулд ой зохион байгуулалтын ажлыг шинэчлэн хийж, ойн төлөв байдалд үнэлгээ өгснөөр цаашид хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхэд баримтлах анхан шатны тулгуур материал болох тайлан, тархалтын зургийг шинэчлэн боловсруулан гаргаж байгаа нь чухал ажил юм.

Монгол орны ой түүний үүрэг, ач холбогдол

Монгол орны ойн санг бүрдүүлэгч амьтан ургамлын олон янз байдал, биологийн бусад бичил биетэн, байгалийн нөөц баялаг шүтэлцэн орших экологийн онцлог нөхцөл орчин үүсгэн зохицож ургасан байгалийн болон таримал байдлаар байгаа мод, бут, сөөгийн хам бүрдлийг ой гэнэ.

Монгол орны ойн баялаг нь нутаг дэвсгэрийн хойд хэсгийн уулархаг мужид ургасан шилмүүст, навчит ой, өмнө хэсгийн говь, цөл, хээрийн бүсэд тархан ургасан заган ойгоос бүрдэнэ.

Монгол орны ой нь Төв Азийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд ургадаг учир байгалийн жамаар сэргэх чадавхаар нэн хязгаарлагдмал, ойн түймэр, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртөмтгий чанартай байдаг.

Байгаль цаг уур, газарзүйн нөхцөлөөс хамаарч ойн ургах орчны нөхцөл, ойн өсөлт, ургалтын эрчим, модны чанар, нөөц зэрэг таксацын дундаж үзүүлэлтүүд нь модны төрөл тус бүрд өөр өөр байна.

Ой нь байгалийн чухал өвийг бүрдүүлдэг, эдийн засгийн чухал ач холбогдол бүхий баялаг бөгөөд даян дэлхийн байгаль орчны тогтвортой байдлыг хангаж байдаг. Ой нь хүнс, мод болон модон бүтээгдэхүүн зэрэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүний эх үүсвэр бөгөөд уур амьсгалыг зохицуулах, усны нөөцийг хамгаалах, ядуурлыг бууруулах, тайвшрал, гоо зүйн тааламжийг хангах зэрэг экосистемийн үйлчилгээний эх үүсвэр нь болдог.

Монгол Улсын ойн сангийн талбай 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 18 596.1 мян.га байна. Энэ нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзэлж байна.

Манай орны ой сан 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрдэх бөгөөд 83.4 хувийг навчит болон шилмүүст ой, 16.6 хувийг заган ой эзэлнэ. Монгол оронд зонхилгогч гол мод нь шинэс бөгөөд байгалийн ойн талбайн 63.0 хувийг, нөөцийн 79.3 хувийг эзэлдэг.

Тухайн газар нутгийн ойрхог чанарыг тогтоохдоо ойгоор бүрхэгдсэн талбайгаар тооцож үнэлдэг. Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай (улсын хэмжээний ойрхог чанар) нь нийт газар нутгийн 7.96 хувийг эзэлж байна.

Монгол улсын ойн сангийн талбайн 84.9 хувийг навч, шилмүүст ой, 15.1 хувийг заган ой эзэлнэ.

Монгол орны ой гол мөрний усны нөөцийг зохицуулах, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг барих зэрэг экологийн өндөр ач холбогдолтойгоос гадна Сибирийн их тайгын үргэлжлэл, дэлхийн гурван томоохон ус хагалбарыг дагаж ургадаг онцлог нь түүний экологид гүйцэтгэх үүрэг ач холбогдлыг олон улсын шинжтэй болгодог.

Монгол орны ой мод нь экологийн төдийгүй нийгэмд зориулагдсан үр өгөөж, ашгийн үндсэн нөөц болж, амьжиргааны эх үүсвэр, ажлын байр бий болгох, нийгмийн сайн сайхан байдлын хангамжийг бүрдүүлэх, соёлын үнэ цэнэ болох зэрэг нийгмийн өндөр ач холбогдолтой байдаг.

Ой мод нь экологийн онцгой ач холбогдолтойгоос гадна ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тодорхой нөөцтэй, эдийн засгийн асар өндөр ач холбогдолтой, нөхөн сэргээгддэг байгалийн үнэт баялаг юм.

Ерөнхий бичлэг

1. Ой зохион байгуулалтын ажлын зорилго

Энэ удаагийн ой зохион байгуулалтын ажлын зорилго нь Увс аймгийн ойн сангийн төлөв байдал, ойн талбай, нөөц, таксацын үндсэн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг тогтоож ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үндэслэлийг тусгасан ой зохион байгуулалтын ажлын тайлан, тархалтын зургийг шинэчлэн боловсруулах явдал юм.

2. Ойн сангийн судлагдсан байдал

Манай орны ойн санд 1956-1957 онуудад хуучнаар ЗХУ-ын техник хэрэгсэл, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анхны агаарын тоймчилсон судалгааг явуулж ойн сангийн нийт талбай, нөөц, таксацын үзүүлэлтүүдийг тогтоосон байдаг.

Увс аймгийн ойн санд анх 1990 онд аймгийн нийт ойн санг хамруулан ой зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байдаг. Улмаар 2002 онд Ханхөхийн нурууны байгалийн цогцолборт газрын хэмжээнд, 2007 онд Түргэн уулын дархан цаазат газар, Цагаан шувуутын дархан цаазат газрын хүрээнд хэсэгчилэн ой зохион байгуулалтын ажил хийгдэж байсан байна.

3. Ой зохион байгуулалтын техникийн тодорхойлолт

Ой зохион байгуулалт гэж ойн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүний хэмжээ, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг хэлнэ.

Ой зохион байгуулалтын ажлыг Засгийн газрын 2013 оны 105-р тогтоолоор баталсан "Ой зохион байгуулалт хийх журам", 2005 оны "Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах" тухай 25-р тогтоол, Ойн газрын даргын 2009 оны 88 тоот тушаалын 3 дугаар хавсралт "Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх заавар" зэрэг хууль эрх зүйн баримтын дагуу хийж гүйцэтгэсэн.

Ойн санг тоолж бүртгэх, өөрчлөлтийг гаргах, ойн ашиглалт, хамгаалалтын арга хэмжээг зүй зохистой явуулах, мэдээллийн санд өөрчлөлтийг тооцож байхад хялбар эмх цэгцтэй байх зорилгоор сум тус бүрийн ойн санг 800-1000 га орчим талбайтай хэсэглэлүүдэд хувааж баруун хойноос зүүн урагш дэс дараалуулан дугаарладаг. Хэсэглэлийн хилийг байгалийн үл хөдлөх тогтцыг ашиглан тогтоосон хуучин хилийг өөрчлөөгүй бөгөөд хоёр өндөрлөгийг холбосон шулуун шугамаар тогтоосон аймаг, сумын хилээр хязгаарлав.

Ойн санг хэсэглэлд хуваасан байдал, хэсэглэлүүдийн хилийн уулзвар цэгийн солбицлыг харуулсан тойм зургийг хавсаргав. Ойн таксацын үндсэн үзүүлэлтүүдийг хээрийн хэмжилт судалгаагаар хэмжигч багаж ашиглан тогтоов.

Ойн сангийн тооцоог ойн мэдээллийн сангийн "FOREST", "MS Access" тайлан боловсруулалтыг "WORD", ойн тархалтын зураг боловсруулалтын ажлыг "ArcView GIS-3.2" программ хангамжуудаар боловсруулж ойн мэдээ, боловсруулж гаргасан баримт материалыг ойн мэдээллийн санд хадгалсан болно.

Энэ удаагийн ой зохион байгуулалтын ажлын гол зорилго нь ойн төлөв байдал, тархалт, нөөц, таксацын үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоох, ойн өөрчлөлт, түүний шалтгааныг тодорхойлж "Ойн сангийн тархалтын зураг, тайлан мэдээ"-г сум, аймгийн түвшинд шинээр боловсруулах явдал юм. Ой зохион байгуулалтын ажлын үр дүнд ой бүхий сум тус бүрээр доорх материалыг боловсруулан гаргав. Үүнд:

- 1: 50 000 масштабтай ойн тархалтын зураг (сум тус бүр) - 2 хувь

- Ой зохион байгуулалтын ажлын тайлан (сум тус бүр) - 2 хувь
- Ойн таксацын бичлэг, төслийн хавсралт хүснэгт (сум тус бүр) - 2 хувь
- Ойн тойм зураг (сум тус бүр) - 2 хувь
- Аймгийн нэгдсэн тайлан - 2 хувь

4. Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх үндэслэл

Ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсын "Ойн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2020 оны А/25 дугаар тушаал, "Увс аймгийн ойн санд ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх" ажлын 84 тоот гэрээ зэргийг үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Ой зохион байгуулалтын хээрийн хайгуул судалгааны хэмжилт, тооллогын ажлыг мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж гүйцэтгэсэн бол материал боловсруулалтын ажлыг "Ойн судалгаа хөгжлийн төв" УТҮГазрын Ойн нөөцийн судалгаа, ашиглалтын алба хариуцан гүйцэтгэв.

5. Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэсэн хугацаа

Ой зохион байгуулалтын бэлтгэл ажлыг 2020 оны 2-5 сарын хооронд, хээрийн хайгуул судалгааны ажлыг 6-10 сарын хооронд, материал боловсруулалтын ажлыг 2020 оны 10 сараас 2021 оны 3 сарын хооронд хийж гүйцэтгэв.

6. Ой зохион байгуулалтын ажлын аргазүй


Ой зохион байгуулалтын ажлын гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулсан. Ойн сангийн талбайн хэмжээ болон байршлыг харгалзан Увс аймгийн ойн санг 1 багц болгон тендер зарласан бөгөөд "Увс аймгийн ойн санд ой зохион байгуулалт хийх ОНСАА 2020-01" тендерт "Гранд форест" ХХК гүйцэтгэгчээр шалгарч хээрийн хайгуул судалгаа, хэмжилт тооллогын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ой зохион байгуулалтын ажлын үр дүнг дээшлүүлэх, бодит байдалд ойртуулах үүднээс хэмжилтэд тулгуурласан буюу дээж талбай байгуулан хэмжилт тооллого хийх аргачлалаар хийж гүйцэтгэв.

Дээж талбайн загвар нь нэг цэгийн байршилд тухайн ойн янз бүрийн өтгөрөл бүхий хэсгийг хамруулах, статистикийн хувьд вариацийн коэффициентийг илтгэх, хээрийн ажлын үед хэмжилтэд зарцуулагдах хөдөлмөр, цаг хугацааг хэмнэх, хэмжилтийн алдаа гарах нөхцөлийг бууруулахад чиглэгдэнэ.

Статистик дүн шинжилгээ хийх үед бага зайнд ойн ургамалжилтын нягтшилын өөрчлөлтийн олон төрлийг хамруулах, хэмжилтийн үр дүнгийн статистик шинжилгээний вариацийн коэффициентийг нэмэгдүүлэх зорилготой дээж талбайн загвар нь давхар тойргуудаас бүрдэнэ.

Дээж талбайн загвар болон дээж талбайн давхар тойргийн загварыг дараахь зургаар харуулав.



Зураг 1. Дээж талбайн давхар тойргийн загвар

Дээж талбайд хийх хэмжилт харилцан адилгүй радиустай тойргуудад хийгдэх бөгөөд тэдгээрийн радиус нь хэмжилтэд хамрагдах модны цээжний өндрийн диаметр (1.3 метр) болон онцлог хэмжээний хязгаарыг тодорхойлдог. Тойргуудад хийгдэх хэмжилтийн төрлүүдийг 1-р хүснэгтээр үзүүлэв.


1-р хүснэгт

Тойргийн радиус ба түүнд хийгдэх хэмжилтүүд

| Тойргийн радиус | Хэмжилт, судалгаа |
|-----------------|---|
| 2 метр | Төв цэгээс баруун, зүүн зүгт 6 метрийн зайнд 2 метрийн радиустай 2 тойрогт байгалийн сэргэн ургалтын тооллого хийнэ. Тооллогыг 10-50 см, 51-150 см, 151 см дээш гэсэн өндрийн 3 ангиллаар тоолох ба цээжний өндрийн диаметр 5.99 см хүртэл байна. |
| 6 метр | Цээжний өндөрт 6.0 см-14.9 см диаметртэй мод болон биологийн олон янз байдлын тооллого хийгдэнэ. |
| 12 метр | Цээжний өндөрт 15.0-29.9 см диаметртэй мод тоологдоно. |
| 20 метр | Цээжний өндөрт 30.0 см-ээс дээш диаметртэй мод, газрын налуу болон ландшафт, мал бэлчээрлэлт, ойн ташингын бүтэц, ойн нөхцөл, үүрэг, ойн түймрийн нөлөө, хөрсний эвдрэл зэрэг үзүүлэлтийг хэмжиж тэмдэглэнэ. |


Хэмжилтийн цэгийн сонголт

Ой зохион байгуулалтын ажлын бэлтгэл ажлын хүрээнд ойн сангийн талбайг урьдчилсан байдлаар тодорхойлох, хээрийн хэмжилт тооллогын цэгийг сонгон байршуулах ажил хийгдсэн.




Зураг 2. Хээрийн хэмжилтийн цэг сонгосон дараалал

Увс аймгийн ой зохион байгуулалтын ажлын хээрийн хайгуул судалгааны ажлын хэмжилтийн цэгийг тодорхойлохдоо QGIS газарзүйн мэдээллийн системийн программ хангамжийн тусламжтайгаар аймгийн газар нутгийн хэмжээнд 0.5 х 0.5 км-ийн тор татаж торлолын огтлолцол бүр дээр үнэлгээний цэгийг тархаан байршуулсан.




Зураг-3. Нийт газар нутгийн хэмжээнд торлол татсан байдал



Зураг-4. Торлолын огтлолцол бүр дээр буусан үнэлгээ хийх дээж талбайг харуулсан байдал

Тархаан байршуулсан нийт 9425 цэгт НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан газрын төрлийн өөрчлөлтийг тодорхойлох “OPENFORIS Collect Earth” программ хангамжийн тусламжтай үнэлгээ хийж ойн сангийн газрын төрлийг тогтоосны дараа газрын төрөл тус бүрээс сонголт хийж ижил утга илэрхийлэх цэгүүдээс оновчтой хувилбаруудыг сонгож хээрийн хэмжилт хийх цэгүүдийг байршуулсан.

Увс аймгийн хэмжээнд нийт 586 дээж талбай байгуулж хэмжилт, тооллого хийхээр сонгон байршуулсан.



Зураг 5. 3OPENFORIS Collect Earth3 программын үнэлгээний загварчлал

Ойн сан:

- Байгалийн ой
- Сөөг, торлог
- Таримал ой
- Шатсан талбай
- Цагаан энгэр
- Бусад газрын төрөл

Бусад газар:

Увс аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамруулан 9425 цэгт “OPENFORIS Collect Earth” программ хангамж ашиглан хийсэн газар ашиглалтын үнэлгээний үр дүнг доорх хүснэгтээр үзүүлэв.

2-р хүснэгт

Газар ашиглалтын үнэлгээ

| Газрын төрөл | Газрын ангилал | Цэгийн тоо | Талбай мян.га |
|------------------------------|--|-------------|---------------|
| Ойн газар | Байгалийн ой | 6099 | 152475 |
| | Сөөг, торлог | 53 | 1325 |
| | Тармаг мод | 1178 | 29450 |
| | Шатсан талбай | 29 | 725 |
| | Мод бэлтгэсэн талбай | 15 | 375 |
| | Цагаан энгэр | 48 | 1200 |
| | Таримал ой | 1 | 25 |
| | Ойжуулсан талбай | 4 | 100 |
| | Хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай | 23 | 575 |
| Ойн сангийн талбайн нийт дүн | | 7450 | 186250 |
| Бусад газар | | 1975 | 49375 |
| Нийт | | 9425 | 235625 |

Увс аймгийн ойн санд хээрийн хэмжилт судалгаа явуулсан дээж талбайн байршлын солбицлын жагсаалтыг ой зохион байгуулалтын ажлын тайланд хавсаргав.


7. Хяналт, баталгаажуулалт

Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэхийн өмнө I зөвлөгөөнийг гүйцэтгэгч болон захиалагч тал, Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ой бүхий сумдын байгаль хамгаалагч, ойн ангийн мэргэжилтэн нарыг оролцуулан 2020 оны 06 сарын 08-ны өдөр Улаангом хотод зохион байгуулсан.

Ой зохион байгуулалтын хээрийн хайгуул судалгааны ажлын явцад "ОйСХТ" УТҮГ-аас томилогдсон төслийн менежер болон орон нутгийн байгаль хамгаалагч бусад холбогдох албан тушаалтан нар хяналт тавьж ажилласан ба хяналтын тооллого хийж зөрчлийг арилгах, заавар аргачлалыг мөрдөх талаар заавар, зөвлөмжөөр хангаж ажилласан.

Ой зохион байгуулалтын ажлын тайлан, ойн зураглалын ажил дууссаны дараа II зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж орон нутгийн саналыг тусган нэмэлт засвар хийв.

Ой зохион байгуулалтын ажлын үр дүн, тайлан зураглалын ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөл”-ийн 2021 оны 06 сарын 21-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулан 1 хувийг ойн мэдээллийн сангийн архивт хүлээлгэн өгсөн. Увс аймгийн ойн санд хээрийн хэмжилт судалгаа явуулсан дээж талбайн байршлыг 6-р зургаар харуулав.



Зураг-6. Увс аймгийн ойн санд хэмжилт, тооллого хийсэн цэгүүдийн байршлыг харуулсан тойм зураг.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ


УВС АЙМГИЙН БАЙГАЛЬ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1. Газар зүйн байрлал

Увс аймаг нь Монгол Улсын баруун хэсэгт Хан Хөхий, Хархираа, Түргэний уулс, Увс нуурын хотгорын баруун урд захад оршино. Улаанбаатар хотоос 1417 км зайд хойд талаараа ОХУ-лс, зүүн талаараа Завхан аймаг, өмнө талаараа Ховд аймаг, баруун талаараа Баян-Өлгий аймагтай тус тус хил залган оршино. Увс аймаг нийт 69.6 км² газар нутагтай. Аймгийн төв Улаангом нь далайн түвшнээс дээш 939 метр өргөгдсөн. Хамгийн өндөр уул нь д.т.д 4116 метр өндөр Хархираа уул юм.

Тус аймгийн нутаг нь Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Хан Хөхийн өндөр уулс бүхий говь цөлөөс өндөр уулсын мөнх ца, мөсөн гол хүртэлх Төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан өвөрмөц тогтоцтой. Байгалийн мужлалаар Увс, Хяргас хуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Хан Хөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтдаг. Хамгийн нам цэг нь д.т.д 758.9 метрт Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь д.т.д 4250 метрт Цагаан Дэглий оргил юм.

Хархираа, Түргэний уулс нь залуу атираат уул бөгөөд Хяргас, Увс нуурын хотгороор шинэ төрмөлийн эриний хурдас тархсан. Чулуун нүүрс (Нүүрст хотгор, Хар Тарвагатай) бий бөгөөд барилгын материалын баялагтай, мөн жамц давсны асар их нөөцтэй Шүдлэн уул энд байдаг.



Зураг-7. Увс аймгийн газарзүйн байршил

1.2. Уур амьсгал

Байгальд гарч буй хувьсал, байгалийн иж бүрдлийн өөрчлөлтөд уур амьсгалаас үзүүлэх нөлөө хамгийн чухал байр суурийг эзэлдэг. Уур амьсгал гэдэг маш өргөн утгатай бөгөөд түүнд сав газрын агаарын ба хөрсний дулаан, хүйтэн, хур тунадас, салхи, нарны гэрлийн цацралт, ууршилт зэрэг уур амьсгалын олон нэгжүүд багтах боловч тэдгээр нь газар зүйн бусад нөхцөлүүдтэй хамтран шууд буюу шууд бусаар нөлөөлнө.

Увс аймгийн цаг уурын байдал нь Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм. Иймээс өвлийн улиралд агаарын даралт нэгдүгээр сард 1054 гПа болж, агаарын температурын хувьд Монгол орны хамгийн хүйтэн газар юм. Зуны улиралд хамгийн дулаандаа 7-р сард хөрсний гадаргын дундаж температур 30 хэм хүртэл дулаардаг. Өвөл нэгдүгээр сард 48 хэм хүрч хүйтэрнэ. Жилийн дундаж салхины хурд 1.4 м/сек, жилийн хур тунадасны нийлбэр 139.8 мм байна.

1.3. Ус зүйн нөхцөл

Увс аймаг нь усзүйн сүлжээний хувьд бараг бүхэлдээ Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. Аймгийн усны нөөц 1.121 м3/жил, өрнөд бүсийн нөөцийн 12.8 хувийг эзэлнэ.

Увс аймгийн нутгаар Түргэн, Тэс, Нарийн, Завхан, Ховд зэрэг том голууд урсах бөгөөд Увс, Хяргас, Үүрэг, Ачит, Хар-Ус, Дөрөө, Баян нуур гэхчлэн том нуурууд элбэгтэй. Хартэрмэсийн, Хавцал боомын, Бургастайн зэрэг рашаан ус бий.


Увс нуур

Увс нуур далайн түвшнээс дээш 753 метр өргөгдсөн, 3350 ам дөрвөлжин км нутаг дэвсгэр бүхий Монгол орны хамгийн том нуур юм. Увс нуур нь олон сая жилийн өмнөх аварга том тэнгисийн үлдэгдэл бөгөөд ихээхэн давсархаг, гүехэн устай нуур. Увс нуур нь Евро-Азийн тал нутгийн багйалийн унаган төрхийг хамгийн сайн хадгалан үлдээсэн 700000 хавтгай дөрвөлжин км нутгийг хамрах Увс нуурын сав газрын төв нь юм. Энд дэлхийн хамгийн хойд захын цөл, хамгийн өмнөд захын тундр оршдог. Увс нуурын савд олон нуурууд багтдаг ба тэдгээрийн нэг болох Үүрэг нуур д.т.д 1450 метр өндөрт оршдог. Энэ нуурууд нь Төв-Азийн гадагш урсгалгүй нуурууд бөгөөд усны шувуудын нүүдлийн маш чухал нутаг болдог. Увс нуур их нууруудын хойд хагаст, Увс аймгийн зүүн хойд хэсэгт орших бөгөөд 84 км урт, 79 км өргөн, 3350 ам.дөр.км хэмжээтэй. Увс нууранд Тэс, Нарийн, Хархираа, Түргэн, Сагил, Боршоо, Хөндлөн, Торхилог зэрэг том жижиг 38 гол, горхи цутгадаг. Нуурын хөвөөнд хужир, давс элбэгтэй, зэгс, дэрс, бут, сөөг, өлөн, шагшуурга, бургас, улиас зэрэг ургамалтай, 362 нэр төрлийн нүүдлийн шувуу, 72 төрлийн хөхтөн амьтан амьдардаг.

Хяргас нуур

Хяргас нуур Их нууруудын хотгор дахь эрдэст нуур. Тус нуурыг 2000 онд байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалтанд авсан. Ус нь үнэргүй, шорвог амттай, өнгө булингардалт нь цаг агаар, улирлын онцлогоос шалтгаалж өөрчлөгдөнө. Нуурын усны тунгалагжих үе нь гол төлөв өвлийн улиралд тохиолдож байхад зун, намрын улиралд шар

өнгөтэй болно. Өвлийн улиралд мөсөн бүрхүүл тогтож динамик хөдөлгөөн багасаж, улмаар нуурын усны тунгалаг чанар ихэсдэг.



Зураг-8. Увс аймгийн гадаргын усны зураглал

1.4. Хөрс

Тус аймгийн нутгийн ихэнх хэсэгт хээрийн цайвар хүрэн хөрс, уулархаг нутгаар уулын нугын талийн ба хар шороон хөрстэй, нуурын хэсгээр хөндий газраар намгархаг элсэрхэг хөрстэй, уулархаг нутгаараа ой хөвч, тагийн ургамалтай, нууруудын хотгороор говийн ургамал ургана.

1.5. Ургамлын бүрхэвч

Хархираа, Түргэн, Хан Хөхийн нуруунд өндөр уулын ургамалшил 2100-2400 метрээс авахуулаад уулсын орой дахь мөнх цасны шугам хүртэл үргэлжилнэ. Энд уур амьсгал хуурайн улмаас модлог ургамал ургах нөхцөл муутайгаас тайгын бүслүүр бий болдоггүй, тагийн бүслүүр шууд уулын хээр ба ойн бүслүүрт шилжинэ. Тагийн бүслүүр нэн ширүүн хахир уур амьсгалын нөхцөлд оршдог тул тэндэх ургамалшил тачир юм. Тагийн бүслүүрт олон наст ургамал зонхилно. Олон наст өвсний ксерофит шинжийн сибирийн бушилз, чийгэнд ивээлт улалжын зүйлүүд болох хар цэцэгт улалж, нарийн цэцэгт улалж, зэнтгэр улалж, түүнчлэн тагийн буржгар, гоо дэвхэргийн цагаан, нангиад холтсон цэцэг, тагийн тооронцор, цав цагаан гичгэнэ, цагаан дэгд, сормууст сэрдэг зэрэг алаг өвс ургана.

Тагийн бүслүүрийн уур амьсгал ширүүн тул нэг наст өвс бараг байхгүй, харин хаг, хөвд чухал үүрэгтэй. Тэнд бушилз, улалж, хаг, хөвд зонхилохын хамт хамгийн доод захаар нь явган бургас намхан тачир бут ургадаг. Уулын доод хэсгийн бүслүүрт тархан ургасан

модод нь намхан, сийрэг, өвслөг нөмрөг багатай голчлон хөвд, сөөг, сөөгөнцөр ургамалууд тархсан байдаг бол харин уулын бэл хэсгээс доош модод нь өндөр, өтгөрөл ихтэй, өвөлөг нөмрөгөөр баялаг болно. Голын татмын дагуу бургас, улиас, бут сөөг ургана.

1.6. Нийгэм эдийн засгийн нөхцөл

Ойрад Монголын их хаан Галдан бошигт 1686 онд Хархираа голоос суваг татуулж Увс нуурын хотгор Гурван тээл, Арсай, Мянган бэл, Хар толгой, Бор үзүүр зэрэг газруудад тариа тариулж эхэлсэн нь суурин амьдралын үндэс тавигдаж улмаар Улаангом сумын анхны шав тавигдсан гэж үздэг.

Чандмань уулын орчимд Дэчинравжаалан хөндийн анхны дацан болох Лүүжин дацан байгуулагдсан нь Улаангомьн хүрээний анхны суурь болсон байна. Лүүжин дацангын дэргэд Цогчин дуган, олон сүм баригдаж, лам хуврагууд олноор шавилан сууснаар Баянчандмань уулын хошуу байгуулагдаж, хошууны тамгын газар төвлөрсөнөөр Улаангомьн хүрээ нэртэй болсон байна. Улсын бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор 1931 оны 2 сард засаг захиргааны хуваарийг шинэчлэн Чандмань уулын аймгийг Увс, Ховд гэсэн 2 аймаг болгосноор Улаангом нь Увс аймгийн улс төр, эдийн засаг, соёл боловсролын төв болох эхлэл тавигдсан. Чандмань уулын аймгийг 1931 онд 2 аймаг болгоход Увс аймаг 16 сум, 150 баг, 9133 өрх, 43188 хүн амтай байжээ.

Увс аймаг нийт 19 сумтай бөгөөд 82758 хүн амтай, үүнээс 0-14 насныхан 33.8 хувь, 15-64 насныхан 62.7 хувь, 65-аас дээш насныхан 3.5 хувь байна. Хүн амын бүрэлдэхүүн нь дөрвөд, баяд, халх, элжигэн, сартуул, мянгад, өөлд, захчин, буриад, түрэг үндэстэн, хотон, хасаг зэрэг үндэстэн ястантай. Увс аймгийн төв Улаангом сумыг анх 12 багтайгаар байгуулсан бөгөөд одоо 11 баг, 7043 өрх, 25098 хүн амтай байна. Улаангом сум нь аймгийн төвийн сум бөгөөд нийт хүн амын 33.9 хувь амьдардаг. Дэд бүтцийн салбарын бүхий л шийдлүүд иж бүрэн хийгдэж байна.

Аймгийн төвөөс хамгийн ойр сум Түргэн 28 км, хамгийн алслагдсан сум Зүүнхангай 365 км зайтай. Үйлдвэрлэл үйлчилгээ, жижиг дунд үйлдвэр, олонтой, цаашид өргөжих боломжтой, гадаад зах зээлд ойрхон. ОХУ-руу гарах хилийн боомт Давст сумын нутагт Боршоо, Тэс сумын нутагт Тэс боомт бий. БНХАУ болон ОХУ-лстай эдийн засаг, худалдаа, бүх талын харилцаа холбоо хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ойр юм.

Улаангом хот нь Улаанбаатар хот болон ОХУ-ын Хандгайтын боомттой хатуу хучилттай авто замаар холбогдсон, мөн хотын дотор 21 км хатуу хучилттай авто зам, 18 км явган хүний зам ашиглагдаж байна. Сум хооронд шороон замаар холбогддог.

Эрчим хүчний хувьд аймгийн бүх сум төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон, харилцаа холбооны хувьд үүрэн холбооны бүх салбар болон интернет сүлжээнд бүрэн хамрагдсан.

Увс аймгийн нутгийн зүүн хэсэгт газар тариалан хөгжүүлсэн, аймгийн төв Улаангомд барилгын, хүнсний үйлдвэрүүдтэй.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үзэсгэлэнт Увс нуур, Хархираа, Түргэний, сүрлэг уулстай. Газрын доорх ашигт малтмалын нөөц баялагтай, сор бүтээгдэхүүн болох чацарганы бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломжтой.

Тус аймгийн эдийн засгийн голлох салбар нь уламжлалт мал аж ахуй бөгөөд ноос, ноолуур, махны чиглэлийн хонь, ямаа, үхэр, адууны аж ахуй зонхилдог. Газар нутгийн ихэнх хувийг бэлчээрийн талбай эзэлдэг ч Галданбошигтын үеэс газар тариалан эрхэлж ирсэн түүхэн уламжлалтай. Сүүлийн жилүүдэд чацаргана тариалалт эрс нэмэгдэж,

үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ өссөн. Арвайн гурил, чацаргана, жамц давс зэрэг Увс нэрийн бүтээгдэхүүн зах зээлд өрсөлдөж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОЙН САН

2.1. Ойн бүс

Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ. Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 метр хүртэлх газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сан бүхий газарт хамаарна. Энэ удаагийн судалгааны үр дүнгээр Увс аймгийн ойн сангийн талбай 210 407 га гэж тогтоогдов.

Увс аймгийн ойн санд 586 дээж талбай байгуулан хэмжилт тооллого хийн ойн сангийн талбай, нөөц, таксацын дундаж үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоов.

Ой зохион байгуулалтын ажлын хээрийн хайгуул судалгааны ажлаар хэмжилт тооллого хийсэн цэг, дээж талбайн тоо хэмжээг 3-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-3

Ойн санд хэмжилт хийсэн цэг болон дээж талбайн тоо хэмжээ

| д/д | Сумын нэр | Дээж талбай | д/д | Сумын нэр | Дээж талбай |
|-----|--------------|-------------|-----|---------------|-------------|
| 1 | Баруунтуруун | 42 | 9 | Сагил | 46 |
| 2 | Бөхмөрөн | 15 | 10 | Тариалан | 12 |
| 3 | Давст | 37 | 11 | Түргэн | 51 |
| 4 | Зүүнговь | 3 | 12 | Тэс | 30 |
| 5 | Зүүнхангай | 71 | 13 | Улаангом | 14 |
| 6 | Малчин | 30 | 14 | Ховд | 16 |
| 7 | Наранбулаг | 25 | 15 | Хяргас | 34 |
| 8 | Өндөрхангай | 110 | 16 | Цагаанхайрхан | 50 |

Монгол Улсын “Ойн тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д зааснаар ойн санг хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи-эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ашиглалтын бүсийн ой, хамгаалалтын бүсийн ой гэж ангилдаг.

Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна.

Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хамгаалалтын бүсийн ой нь ургах хугацаандаа гүйцэтгэдэг нийгмийн (амралт, сувилал, хот суурин газрын хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах), хамгаалалтын (усны

горим зохицуулах, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах) болон экологи-эдийн засгийн ач холбогдлоороо ангилагддаг.

Увс аймгийн ойн санг Монгол Улсын “Ойн тухай” хуулийн холбогдох заалтын дагуу ойн бүсүүдэд хуваахад дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, ногоон бүс, хориотой зурвасын ой, 100 га хүртэлх ой, сөөг ширэнгэ, уулын өвөр энгэр төгөл ой, 30 хэмээс дээш налуу газрын ой, улсын хилийн дагуух ой, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, ашиглалтын бүсийн ой гэж ангилагдаж байна.

Дархан цаазат газар

Дархан цаазат газарт байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хамгаалалтад авсан газар нутаг орно. Дархан цаазат газрын эрх зүйн дэглэмийг нарийвчлан тогтоохын тулд тухайн газрын байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс гэсэн дотоод бүсэд хуваана. Бүс тус бүр өөр өөр дэглэмтэй.

Увс нуурын ай сав дархан цаазат газар

Говь, цөлөрхөг хээр, хээр тал, ойт хээр, уул нуруу, мөнх цас, мөсөн голуудыг багтаасан эрс тэс уур амьсгалтай нутаг юм. Увс нуурын ай савын дархан цаазат газрууд нь 1997 онд НҮБ-ын “Хүн ба шим мандал” хөтөлбөрийн олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд, 2003 онд дэлхийн өвийн сүлжээнд, 2004 онд олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа нүүдлийн шувууд олноор амьдардаг орчны тухай олон улсын конвенцид тус тус нэгдэн орж бүртгэгдсэн. Мөн олон улсын гео-биосферийн судалгааны бүсэд багтдаг. “Увс нуурын ай сав” нь дэлхийн байгалийн бүс, бүслүүрийн бүхий л шинж төрхийг өөртөө агуулсан эргэн тойрон уулсаар хүрээлэгдэж оршдог олон улсын ач холбогдол бүхий Төв Азийн эталон нутаг юм. Энэхүү ач холбогдлыг тооцон 1993 онд УИХ-ын 83 дугаар тогтоолоор 755244.05 га талбайг Увс нуурын ай савын кластерийн дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан байна.

Увс нуурын ай савын кластерийн дархан цаазат газрууд нь Увс аймгийн Тэс, Давст, Малчин, Наранбулаг, Тариалан сумдын нутагт орших Увс нуурын, Баруунтуруун суманд орших Алтан элсний, Сагил сумын нутаг дахь Цагаан шувуутын, Түргэн, Тариалан, Бөхмөрөн, Ховд сумын нутагт орших Түргэн уулын гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Байгалийн цогцолборт газар

Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ. Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан онцгой бүс, аялал жуулчлалын бүс, хязгаарлалын бүс гэсэн дотоод бүсчлэлд хуваадаг.

Хан Хөхийн нуруу, Хяргас нуурын байгалийн цогцолборт газар

Хангайн нурууны хамгийн баруун талын салбар уулс болох Хан Хөхийн нуруу, нөгөө талаас Хяргас, Айраг нуур, Завхан, Хүнгүй голуудын адаг тэдгээрийн эргэн тойрны

цөлөрхөг ландшафт бүхий гандуу хуурай орчныг хамарсан ландшафтын эрс тэс хэв шинж тод ялгаран хосолсон хангай нь говьтойгоо зэрэгцэн, цөлөрхөг, гандуу хуурай орчин нуур устай хоршин өвөрмөц орчин үүсгэсэн энэ нутгийг хамгаалах, зохистой ашиглах, аялал жуулчлал хөгжүүлэх зорилгоор Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Хяргас сумдын нутаг дэвсгэрийн 221598 га талбайг хамруулан 2000 онд УИХ-ын 29 дүгээр тогтоолоор байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

Дэвэлийн арал

Увс аймгийн Ховд, Бөхмөрөн, Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Алтанцөгц сумын нутагт орших Ачит нуурыг хамруулан 211552.83 га газар нутгийг 2020 оны Улсын их хурлын 46 дугаар тогтоолоор байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

Байгалийн нөөц газар

Байгалийн өвөрмөц тогтоцтой ан амьтан жигүүртэн шувууд нүүдэллэн буюу байнгын оршин байдаг, ургамал болон модлог ургамлын зүйлээр баялаг газрууд орох ба зам гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах, түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялаг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Тэсийн голын нөөц газар

Булнайн нуруунаас эх аван Увс нуурт цутгах Тэсийн гол орчмын 103705 га нутгийг УИХ-ын 2006 оны 26 дугаар тогтоолоор байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

Ногоон бүс

Байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах зорилгоор хот тосгон суурин газрын эргэн тойрны ойд ногоон бүс тогтоодог. Увс аймгийн ойн сангийн 7.5 хувь буюу 15748 га талбай ногоон бүсийн ойд хамаарч байна.

Хориотой зурвасын ой

Ой нь ургаж байгаа хугацаандаа олон чухал үүрэг гүйцэтгэдгийн нэг нь гадаргын болон газар доорх усны горимыг зохицуулах, усны чанарыг дээшлүүлэх, ус хамгаалалтын үүрэг юм. Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой хамаарна. Увс аймгийн ойн сангийн 13.6 хувь буюу 28620 га талбай хориотой зурвасын ойд хамаарч байна.

100 га хүртэлх хэмжээний төгөл ой

100 га хүртэлх хэмжээний төгөл ой гэдэг нь эх ойгоосоо тусгаарлагдмал бага хэмжээтэй төгөл хэлбэрээр тархсан жижиг зураа, ширэнгэ, уулын өвөр энгэрийн төгөл ой хамаарах ба цаашид тэлж урган ойн сангийн талбай нэмэгдэхэд ихээхэн ач холбогдолтойн дээр талбайгаар нь хавтгайруулан огтолбол шууд хээржих хандлагатай ойг хэлнэ. Увс аймгийн ойн сангийн 1.2 хувь буюу 2571 га талбай 100 га хүртэлх хэмжээний төгөл ойд хамаарч байна.

30 хэмээс дээш налуу газрын ой

Энэ аж ахуйн төрлийн ой нь ихэвчлэн ус хагалбарын шугам дагуу байрлах учраас хөрсийг салхи, усны элэгдэл эвдрэлээс хамгаалах, гол үүрэг ач холбогдолтой бөгөөд ургах орчных нь тохиромжтой нөхцөлийг алдагдуулахгүй байх, ойн хэвийн өсөлт, өөрөө аясаараа сэргэн ургах нөхцөлийг хангах үүднээс хамгаалалтын бүсэд оруулдаг. Увс аймгийн ойн сангийн 2.8 хувь буюу 5917 га талбай 30 хэмээс дээш налуу газрын ойд хамаарч байна.

Улсын хилийн дагуух ой

“Монгол Улсын хилийн тухай” хуулийн 3 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 1-д “Улсын хилийн бүсэд хилийн дэглэмийг сахиулах, Улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зориулалттай хилийн инженер, техникийн байгууламж барих зорилгоор Улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүй Улсын хил хамгаалах байгууллагаас тогтоосон нутаг дэвсгэрийг Улсын хилийн зурвас гэнэ” гэж заасан байдаг.

Увс аймгийн ойн сангийн 2871 га талбай буюу 1.4 хувь нь Улсын хилийн дагуух ойд орж байна.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

Ховор ан амьтаны нутагшил газар, ховор эмийн ургамал, рашаан ус, байгалийн өвөрмөц сонин тогтоц бүхий хадан цохио, агуй, эртний хүмүүсийн сүг зураг, гэр байшингийн туурь, булш зэрэг түүх соёлын дурсгалт газар, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамгаалах зорилгоор орон нутгийн тусгай хамгаалалтанд авдаг. Увс аймгийн ойн сангийн 10.2 хувь буюу 21549 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байна.


Ашиглалтын бүс

Ашиглалтын бүсийн ойд хамгаалалтын бүсэд хамрагдаагүй үлдсэн бүх ойг хамааруулна. Ашиглалтын бүсийн ойгоос иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, мод ойн дагалт нөөцийг ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан менежментийн төлөвлөгөөний дагуу ашиглах эрхтэй. Увс аймгийн ойн сангийн 8.0 хувь буюу 16800 га талбай ашиглалтын бүсийн ойд хамаарч байна. Увс аймгийн ой бүхий 18 сумаас 3 сумын ойн санд ашиглалтын бүс тогтоогдсон байна.

Увс аймгийн ойн сангийн талбайг аж ахуйн бүсээр ангилж 1-р бүдүүвчээр үзүүлэв.

Бүдүүвч-1

Увс аймгийн ойн сангийн талбайг аж ахуйн бүсээр ангилсан нь



Увс аймгийн ойн сангийн талбайг бүсээр ангилсан байдлыг доорх хүнэгтээр үзүүлэв.

Хүснэгт-4

Ойн сангийн талбайг бүсээр ангилсан байдал

| Ойн бүс | Аж ахуйн төрөл | Талбай | Хувь |
|------------------|--|--------|------|
| Хамгаалалтын бүс | Дархан цаазат газрын онгон бүс | 550 | 0.3 |
| | Дархан цаазат газрын хамгаалалтын бүс | 6138 | 2.9 |
| | Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс | 11816 | 5.6 |
| | Байгалийн цогцолборт газрын онцгой бүс | 10448 | 5.0 |
| | Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс | 49387 | 23.5 |
| | Байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүс | 6822 | 3.2 |
| | Байгалийн нөөц газар | 31170 | 14.8 |
| | Ногоон бүс | 15748 | 7.5 |
| | Хориотой зурвасын ой | 28620 | 13.6 |

| | | |
|--|--------|-------|
| 100 га хүртэлх ой, сөөг ширэнгэ уулын энгэр төгөл ой | 2571 | 1.2 |
| 30 хэмээс дээш налуу газрын ой | 5917 | 2.8 |
| Улсын хилийн дагуух ой | 2871 | 1.4 |
| Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг | 21549 | 10.2 |
| Ашиглалтын бүс | 16800 | 8.0 |
| Ойн сангийн нийт талбай | 210407 | 100.0 |


2.2. Ойн сангийн үзүүлэлт

2.2.1. Талбай

Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн 2 хэсэгт ангилах ба ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж 2 хуваагддаг.

Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой байгаа болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд одоогоор ой байхгүй боловч цаашид ой ургах нөхцөл бололцоотой газрууд (байгалийн аясаар ойжиж байгаа газар, тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай г.м.) тус тус хамрагддаг.

Увс аймгийн ойн сангийн тархалтыг тоймчлон 9-р зургаар харуулав.



Зураг-9. Увс аймгийн ойн тархалтыг харуулсан тойм зураг

Ойн бус талбайд ойн сан доторх (цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, нуур, намаг, элс, мод үржүүлгийн талбай) зэрэг газрууд ордог. Увс аймаг ойн сан бүхий 18 сумтай бөгөөд сум тус бүрийн ойн сангийн талбай, байгалийн ойн нөөцийн хэмжээ, тэдгээрийн эзлэх хувь хэмжээг 5-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт -5

Ойн сангийн талбай, ойн нийт нөөц сум тус бүрээр

| д/д | Сумын нэр | Талбай (га) | Талбайд эзлэх хувь | Нөөц (шоо.метр) | Нөөцөд эзлэх хувь |
|------|---------------|----------------|-----------------------|--------------------|----------------------|
| 1 | Баруунтуруун | 12809 | 6.1 | 1125830 | 5.7 |
| 2 | Бөхмөрөн | 3890 | 1.8 | 156130 | 0.8 |
| 3 | Зүүнговь | 401 | 0.2 | 8560 | 0.04 |
| 4 | Завхан | 6 | 0.003 | 70 | 0.0004 |
| 5 | Зүүнхангай | 23952 | 11.4 | 3189110 | 16.1 |
| 6 | Өндөрхангай | 41067 | 19.5 | 5057010 | 25.5 |
| 7 | Сагил | 15344 | 7.3 | 1333050 | 6.7 |
| 8 | Давст | 11024 | 5.2 | 622360 | 3.1 |
| 9 | Тариалан | 1833 | 0.9 | 201900 | 1.0 |
| 10 | Түргэн | 17296 | 8.2 | 1708650 | 8.6 |
| 11 | Тэс | 31580 | 15.0 | 753850 | 3.8 |
| 12 | Улаангом | 5451 | 2.6 | 562570 | 2.8 |
| 13 | Малчин | 7785 | 3.7 | 883002 | 4.5 |
| 14 | Ховд | 4564 | 2.2 | 146190 | 0.7 |
| 15 | Наранбулаг | 6831 | 3.2 | 888290 | 4.5 |
| 16 | Хяргас | 10403 | 4.9 | 1419710 | 7.2 |
| 17 | Цагаанхайрхан | 15377 | 7.3 | 1765240 | 8.9 |
| 18 | Өмнөговь | 794 | 0.4 | 16200 | 0.1 |
| Нийт | | 210407 | 100.0 | 19837722 | 100.0 |

Ойн сангийн талбайг газрын төрлөөр ангилан аж ахуйн бүс тус бүрээр нэгтгэн 6-р хүснэгтээр үзүүлэв.

Ойн санг газрын төрлөөр ангилсан нь (га)

| Ойгоор бүрхэгдсэн талбай | | | | Ойгоор бүрхэгдээгүй талбай | | | | | Ойн бус талбай | | | | Ойн бус талбайн дүн | Ойн сан | |
|---|-----------|------------|--------|----------------------------|---------------|----------------------|--------------|-------|-----------------|--------------|----------------------|-----------|---------------------|---------|--------|
| Байгалийн ой | Бут, сөөг | Таримал ой | Дүн | Тармаг мод | Шатсан талбай | Мод бэлтгэсэн талбай | ОХШӨН талбай | Дүн | Ойн талбайн дүн | Цагаан энгэр | Мод үржүүлгийн газар | Таг царам | | | |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Дархан цаазат газрын онгон бүс | | | | | | | | | | | | | | | |
| 387 | | | 387 | 163 | | | | 163 | 550 | | | | | - | 550 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Дархан цаазат газрын хамгаалалтын бүс | | | | | | | | | | | | | | | |
| 4,110 | | | 4,110 | 1,993 | | | | 1,993 | 6,103 | 35 | | | | 35 | 6,138 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс | | | | | | | | | | | | | | | |
| 9,867 | 4 | | 9,871 | 1,866 | | | | 1,866 | 11,737 | 79 | | | | 79 | 11,816 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Байгалийн цогцолборт газрын онцгой бүс | | | | | | | | | | | | | | | |
| 9,197 | 100 | | 9,297 | 690 | 7 | 26 | 198 | 921 | 10,218 | 230 | | | | 230 | 10,448 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс | | | | | | | | | | | | | | | |
| 42,112 | 352 | | 42,464 | 3,436 | 739 | 900 | 530 | 5,605 | 48,069 | 1,317 | 1 | | | 1,318 | 49,387 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс- Байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүс | | | | | | | | | | | | | | | |
| 6,111 | | | 6,111 | 304 | 50 | 186 | | 540 | 6,651 | 171 | | | | 171 | 6,822 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Байгалийн нөөц газар | | | | | | | | | | | | | | | |
| 25,491 | | | 25,491 | 5,631 | | | | 5,631 | 31,122 | 2 | | 46 | | 48 | 31,170 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Ногоон бүс | | | | | | | | | | | | | | | |
| 13,505 | 35 | | 13,540 | 1,814 | 48 | 147 | 14 | 2,023 | 15,563 | 185 | | | | 185 | 15,748 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс-Хориотой зурвасын ой | | | | | | | | | | | | | | | |
| 17,385 | 1,522 | | 18,907 | 6,845 | 221 | 265 | 1,924 | 9,255 | 28,162 | 458 | | | | 458 | 28,620 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс- 100 га хүртэлх төгөл ой | | | | | | | | | | | | | | | |
| 1,923 | | | 1,923 | 616 | | | 19 | 635 | 2,558 | 13 | | | | 13 | 2,571 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс- 30 хэмээс дээш налуу газрын ой | | | | | | | | | | | | | | | |
| 5,469 | 4 | 30 | 5,503 | 389 | | | | 389 | 5,892 | 25 | | | | 25 | 5,917 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс- Улсын хилийн дагуух ой | | | | | | | | | | | | | | | |
| 2,549 | | | 2,549 | 214 | | | | 214 | 2,763 | 108 | | | | 108 | 2,871 |
| Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүс- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг | | | | | | | | | | | | | | | |
| 19,821 | | 6 | 19,827 | 1,033 | 39 | 326 | | 1,398 | 21,225 | 324 | | | | 324 | 21,549 |
| Аж ахуйн төрөл: Ашиглалтын бүс-Ашиглалтын бүсийн ой | | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---------------------------|-------|----|---------|--------|-------|-------|-------|--------|---------|-------|---|----|-------|---------|
| 15,666 | 10 | | 15,676 | 687 | 30 | 159 | 27 | 903 | 16,579 | 221 | | | 221 | 16,800 |
| Аймгийн хэмжээгээр | | | | | | | | | | | | | | |
| 173,593 | 2,027 | 36 | 175,656 | 25,681 | 1,134 | 2,009 | 2,712 | 31,536 | 207,192 | 3,168 | 1 | 46 | 3,215 | 210,407 |

Увс аймгийн ойн сангийн нийт талбай 210407 га байна. Үүнээс 207192 га буюу 98.5 хувийг ойн талбай, 3215 га буюу 1.5 хувийг ойн бус талбай эзэлж байна.

Ойн талбайн 175656 га талбай буюу 84.8 хувийг ойгоор бүрхэгдсэн талбай, 31536 га буюу 15.2 хувийг ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна.


Ойгоор бүрхэгдсэн талбайн 98.8 хувь буюу 173593 га талбайг байгалийн ой, 1.2 хувь буюу 2027 га талбайг бут сөөг, 0.02 хувь буюу 36 га талбайг таримал ой тус тус эзэлж байна.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн 25681 га буюу 81.4 хувийг тармаг мод, 1134 га буюу 3.6 хувийг шатсан талбай, 2009 га буюу 6.4 хувийг мод бэлтгэсэн талбай, 2712 га буюу 8.6 хувийг ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай тус тус эзэлж байна.

Ойн санг газрын төрлөөр ангилж бүдүүвч 2-оор үзүүлэв.

Бүдүүвч-2

Ойн сангийн талбай газрын төрлөөр ангилагдсан байдал



Ойгоор бүрхэгдсэн талбайг /175.656 га/ аймгийн нийт нутаг дэвсгэрийн талбайд /69.6 мян.км²/ харьцуулахад ойрхог чанар 2.5 хувь байна. Тухайн нутаг дэвсгэрийн 30-50 хувь ой модоор хучигдсан байвал экологийн тааламжтай орчин үүсдэг гэсэн дэлхий нийтийн жишиг байдаг.


Увс аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд ойн хэлбэр нь ихэвчлэн энгийн ой байх ба заримдаа хөгшин моддын доогуур залуу модод ташинга үүсгэж ургаснаас нийлмэл ой үүссэн байна. Ойн бүрэлдэхүүнд шинэсэн ой зонхилох бөгөөд голын дагуу бургас, улиас тархан ургана. Байгалийн ойд моддын төрлийн эзлэх хувийг авч үзвэл:

- Шинэс (*Larix sibirica* L) - 134612 га
- Хуш (*Pinus sibirica*) - 1336 га
- Гацуур (*Picea obovata*) - 195 га
- Хус (*Betula platyphylla* Sukacz) - 987 га
- Улиас (*Populus Laurifolia*) - 9063 га
- Хайлаас (*Ulmus pumila*) - 22 га
- Бургас (*Sallix* sp) - 27378 га талбайд тархан ургаж байна.

Ойн сангийн талбайг хэсэглэл тус бүрээр гаргаж төсөлд хавсаргав. Хэсэглэлүүдийн доторх ялгарлын талбай, нөөц болон таксацын бусад үзүүлэлтүүдийг тухайн сумын “Таксацын бичлэг”-ээс, модны төрөл, тархалтыг “Ойн тархалтын зураг”-аас үзэх боломжтой. Байгалийн ойд модны төрөл тус бүрийн эзлэх хувь хэмжээг 1-р графикаар харуулав.

График-1

Байгалийн ойд модны төрөл тус бүрийн эзлэх хувь



Увс аймгийн ойн санд шинэсэн ой хамгийн их буюу 77.5 хувийг эзэлж байгаа бол хуш 0.8 хувь, гацуур 0.1 хувь, хус 0.6 хувь, улиас 5.2 хувь, хайлаас 0.01 хувь, бургас 15.8 хувийг тус тус эзэлж байна.

Увс аймгийн ойн санд зонхилон тархсан моддын товч тодорхойлолтыг оруулав.

Сибирь шинэс (*Larix sibirica* Ledb)



| Торлог | | 2027 | | 2027 | | | | | | | | 2027 |
| Бургас | 27378 | | | 27378 | | 8496 | | | | | 8496 | 35874 |
| Дүн | 173593 | 2027 | 36 | 175656 | 1134 | 25681 | 2009 | | | 2712 | 31536 | 207192 |

Тайлбар: ХШӨН-хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, МБТ – Мод бэлтгэсэн талбай


2.9. Ойн сангийн экологи-эдийн засгийн үнэлгээ

Ойн сангийн зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилгод нийцүүлэн түүнд экологи-эдийн засгийн үнэлгээ өгдөг. Ойн нөөцийн экологи эдийн засгийн үнэлгээ нь Монгол улсын “Ойн тухай” хууль, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хуулийн зорилгод нийцэн ойн нөөцийн байгаль, аж ахуй, эдийн засгийн үндсийг тодорхойлдог ойн кадастрын нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь ойн нөөцийн шууд болон шууд бус ашиглалтын экологи, эдийн засгийн үр ашигт суурилдаг ба тэрээр ойн нөөцийн бүхэл ач холбогдолын мөнгөн илэрхийлэл юм.

Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ нь:

- Ойн модны нөөцийн үнэлгээ
- Ойн дагалт баялагийн үнэлгээ
- Ойн эдэлбэр газрын үнэлгээ
- Ойн хөрс, ус хамгаалах ашигт чанарын үнэлгээ
- Ойн биологийн төрөл зүйлийг хамгаалах ач холбогдолын үнэлгээ
- Ойн нүүрстөрөгчийн хийг шингээх ач холбогдлын үнэлгээ
- Ойн амралт, аялал жуулчлал, нийгмийн ач холбогдлын үнэлгээ зэргээс бүрдэнэ.



Зураг-9. Ойн эдийн засаг, нийгэм, экологийн ач холбогдол

Ойн нөхөн сэргээх зардал, модон материалын хэрэглээ, нийлүүлэлтийн өртөг, үнэ, рент, дагалт баялагийн ашиглалт, ойн хөрс, ус хамгаалах, агаарыг цэвэршүүлэх ач холбогдлын зэрэгцээ, ойн нөөцийн хомсдол, доройтол зэрэг нь ойн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох, шинэчлэх суурь нөхцөл болдог.

Аливаа зүйлийг мөнгөн дүнгээр тооцож үнэлэх нь илүү ойлгомжтой байх ба ямар үнэтэй баялаг болохыг ойлгоход дөхөмтэй байдаг.

Ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг дараах зориулалтаар ашиглана.

1. Улсын ойн нөөцийг мөнгөн дүнгээр илэрхийлж үндэсний баялагт бүртгэх
2. Ойн нөөцийн хомсдолын түвшинд өртгийн үнэлгээ өгч, салбарын макро эдийн засгийн болон тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэн тооцох
3. Ойн нөөцийн ашиглалтын төлбөр, нөхөн төлбөрийн тарифыг үндэслэлтэй тогтоох
4. Ойн нөөцийг түрээслэх, эзэмшүүлэх нөхцөлд түрээсийн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл болгох
5. Ойн нөөцөд учирсан төрөл бүрийн хохирлын хэмжээг тооцох
6. Ойн нөөцийн эзэмших газрыг ойн аж ахуйн бус зориулалтаар (хөдөө аж ахуй, аж үйлдвэр, барилга, зам г.м.) олгох өртөг үр ашгийг тооцоход ашиглах
7. Ой зохион байгуулалтын ажлын үндэслэлийг дээшлүүлэх зэрэг болно.

Увс аймгийн ойн сангийн экологи-эдийн засгийн үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны 325-р тушаалын хавсралтад заасны дагуу хамгаалалтын бүсийн ойг I муж, ашиглалтын бүсийн ойг II мужид хамааруулж Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2020 оны 03-р сарын 16-ний өдрийн А/176 дугаар тушаалын 1,2,3 дугаар хавсралтаар баталсан үнэлгээгээр тооцож тогтоов.

Ойгоор бүрхэгдсэн талбайн экологи-эдийн засгийн үнэлгээг 15-р хүснэгтээр, ойгоор бүрхэгдээгүй талбайн экологи эдийн засгийн үнэлгээг 16-р хүснэгтээр, ойн талбайн экологи эдийн засгийн үнэлгээг 17-р хүснэгтээр тус тус үзүүлэв.

Ойн экологи эдийн засгийн үнэлгээг тооцохдоо шууд үр ашгийн болон шууд бус үр ашгийн гэсэн ангиллаар тооцож үнэлэв.

Шууд үр ашиг гэсэн ангилалд ойн нөөц, ойн дагалт баялгийн үнэлгээг тооцдог бол шууд бус үр ашгийн ангиллаар ойн ус зохицуулах, хөрс хамгаалах, нүүрстөрөгчийн хийг шингээх, нийгэм, амралт зугаалгын ач холбогдлын үнэлгээг тооцно.

Шууд болон шууд бус үр ашгийн үнэлгээний нийлбэр хамаарал нь ойн экологи эдийн засгийн үнэлгээ болно.

Ойгоор бүрхэгдсэн талбайн экологи-эдийн засгийн үнэлгээ

| Анги-лал | Модны төрөл | Нэгдүгээр муж | | | Хоёрдугаар муж | | | Нийт | |
|--------------------|---------------|-----------------|-----------------------------|-----------------------------|-----------------|---------------------------|---------------------|-----------------------------|-----------------------------|
| | | Ойн талбай (га) | 1 га-н үнэлгээ (төг) | Дүн төг | Ойн талбай (га) | 1 га-н үнэлгээ (төг) | Дүн (төг) | Ойн талбай (га) | Үнэлгээ (төг) |
| Шууд үр ашгийн | Шинэс | 118946 | 33,983,181.00 | 4,042,163,447,226.00 | 15666 | 22,336,363.00 | 349,921,462,758.00 | 134612 | 4,392,084,909,984.00 |
| | Хуш | 1336 | 56,000,453.00 | 74,816,605,208.00 | | 36,854,999.00 | | 1336 | 74,816,605,208.00 |
| | Гацуур | 195 | 49,139,999.00 | 9,582,299,805.00 | | 32,387,726.00 | | 195 | 9,582,299,805.00 |
| | Хус | 987 | 14,837,727.00 | 14,644,836,549.00 | | 6,860,454.00 | | 987 | 14,644,836,549.00 |
| | Улиас | 9099 | 11,168,182.00 | 101,619,288,018.00 | | 5,265,000.00 | | 9099 | 101,619,288,018.00 |
| | Хайлаас | 22 | 13,242,272.00 | 291,329,984.00 | | 8,775,000.00 | | 22 | 291,329,984.00 |
| | Бургас | 27378 | 7,179,545.00 | 196,561,583,010.00 | | 3,510,000.00 | | 27378 | 196,561,583,010.00 |
| | Торлог | 2017 | 2,233,636.00 | 4,505,243,812.00 | 10 | 1,435,909.00 | | 2027 | 4,505,243,812.00 |
| | дүн | 159980 | | 4,444,184,633,612.00 | 15666 | | 349921462758 | 175656 | 4,794,106,096,370.00 |
| Шууд бус үр ашгийн | Шинэс | 118946 | 43,566,383.00 | 5,182,046,992,318.00 | 15666 | 28,635,181.00 | 448,598,745,546.00 | 134612 | 5630645737864 |
| | Хуш | 1336 | 71,792,491.00 | 95,914,767,976.00 | | 47,248,049.00 | | 1336 | 95914767976 |
| | Гацуур | 195 | 62,997,399.00 | 12,284,492,805.00 | | 41,521,013.00 | | 195 | 12284492805 |
| | Хус | 987 | 19,021,942.00 | 18,774,656,754.00 | | 8,795,091.00 | - | 987 | 18774656754 |
| | Улиас | 9099 | 14,317,591.00 | 130,275,760,509.00 | | 6,749,721.00 | - | 9099 | 130275760509 |
| | Хайлаас | 22 | 16,976,572.00 | 373,484,584.00 | | 11,249,536.00 | | 22 | 373484584 |
| | Бургас | 27378 | 9,204,165.00 | 251,991,629,370.00 | | 4,499,814.00 | - | 27378 | 251991629370 |
| | Торлог | 2017 | 2,863,518.00 | 5,775,715,806.00 | 10 | 1,840,833.00 | | 2027 | 5775715806 |
| дүн | 159980 | | 5,697,437,500,122.00 | 15676 | | 448,598,745,546.00 | 175656 | 6,146,036,245,668.00 | |
| Нийт үнэлгээ | Шинэс | 118946 | 77,549,564 | 9,224,210,439,544.00 | 15666 | 50,971,544 | 798,520,208,304.00 | 134612 | 10,022,730,647,848.00 |
| | Хуш | 1336 | 127,792,944 | 170,731,373,184.00 | | 84,103,048.00 | | 1336 | 170,731,373,184.00 |
| | Гацуур | 195 | 112,137,398 | 21,866,792,610.00 | | 73,908,739.00 | | 195 | 21,866,792,610.00 |
| | Хус | 987 | 33,859,669 | 33,419,493,303.00 | | 15,655,545.00 | | 987 | 33,419,493,303.00 |
| | Улиас | 9099 | 25,485,773 | 231,895,048,527.00 | | 12,014,721.00 | | 9099 | 231,895,048,527.00 |
| | Хайлаас | 22 | 30,218,844 | 664,814,568.00 | | 20,024,536.00 | | 22 | 664,814,568.00 |
| | Бургас | 27378 | 16,383,710 | 448,553,212,380.00 | | 8,009,814.00 | | 27378 | 448,553,212,380.00 |

| | | | | | | | | |
|--------|---------------|-----------|------------------------------|--------------|--------------|---------------------------|---------------|------------------------------|
| Торлог | 2017 | 5,097,154 | 10,280,959,618.00 | 10 | 3,276,742.00 | | 2027 | 10,280,959,618.00 |
| дүн | 159980 | | 10,141,622,133,734.00 | 15676 | | 798,520,208,304.00 | 175656 | 10,940,142,342,038.00 |

Увс аймгийн ойгоор бүрхэгдсэн талбайн шууд үр ашгийн (ойн нөөц, ойн дагалт баялгийн үнэлгээ) экологи эдийн засгийн үнэлгээ **4 794 106 096 370** (Дөрвөн их наяд, долоон зуун ерэн дөрвөн тэрбум нэг зуун зургаан сая ерэн зургаан мянга гурван зуун далан) төгрөг.

Ойгоор бүрхэгдсэн талбайн шууд бус үр ашгийн (ойн ус зохицуулах, хөрс хамгаалах, нүүрсхүчлийн хийг шингээх, нийгэм, амралт зугаалгын ач холбогдол зэрэг экологийн ач холбогдлын үнэлгээ) экологи эдийн засгийн үнэлгээ нь **6 146 036 245 668** (Зургаан их наяд нэг зуун дөчин зургаан тэрбум гучин зургаан сая хоёр зуун дөчин таван мянга зургаан зуун жаран найм) төгрөг.

Увс аймгийн ойгоор бүрхэгдсэн талбайн нийт экологи эдийн засгийн үнэлгээ **10 940 142 342 038** (Арван их наяд есөн зуун дөчин тэрбум нэг зуун дөчин хоёр сая гурван зуун дөчин хоёр мянга гучин найман) төгрөгөөр үнэлэгдэж байна.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн экологи эдийн засгийн үнэлгээ (төгрөг)

| Ангилал | Газрын төрөл | Хамгаалалтын бүс-Нэгдүгээр муж | | | Ашиглалтын бүс-Хоёрдугаар муж | | | Нийт | |
|--------------------|----------------------|--------------------------------|----------------------------|---------------------------|-------------------------------|----------------------------|-------------------------|--------------|---------------------------|
| | | Талбай (га) | 1 га талбайн үнэлгээ (төг) | Үнэлгээ (төг) | Талбай (га) | 1 га талбайн үнэлгээ (төг) | Үнэлгээ (төг) | Талбай (га) | Үнэлгээ (төг) |
| Шууд үр ашгийн | Тармаг мод | 24994 | 13,593,272.00 | 339,750,240,368.00 | 687 | 8,934,545.00 | 6,138,032,415.00 | 25681 | 345,888,272,783.00 |
| | Шатсан талбай | 1104 | 10,147,091.00 | 11,202,388,464.00 | 30 | 6,700,909.00 | 201,027,270.00 | 1134 | 11,403,415,734.00 |
| | Мод бэлтгэсэн талбай | 1850 | 9,062,182.00 | 16,765,036,700.00 | 159 | 5,935,091.00 | 943,679,469.00 | 2009 | 17,708,716,169.00 |
| | ХШӨН талбай | 2685 | 11,295,818.00 | 30,329,271,330.00 | 27 | 7,466,727.00 | 201,601,629.00 | 2712 | 30,530,872,959.00 |
| | Дүн | 30633 | | 398,046,936,862.00 | 903 | | 7,484,340,783.00 | 31536 | 405,531,277,645.00 |
| Шууд бус үр ашгийн | Тармаг мод | 24994 | 17,426,553.00 | 435,559,265,682.00 | 687 | 11,454,073.00 | 7,868,948,151.00 | 25681 | 443,428,213,833.00 |
| | Шатсан талбай | 1104 | 13,008,554.00 | 14,361,443,616.00 | 30 | 8,590,554.00 | 257,716,620.00 | 1134 | 14,619,160,236.00 |
| | Мод бэлтгэсэн талбай | 1850 | 11,617,702.00 | 21,492,748,700.00 | 159 | 7,608,777.00 | 1,209,795,543.00 | 2009 | 22,702,544,243.00 |
| | ХШӨН талбай | 2685 | 14,481,220.00 | 38,882,075,700.00 | 27 | 9,572,332.00 | 258,452,964.00 | 2712 | 39,140,528,664.00 |
| | Дүн | 30633 | | 471,413,457,998.00 | 903 | | 9,336,460,314.00 | 31536 | 519,890,446,976.00 |
| Нийт | Тармаг мод | 24994 | 31,019,825.00 | 775,309,506,050.00 | 687 | 20,388,618.00 | 14,006,980,566.00 | 25681 | 789,316,486,616.00 |
| | Шатсан талбай | 1104 | 23,155,645.00 | 25,563,832,080.00 | 30 | 15,291,463.00 | 458,743,890.00 | 1134 | 26,022,575,970.00 |
| | Мод бэлтгэсэн талбай | 1850 | 20,679,884.00 | 38,257,785,400.00 | 159 | 13,543,868.00 | 2,153,475,012.00 | 2009 | 40,411,260,412.00 |
| | ХШӨН талбай | 2685 | 25,777,038.00 | 69,211,347,030.00 | 27 | 17,039,059.00 | 460,054,593.00 | 2712 | 69,671,401,623.00 |
| | Дүн | 30633 | | 839,131,123,530.00 | 903 | | 16619199468 | 31536 | 925,421,724,621.00 |

Ойгоор бүрхэгдээгүй талбайн шууд үр ашгийн (ойн нөөц, ойн дагалт баялгийн үнэлгээ) экологи эдийн засгийн үнэлгээ) **405 531 277 645** (Дөрвөн зуун таван тэрбум таван зуун гучин нэгэн сая хоёр зуун далан долоон мянга зургаан зуун дөчин тав) төгрөг.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн шууд бус үр ашгийн (ойн ус зохицуулах, хөрс хамгаалах, нүүрсхүчлийн хийг шингээх, нийгэм, амралт зугаалгын ач холбогдол зэрэг экологийн ач холбогдлын үнэлгээ) экологи эдийн засгийн үнэлгээ нь **519 890 446 976** (Таван зуун арван есөн тэрбум найман зуун ерэн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга есөн зуун далан зургаа) төгрөг.

Ойгоор бүрхэгдээгүй талбайн экологи эдийн засгийн үнэлгээ **925 421 724 621** (Есөн зуун хорин таван тэрбум дөрвөн зуун хорин нэгэн сая долоон зуун хорин дөрвөн мянга зургаан зуун хорин нэг) төгрөг болж байна.

Ойн талбайн экологи эдийн засгийн үнэлгээ

| Ангилал | Ойгоор бүрхэгдсэн талбай (төгрөг) | Ойгоор бүрхэгдээгүй талбай (төгрөг) | Нийт үнэлгээ (төгрөг) |
|--------------------|--------------------------------------|--|--------------------------|
| Шууд үр ашгийн | 4,794,106,096,370.00 | 405,531,277,645.00 | 5,199,637,374,015.00 |
| Шууд бус үр ашгийн | 6,146,036,245,668.00 | 519,890,446,976.00 | 6,665,926,692,644.00 |
| Нийт | 10,940,142,342,038.00 | 925,421,724,621.00 | 11,865,564,066,659.00 |

Ойн талбайн шууд үр ашгийн үнэлгээ нь **5 199 637 374 015** (Таван их наяд нэг зуун ерэн есөн тэрбум зургаан зуун гучин долоон сая гурван зуун далан дөрвөн мянга арван тав) төгрөг.

Ойн талбайн шууд бус үр ашгийн үнэлгээ **6 665 926 692 644** (Зургаан их наяд зургаан зуун жаран таван тэрбум есөн зуун хорин зургаан сая зургаан зуун ерэн хоёр мянга зургаан зуун дөчин дөрөв) төгрөг.

Увс аймгийн ойн талбайн экологи эдийн засгийн үнэлгээг ойгоор бүрхэгдсэн талбай болон ойгоор бүрхэгдээгүй талбайн нийлбэрээр тооцож үнэлбэл нийт үнэлгээ нь **11 865 564 066 659** (Арван нэгэн их наяд найман зуун жаран таван тэрбум таван зуун жаран дөрвөн сая жаран зургаан мянга зургаан зуун тавин ес) төгрөг болж байна.

Ойн сангийн экологи эдийн засгийн үнэлгээг талбайгаар тооцохоос гадна мөн ойн нөөцөөр тооцож боддог. Увс аймгийн ойн сангийн байгалийн ойн нөөцийн шууд үр ашгийн үнэлгээ **4 141 729 612 834** (Дөрвөн их наяд нэг зуун дөчин нэгэн тэрбум, долоон зуун хорин есөн мянга зургаан зуун арван хоёр мянга найман зуун гучин дөрөв) төгрөг.

Байгалийн ойн нөөцийн шууд бус үр ашгийн үнэлгээ **5 309 643 089 308** (Таван их наяд гурван зуун есөн тэрбум зургаан зуун дөчин гурван сая наян есөн мянга гурван зуун найман) төгрөг.

Увс аймгийн байгалийн ойн нөөцийн нийт экологи эдийн засгийн үнэлгээ **9 451 372 702 142** (Есөн их наяд дөрвөн зуун тавин нэгэн тэрбум гурван зуун далан хоёр сая долоон зуун хоёр мянга нэг зуун дөчин хоёр) төгрөг болж байна.

Увс аймгийн ойн нөөцийн экологи эдийн засгийн үнэлгээг 18-р хүснэгтээр үзүүлэв.

Ойн нөөцийн экологи эдийн засгийн үнэлгээ (төгрөг)

| Модны төрөл | Хамгаалалтын бүс-Нэгдүгээр муж | | | Ашиглалтын бүс-Хоёрдугаар муж | | | Нийт | |
|----------------|--------------------------------|---|-----------------------------|-------------------------------|---|--------------------------|-------------------------------|-----------------------------|
| | Ойн нөөц (м ³) | 1 м ³ -н үнэлгээ (төг) | Дүн (төг) | Ойн нөөц (м ³) | 1 м ³ -н үнэлгээ (төг) | Дүн (төг) | Ойн нөөц (м ³) | Үнэлгээ (төг) |
| Шинэс | 15481190 | 249,877.00 | 3,868,393,313,630.00 | 161892 | 161,892.00 | 26,209,019,664.00 | 15643082 | 3,894,602,333,294.00 |
| Хуш | 209690 | 411,769.00 | 86,343,841,610.00 | | 266,301.00 | | 209690 | 86,343,841,610.00 |
| Гацуур | 21270 | 374,228.00 | 7,959,829,560.00 | | 245,184.00 | | 21270 | 7,959,829,560.00 |
| Хус | 29850 | 146,641.00 | 4,377,233,850.00 | | 95,024.00 | - | 29850 | 4,377,233,850.00 |
| Улиас | 594790 | 124,352.00 | 73,963,326,080.00 | | 80,946.00 | - | 594790 | 73,963,326,080.00 |
| Хайлаас | 880 | 172,450.00 | 151,756,000.00 | | 113,794.00 | | 880 | 151,756,000.00 |
| Бургас | 674060 | 110,274.00 | 74,331,292,440.00 | | 73,907.00 | - | 674060 | 74,331,292,440.00 |
| Дүн | 17011730 | | 4,115,520,593,170.00 | 161892 | | 26,209,019,664.00 | 17173622 | 4,141,729,612,834.00 |
| Шинэс | 15481190 | 320,339.00 | 4,959,228,923,410.00 | 161892 | 207,544.00 | 33,599,713,248.00 | 15643082 | 4,992,828,636,658.00 |
| Хуш | 209690 | 527,883.00 | 110,691,786,270.00 | | 341,394.00 | | 209690 | 110,691,786,270.00 |
| Гацуур | 21270 | 479,757.00 | 10,204,431,390.00 | | 314,323.00 | | 21270 | 10,204,431,390.00 |
| Хус | 29850 | 187,993.00 | 5,611,591,050.00 | | 121,819.00 | - | 29850 | 5,611,591,050.00 |
| Улиас | 594790 | 159,418.00 | 94,820,232,220.00 | | 103,772.00 | - | 594790 | 94,820,232,220.00 |
| Хайлаас | 880 | 221,079.00 | 194,549,520.00 | | 145,882.00 | | 880 | 194,549,520.00 |
| Бургас | 674060 | 141,370.00 | 95,291,862,200.00 | | 94,748.00 | - | 674060 | 95,291,862,200.00 |
| Дүн | 17011730 | | 5,276,043,376,060.00 | 161892 | | 33,599,713,248.00 | 17173622 | 5,309,643,089,308.00 |
| Шинэс | 15481190 | 570,216.00 | 8,827,622,237,040.00 | 161892 | 369,436.00 | 59,808,732,912.00 | 15643082 | 8,887,430,969,952.00 |
| Хуш | 209690 | 939,652.00 | 197,035,627,880.00 | | 607,695.00 | | 209690 | 197,035,627,880.00 |
| Гацуур | 21270 | 853,985.00 | 18,164,260,950.00 | | 559,507.00 | | 21270 | 18,164,260,950.00 |
| Хус | 29850 | 334,634.00 | 9,988,824,900.00 | | 216,843.00 | - | 29850 | 9,988,824,900.00 |
| Улиас | 594790 | 283,770.00 | 168,783,558,300.00 | | 184,718.00 | - | 594790 | 168,783,558,300.00 |
| Хайлаас | 880 | 393,529.00 | 346,305,520.00 | | 259,676.00 | | 880 | 346,305,520.00 |

| | | | | | | | | |
|---------------|-----------------|------------|-----------------------------|---------------|------------|--------------------------|-----------------|-----------------------------|
| Бургас | 674060 | 251,644.00 | 169,623,154,640.00 | | 168,655.00 | - | 674060 | 169,623,154,640.00 |
| Дүн | 17011730 | | 9,391,563,969,230.00 | 161892 | | 59,808,732,912.00 | 17173622 | 9,451,372,702,142.00 |

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОЙН САНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн ойг бууруулах өөрчлөлт оруулахад ойн түймэр, эмх замбараагүй хийгддэг мод бэлтгэл, ойн хортон шавжийн үржил, тархалт мөн бэлчээрийн малын нөлөө зэрэг хүчин зүйл голлон нөлөөлж байдаг.

Үүний зэрэгцээ уур амьсгалын хуурайшилт, дулааралт нь ойн нөөцийг аажмаар багасгахад хүргэж буй байгалийн хүчин зүйлийн нэг болж байна. Байгалийн хүчин зүйлээс гадна хүний сөрөг үйл ажиллагааны нөлөөллөөс ойн нөөц хомсдож, ойн чанар, чансаа улам буурсаар байна.

Монгол улс нь ойн баялгаар ядмаг орны тоонд орох бөгөөд ойн сангийн хувирал, өөрчлөлт, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйл, цаашдын хандлагыг тухай бүр тогтоож байх нь ойн баялгийг зүй зохистой ашиглахад чухал ач холбогдолтой.

Ой зохион байгуулалтын ажлын нэг зорилго нь тухайн газар нутгийн ойн сангийн төлөв байдал, талбай, тархалтыг тогтоож түүнд гарсан өөрчлөлт түүний шалтгааныг тооцож цаашид хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг оновчтой төлөвлөх явдал юм.

3.1. Ойн сангийн талбайн газрын төрлийн өөрчлөлт

Ойн сангийн өөрчлөлтийг гаргахдаа 2011 оны ой зохион байгуулалтын ажлын дүн мэдээг 2020 оны давтан ой зохион байгуулалтын ажлын дүн мэдээтэй харьцуулан газрын төрлийн ангиллыг 19-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-19

Ойн сангийн газрын төрлийн өөрчлөлт

| Ойн сангийн талбайн төрөл | Газрын төрөл | 2011 оны ой зохион байгуулалт | 2020 оны ой зохион байгуулалт | Зөрүү |
|----------------------------|--------------------|-------------------------------|-------------------------------|---------------|
| Ойгоор бүрхэгдсэн талбай | Байгалийн ой | 197347 | 173593 | -23754 |
| | Сөөг торлог | 3552 | 2027 | -1525 |
| | Таримал ой | 30 | 36 | 6 |
| | Дүн | 200929 | 175656 | -25273 |
| Ойгоор бүрхэгдээгүй талбай | Тармаг мод | 26678 | 25681 | -997 |
| | Түймэрт нэрвэгдсэн | 2042 | 1134 | -908 |
| | Мод бэлтгэсэн | 1971 | 2009 | 38 |
| | Ойжиж буй | 629 | | -629 |
| | ХШӨН | 26 | 2,712 | 2686 |
| | Дүн | 31346 | 31536 | 190 |
| Ойн талбайн дүн | | 232275 | 207192 | -25083 |
| Ойн бус талбайн | Цагаан энгэр | 4353 | 3168 | -1185 |
| | МҮГ | 1 | 1 | 0 |
| | Таг царам | | 46 | 46 |
| Ойн бус талбайн дүн | | 4,354 | 3,215 | -1139 |
| Ойн сангийн талбай | | 236629 | 210407 | -26222 |


Увс аймгийн ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн газрын төрлийн өөрчлөлтийг 8-р график, ойгоор бүрхэгдээгүй талбайн газрын төрлийн өөрчлөлтийг 9-р графикаар харуулав.

График-8.



Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн газрын төрлийн өөрчлөлтийн хүснэгтээс харахад байгалийн ой 23754 га, бут, сөөг 1525 га талбайгаар тус тус багассан бол таримал ой 6 га талбайгаар нэмэгдэж ойгоор бүрхэгдсэн талбай 25273 га талбайгаар багассан байна.

График-9.




Ойгоор бүрхэгдээгүй талбайн ангилалд тармаг мод 997 га, шатсан талбай 908 га, ойжиж буй талбай 629 га талбайгаар тус тус багассан бол мод бэлтгэсэн талбай 38 га, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай 2686 га талбайгаар нэмэгдсэнээр ойгоор бүрхэгдээгүй талбай 190 га талбайгаар нэмэгдсэн байна.

Увс аймгийн ойн сангийн ангиллын төрлийн өөрчлөлтийг 10-р графикаар харуулав.

График-10

Ойн сангийн талбайн ангиллын өөрчлөлт



Ойн сангийн ангиллын өөрчлөлтийг харуулсан графикаас харахад ойгоор бүрхэгдсэн талбай 25273 га талбайгаар багассан бол ойгоор бүрхэгдээгүй талбай 190 га талбайгаар нэмэгдсэнээр ойн талбай 25083 га талбайгаар багассан үзүүлэлттэй байна.

Харин ойн бус талбайн ангилалд цагаан энгэр 1185 га талбайгаар багассан бол таг царам 46 га талбайгаар нэмэгдсэнээр ойойн бус талбай 1139 га талбайгаар хасагдсан байна.


Ойн талбай 25083 га, ойн бус талбай 1139 га талбайгаар тус тус багассанаар ойн сангийн талбай нийт дүнгээрээ 26222 га талбайгаар багассан үзүүлэлттэй гарсан байна.

Ойн бус талбайн хэмжээ буурсан шалтгаан нь ойн сангийн газрын төрлийн ангиллын дагуу зөвхөн ой дотор байгаа том хэмжээний цагаан энгэр болон цаг царам, ойн цоорхойг бүртгэж тал хээртэй хил залгаа том хэмжээний цагаан энгэрийг ойн сангаас хасаж тооцсонтой холбоотой юм.

Увс аймгийн ойн санд хийгдсэн ой зохион байгуулалтын бэлтгэл ажил, материал боловсруулалтын зураглалын ажлыг Засгийн газрын 2009.01.28-ны “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” 25-р тогтоолын дагуу Олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATER) тусгагийг хэрэглэж тодорхойлж, олон цаг хугацааны орон зайн утга бүхий сансрын зурагт тайлал тодруулалтын ажлыг гүйцэтгэсэнээр ойн сангийн өөрчлөлтийг нарийвчлан гаргах нөхцөл бүрдсэнээр дараахь ажилбаруудыг хийв.


- Үүнд: Увс аймгийн ойн сангийн нийт талбай 26222 га талбайгаар багасаж гарсан бөгөөд өмнөх оны ой золхион байгуулалтын ажлаар газрын налуу ихтэй сүүдэр туссан хэсэг, ойн цоорхой буюу ойгүй талбайг ойн талбайн ангиллаар бүртгэж авсан 11023 га бүхий 747 ялгарлыг ойн талбайгаас хасаж тооцов.
- Ойн сангийн талбайд бүртгэгдээгүй орхигдсон 5946 га талбай бүхий 895 ялгарлыг ойн санд шинээр бүртгэж авсан.
- Өмнөх оны ой зохион байгуулалтын 203661 га талбайг хамарсан 12421 ялгаралд орон зайн засвар хийв.
- Ойн санд бүртгэгдээгүй Завхан, Өмнөговь сумдын ойн санг шинээр бүртгэж авсан.
- Зургийн проекцын зөрүүг засварласнаар 15999 га ойн талбай багасаж гарсан.

Дээрх шалтгаанууд нь ойн сангийн талбайд гарсан өөрчлөлтөд гол нөлөө үзүүлж байгаа бөгөөд үүнээс өөр нэг шалтгаан бол ой зохион байгуулалтын ажлын суурь зурагт нарийвчлал өндөртэй хиймэл дагуулын мэдээ ашиглан ойн хил хязгаарыг илүү бодитой тогтоосон явдал юм. Үүнээс үүдэж ойн сангийн талбайд ихээхэн хэмжээний өөрчлөлт гарч байна.




Ойн талбайд гарсан өөрчлөлтийн жишээг дараах зургуудаар тодруулж харуулав.


Зураг-10. Ойн талбайн хил хязгаарыг нарийвчлан зурсан байдал.




Зураг-11. Түргэн сумын ойн сангаас ойгүй талбай хасагдсан байдал




Зураг-12. Тэсийн голын дагуух ойн талбайн хил хязгаарыг нарийвчлан ялгав.



Зураг-13. Бөхмөрөн сум-ийн талбайн хил хязгаарыг бодитой тогтоов.



Зураг-14. Сагил сум-Ойн санд бүртгээгүй талбайг нэмж бүртгэв.



Зураг-15. Сагил сум-Ойгүй талбайг бүртгэсэн болон орхигдсон ойн талбайг шинээр бүртгэж авсан байдал.

Увс аймгийн ойн санд өөрчлөлт (хасагдсан болон шинээр нэмэгдсэн мөн проекцын засвар хийгдсэн) орсон шалтгааныг сум тус бүрээр гаргаж 20-р хүснэгтээр үзүүлэв.

Увс аймгийн ойн талбайн өөрчлөлт /сум тус бүрээр/

| д/д | Сум | Нийт талбай (га) | | Талбайн зөрүү (га) | Проекцын зөрүү (га) | Хасагдсан талбай | | Шинээр нэмэгдсэн | | Орон зайн засвар хийгдсэн (үндсэн) | | 2020 оны нийт дүн | | | |
|-----|---------------|------------------|---------------|--------------------|---------------------|--------------------|--------------|--------------------|-------------|------------------------------------|---------------|--------------------|---------------|--------------------|-------------|
| | | хуучин | шинэ | | | ялгарлын тоо (шир) | Талбай (га) | ялгарлын тоо (шир) | Талбай (га) | ялгарлын тоо (шир) | Талбай (га) | ялгарлын тоо (шир) | Талбай (га) | ялгарлын тоо (шир) | Талбай (га) |
| | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Баруунтуруун | 13440 | 12809 | -631 | 13 | 50 | 644 | 20 | 149 | 643 | 12660 | 663 | 12809 | | |
| 2 | Бөхмөрөн | 4455 | 3890 | -565 | -2 | 12 | 563 | 7 | 47 | 122 | 3843 | 129 | 3890 | | |
| 3 | Давст | 13424 | 11024 | -2400 | -1612 | 28 | 788 | 11 | 200 | 325 | 10824 | 336 | 11024 | | |
| 4 | Зүүнговь | 1231 | 401 | -830 | -291 | 30 | 539 | 1 | 1 | 25 | 400 | 26 | 401 | | |
| 5 | Зүүнхангай | 25011 | 23952 | -1059 | -649 | 63 | 410 | 45 | 147 | 1547 | 23805 | 1592 | 23952 | | |
| 6 | Малчин | 9097 | 7785 | -1312 | -876 | 69 | 436 | 69 | 244 | 930 | 7541 | 999 | 7785 | | |
| 7 | Наранбулаг | 6743 | 6831 | 88 | 232 | 30 | 144 | 11 | 49 | 1078 | 6782 | 1089 | 6831 | | |
| 8 | Өндөрхангай | 41697 | 40896 | -801 | -7 | 70 | 794 | 213 | 2197 | 2039 | 38699 | 2252 | 40896 | | |
| 9 | Сагил | 16949 | 15515 | -1434 | -579 | 72 | 855 | 29 | 344 | 901 | 15171 | 930 | 15515 | | |
| 10 | Тариалан | 2997 | 1833 | -1164 | -1138 | 5 | 26 | 11 | 103 | 197 | 1730 | 208 | 1833 | | |
| 11 | Түргэн | 18879 | 17296 | -1583 | -337 | 124 | 1246 | 140 | 651 | 1039 | 16645 | 1179 | 17296 | | |
| 12 | Тэс | 47629 | 31580 | -16049 | -12563 | 122 | 3486 | 9 | 157 | 1102 | 31423 | 1111 | 31580 | | |
| 13 | Ховд | 5045 | 4564 | -481 | 162 | 20 | 643 | 16 | 162 | 116 | 4402 | 132 | 4564 | | |
| 14 | Хяргас | 10102 | 10403 | 301 | 433 | 18 | 132 | 175 | 542 | 1010 | 9861 | 1185 | 10403 | | |
| 15 | Цагаанхайрхан | 15879 | 15377 | -502 | -232 | 28 | 270 | 43 | 171 | 1047 | 15206 | 1090 | 15377 | | |
| 16 | Улаангом | 4051 | 5451 | 1400 | 1447 | 6 | 47 | 95 | 782 | 300 | 4669 | 395 | 5451 | | |
| 17 | Завхан | | 6 | 6 | 6 | | | 3 | 6 | | | 3 | 6 | | |
| 18 | Өмнөговь | | 794 | 794 | 794 | | | 96 | 794 | | | 96 | 794 | | |
| | Нийт дүн | 236629 | 210407 | -26222 | -15999 | 747 | 11023 | 895 | 5946 | 12421 | 203661 | 13316 | 210407 | | |

3.2. Байгалийн ойн насны бүлгийн өөрчлөлт

Хүснэгт-21

Байгалийн ойн насны бүлгийн өөрчлөлт

| Модны төрөл | Ой зохион байгуулалт хийсэн он | Залуу ой | | Дунд насны ой | | Болц гүйцэж яваа ой | | Болц гүйцсэн, хөгшин ой | | Бүх дүн | |
|-------------|--------------------------------|----------|--------|---------------|---------|---------------------|---------|-------------------------|----------|---------|----------|
| | | талбай | нөөц | талбай | нөөц | талбай | нөөц | талбай | нөөц | талбай | нөөц |
| Шинэс | 2011 | 390 | 22070 | 11170 | 1229270 | 30139 | 3521860 | 99658 | 14131410 | 140967 | 18882540 |
| | 2020 | 2156 | 74930 | 15576 | 1524700 | 24642 | 2884670 | 92238 | 12967100 | 134612 | 17451400 |
| зөрүү | | 1766 | 52860 | 4406 | 295430 | -5497 | -637190 | -7420 | -1164310 | -6745 | -1453210 |
| Хуш | 2011 | | | 45 | 5800 | 1458 | 237200 | 24 | 6720 | 1527 | 249720 |
| | 2020 | 217 | 31470 | 135 | 16940 | 951 | 150390 | 33 | 10890 | 1336 | 209690 |
| зөрүү | | 217 | 31470 | 90 | 11140 | -507 | -86810 | 9 | 4170 | -191 | -40030 |
| Гацуур | 2011 | | | 86 | 7740 | 244 | 26330 | | | 330 | 34070 |
| | 2020 | | | | | 195 | 21270 | | | 195 | 21270 |
| зөрүү | | | | -86 | -7740 | -49 | -5060 | | | -135 | -12800 |
| Хус | 2011 | 68 | 1200 | 1208 | 40330 | 39 | 2590 | | | 1315 | 44120 |
| | 2020 | 71 | 1690 | 762 | 21590 | 44 | 2200 | 110 | 4370 | 987 | 29850 |
| зөрүү | | 3 | 490 | -446 | -18740 | 5 | -390 | 110 | 4370 | -328 | -14270 |
| Улиас | 2011 | 202 | 4040 | 5189 | 283370 | 1368 | 100880 | 4381 | 319040 | 11140 | 707330 |
| | 2020 | 142 | 3460 | 1759 | 84080 | 2659 | 157340 | 4503 | 349910 | 9063 | 594790 |
| зөрүү | | -60 | -580 | -3430 | -199290 | 1291 | 56460 | 122 | 30870 | -2077 | -112540 |
| Хайлаас | 2011 | | | | | | | | | 0 | 0 |
| | 2020 | | | 22 | 880 | | | | | 22 | 880 |
| Зөрүү | | | | 22 | 880 | | | | | 22 | 880 |
| Бургас | 2011 | 1970 | 25070 | 39708 | 996750 | | | | | 41678 | 1021820 |
| | 2020 | 1382 | 19590 | 25996 | 654470 | | | | | 27378 | 674060 |
| Зөрүү | | -588 | -5480 | -13712 | -342280 | | | | | -14300 | -347760 |
| Дүн | 2011 | 2630 | 52380 | 57406 | 2563260 | 33248 | 3888860 | 104063 | 14457170 | 197347 | 20961670 |
| | 2020 | 3968 | 131140 | 44250 | 2302660 | 28491 | 3215870 | 96884 | 13332270 | 173593 | 18981940 |
| Зөрүү | | 1338 | 78760 | -13156 | -260600 | -4757 | -672990 | -7179 | -1124900 | -23754 | -1979730 |

Насны бүлгийн өөрчлөлтийн хүснэгтээс харахад залуу ойн талбай, нөөц нэмэгдсэн бол дунд насны болон болц гүйцэж яваа ой мөн болц гүйцсэн хөгшин ойн талбай, нөөц буурсан үзүүлэлттэй байна.

Залуу ойн талбай 1338 га, нөөц 78760 шоо.метрээр нэмэгдсэн нь байгалийн аясаар тэлж ургах явц хэвийн байгааг харуулж байгаа бөгөөд тэлж ургасан ойн талбайг шинээр бүртгэж авсан явдал юм.

Бусад насны бүлгийн талбай, нөөц буурсан нь ойн түймэр, ойн хөнөөлт шавжийн нөлөөгөөр ойгоор бүрхэгдсэн талбай ойгоор бүрхэгдээгүй талбайн ангилалд шилжсэнээс гадна ойн сангийн нийт талбай буурсан үзүүлэлттэй шууд хамааралтай юм.

Байгалийн ойн талбай, нөөцийн хомсдол нь ойн түймэр, хууль бус мод бэлтгэл, ойн хөнөөлт шавж өвчний хөнөөлийн сөрөг нөлөө төдийгүй ойд хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээнүүд хийгдэхгүй байгааг харуулж байна. Нөгөө талаар сүүлийн жилүүдэд тохиолдож байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс болж ойн ургах орчин ихээхэн өөрчлөгдөж байгалийн сөрөг нөлөөллүүд ихэссэнтэй холбоотой.

Манай орны хувьд ойн экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн ойн үүрэг ач холбогдлыг бууруулж байгаа гол хүчин зүйлс нь дараах шалтгаанаас үүдэлтэй байдаг. Үүнд:

- Дэлхий нийтийг хамарсан уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, хуурайшилт
- Хүний болгоомжгүй үйлдлээс үүдэн гарч буй ойн түймэр
- Ойн хөнөөлт шавжийн хэт олшролын улмаас ойн санд учирч буй хор нөлөө
- Ойн санд хэрэгжүүлбэл зохих ойн аж ахуйн арга хэмжээ хийгддэггүй байдал
- Эмх замбараагүй мод бэлтгэл, хууль бус үйл ажиллагаа
- Бэлчээрийн хомсдолтой холбоотой ойн сан дахь мал бэлчээрлэлт зэрэг болно.

Ойн түймэр: Монгол орны ойд хавар, намрын улиралд гал түймэр гарах магадлал өндөр байдаг бөгөөд ой хээрийн түймэрт олон мянган га талбай өртөж доройтож байна.

Ойн хөнөөлт шавж, түүний нөлөө: Байгалийн ойд олон зүйл шавьж, мод өөр хоорондоо харилцан уялдаатай оршин амьдарч ойн экологийн тэнцвэрт байдалд эерэг, сөрөг нөлөө үүрэг гүйцэтгэдэг. Мод сөөгөөр хооллогч шавжийг дотор нь үр боргоцойгоор, нахиа найлзуураар, навч шилмүүсээр, иш холтосоор, үндсээр хооллогч гэсэн экологийн 5 бүлэгт хуваадаг. Эдгээр шавж нь хөгжлийн хүрэнцэрийн үе шатандаа навч, шилмүүсийг үгүйртэл идэж модыг физиологийн доройтолд хүргэдэг.

Бэлчээрийн мал аж ахуй: Малын тоо толгой хэт өсөж, бэлчээр ашиглалтын зохисгүй ажиллагаанаас бэлчээрийн даац хэтэрч, нөгөө талаар уул уурхай, барилга байгууламжийн үйл ажиллагааны улмаас бэлчээр нутаг хомсдох, уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж, бэлчээрийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй зэрэг олон шалтгааны улмаас ой бүхий газарт мал бэлчээрлэх явдал ихэссэн. Монгол улсын нийт мал сүргийн 28 хувь ой мод бүхий газар нутагт бэлчиж байна.

Хууль бус мод бэлтгэл: Ядуурал, ажилгүйдэл болон хяналт шалгалт хангалтгүй, торгууль шийтгэл бага байгаатай холбоотойгоор хууль бусаар мод бэлтгэж байгаа нь зарим газарт ойн нөөц ихээр хомсдоход хүргэж байна.

Дээрх нөхцөл байдал нь агаарын бохирдлыг бууруулж, хүлэмжийн хий гэгдэх нүүрсхүчлийн хийг шингээн хүчилтөрөгчийг ялгаруулж байдаг нандин орчин болсон ойн сан хөмрөг ихээр хумигдан ойн орчин доройтон бохирдож экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж байдаг. Увс аймгийн ойн сангийн байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтийг 22-р хүснэгтээр үзүүлэв.

3.3. Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт

Хүснэгт -22

Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт

| Ой зохион байгуулалт хийсэн он | Модны төрөл | Байгалийн ой (га) | Бүх нөөц (ш.м) | Б.Г.Х ойн талбай (га) | Б.Г.Х ойн нөөц (ш.м) | Бүх дундаж өсөлт (ш.м) | Бүх дундаж | | | Б.Г.Х ойн 1 га-н нөөц (ш.м) | Байгалийн ойн 1 га талбайн | |
|--------------------------------|-------------|-------------------|----------------|-----------------------|----------------------|------------------------|------------|---------|---------|-----------------------------|----------------------------|-------------|
| | | | | | | | нас (жил) | бонитет | өтгөрөл | | нөөц (ш.м) | өсөлт (ш.м) |
| 2011 | Шинэс | 141357 | 18904610 | 99658 | 14131410 | 142904 | 131.07 | 4.56 | 0.53 | 139.7 | 138.9 | 1.00 |
| 2020 | | 134612 | 17451400 | 92238 | 12967100 | 131868 | 132.3 | 4.5 | 0.53 | 140.6 | 129.6 | 1.0 |
| зөрүү | | -6745 | -1453210 | -7420 | -1164310 | -11036 | 1.27 | -0.07 | 0 | 0.94 | -9.27 | 0.0 |
| 2011 | Хуш | 1527 | 249720 | 24 | 6720 | 1817 | 144.75 | 4.52 | 0.57 | 56.00 | 172.79 | 1.15 |
| 2020 | | 1336 | 209690 | 33 | 10890 | 1681 | 124.73 | 4.64 | 0.60 | 330.00 | 157.0 | 1.3 |
| зөрүү | | -191 | -40030 | 9 | 4170 | -136 | -20.02 | 0.12 | 0.03 | 274 | -15.79 | 0.2 |
| 2011 | Гацуур | 330 | 34070 | | | 322 | 108.28 | 4.50 | 0.55 | | 102.00 | 1.1 |
| 2020 | | 195 | 21270 | | | 193 | 110.00 | 4.72 | 0.53 | | 109.1 | 1.0 |
| зөрүү | | -135 | -12800 | | | -129 | 1.72 | 0.22 | -0.02 | | 7.1 | -0.1 |
| 2011 | Хус | 1315 | 44120 | | | 1284 | 31.54 | 4.8 | 0.47 | | 31 | 0.96 |
| 2020 | | 987 | 29850 | 110 | 4370 | 733 | 40.7 | 4.8 | 0.47 | 39.70 | 30.20 | 0.7 |
| зөрүү | | -328 | -14270 | 110 | 4370 | -551 | 9.17 | -0.03 | 0 | 39.7 | -0.8 | -0.26 |
| 2011 | Улиас | 11140 | 707330 | 4381 | 319040 | 12730 | 51.31 | 4.45 | 0.49 | 74.87 | 65 | 1.30 |
| 2020 | | 9063 | 594790 | 4503 | 349910 | 9159 | 64.9 | 4.38 | 0.49 | 77.7 | 65.6 | 1.0 |
| зөрүү | | -2077 | -112540 | 122 | 30870 | -3571 | 13.63 | -0.07 | 0 | 2.83 | 0.6 | -0.3 |
| 2011 | Хайлаас | | | | | | | | | | | |
| 2020 | | 22 | 880 | | | 25 | 35.0 | 4.0 | 0.30 | | 40.0 | 1.1 |
| зөрүү | | 22 | 880 | | | 25 | 35.0 | 4.0 | 0.30 | | 40 | 1.1 |
| 2011 | Бургас | 41678 | 1021820 | | | 41225 | 25.74 | 4.9 | 0.39 | | 21 | 0.99 |
| 2020 | | 27378 | 674060 | | | 26538 | 25.4 | 5.0 | 0.39 | | 25 | 1.0 |

| | | | | | | | | | | | | |
|--------------|-----|--------|----------|--------|----------|--------|-------|-------|------|-------|-------|-------|
| зөрүү | | -14300 | -347760 | | | -14687 | -0.34 | 0.1 | 0 | | 3.6 | 0.0 |
| 2011 | Дүн | 197347 | 20961670 | 104063 | 14457170 | 200282 | | 4.6 | 0.49 | 138.9 | 106.2 | 1.01 |
| 2020 | | 173593 | 18981940 | 96884 | 13332270 | 170198 | | 4.57 | 0.50 | 137.6 | 109.3 | 1.0 |
| зөрүү | | -23754 | -1979730 | -7179 | -1124900 | -30084 | | -0.05 | 0.01 | -1.32 | 3.09 | -0.01 |

Тайлбар: Б.Г.Х-болц гүйцсэн, хөгшин

Увс аймгийн ойн сангийн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтийн хүснэгтээс харахад байгалийн ойн талбай 23754 га талбайгаар, нөөц 1979730 шоо.метрээр буурсан байна. Энэ нь ойн бүтээмж буурч байгааг харуулж байна.

Бүх дундаж өсөлт шилмүүст ойд 11301 шоо.метрээр, навчит ойд 18784 шоо.метрээр нийт 30084 шоо.метрээр багассан байна.

Болц гүйцсэн хөгшин шилмүүст ойн 1 га-н нөөц 274.9 шоо.метр, навчит ойн нөөц 42.5 шоо.метрээр нэмэгдэж, нийт дүнгээр аймгийн хэмжээнд 3.09 шоо.метрээр буурсан байна.

Байгалийн ойн 1 га шилмүүст ойн нөөц 17.9 шоо.метрээр буурсан бол навчит ойн нөөц 43.4 шоо.метрээр нэмэгдсэн ба аймгийн хэмжээгээр нийт 3.08 шоо.метрээр өссөн байна. Байгалийн ойн 1 га талбайн өсөлт 0.01 шоо метрээр багассан үзүүлэлттэй байна.

Таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтөнд байгалийн ойн талбайн өөрчлөлт ихээхэн нөлөөлж байгаагаас гадна ой зохион байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн арга зүй ихээхэн нөлөөлж байна. Ой зохион байгуулалтын ажлыг өмнө нь нүдэн баримжаагаар үнэлж таксацын дундаж үзүүлэлтүүдийг тогтоож байсан бол энэ удаагийн ой зохион байгуулалтын ажлаар дээж талбайн хэмжилтэд тулгуурлан ойн таксацын үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоосон нь таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтөд томоохон нөлөө үзүүлж байна.

Таксацын дундаж үзүүлэлтүүд багасаж гарах өөр нэг нөхцөлд бол ойн түймэр, хөнөөлт шавжийн сөрөг нөлөө мөн ойн аж ахуйн арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүлдэггүй зэрэг шалтгаанууд орно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОЙН САНГИЙН ҮНДСЭН АШИГЛАЛТ

4.1. Ашиглалтын бүсийн ойн сан

Ойн сангаас зохих журам, заавар, стандартын дагуу ойн баялгийн даацад тохируулан мод, ойн дагалт баялгийг бэлтгэх үйл ажиллагааг ойг ашиглах гэж ойлгох бөгөөд ойн баялаг гэж ойн модны нөөц, түүний дагалт баялгийн нөөцийг хэлнэ. Ашиглах нөөц гэж ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгөөр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээг хэлнэ. Ойд үндсэн ашиглалтын хэлбэрийг зөвхөн ашиглалтын бүсийн ойн санд хэрэгжүүлнэ.

Увс аймгийн ашиглалтын бүсийг тогтоохдоо “Ойн тухай” хуулийн 9-р зүйлийн 1 дэх заалтыг баримтлан тогтоов. Увс аймгийн ой бүхий сумдаас Зүүнхангай, Малчин, Түргэн сумдын ойн санд хамгаалалтын бүсэд хамрагдаагүй 2070062 шоо.метр нөөц бүхий 16800 га талбай ашиглалтын бүсийн ойн санд хамаарч байна. Үүнээс 74718960 шоо.метр нөөц бүхий 15666 га талбайг байгалийн ой эзэлж байна

Увс аймгийн ашиглалтын бүсийн ойн сангийн талбайн хэмжээг сум тус бүрээр гаргаж 23-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-23

Увс аймгийн ашиглалтын бүсийн ойн талбай, нөөц /сум тус бүрээр/

| д/д | Сумын нэр | Ашиглалтын бүс | | |
|--------------------|------------|-------------------------|--------------|-----------------|
| | | Ойн сангийн талбай /га/ | Байгалийн ой | |
| | | | Талбай /га/ | Нөөц /шоо.метр/ |
| 1 | Зүүнхангай | 7007 | 6607 | 818960 |
| 2 | Малчин | 5112 | 4613 | 628580 |
| 3 | Түргэн | 4591 | 4446 | 522670 |
| Аймгийн хэмжээгээр | | 16800 | 1566 | 1970210 |

Увс аймгийн ой бүхий бусад сумын ой нь хамгаалалтын шинж чанартай ба ойн нөөц багатай, тусгай хамгаалалтын чанартай ой юм. Хамгаалалтын бүсийн ой гээд ашиглахгүй байх нь зохисгүй бөгөөд өтөлсөн, хөгширсөн ой их байгаа тул арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлж хатсан, унасан, шатсан, ойн хортон, шавжид нэрвэгдэж хатаж хуурайшсан болон хэт хөгшин моддыг авч ахуйн хэрэглээнд болон түлшинд ашиглах нь зүйтэй байдаг.

Ашиглалтын бүсэд хамаарах байгалийн ойн талбай, нөөц насны бүлгээр хуваарилагдсан байдлыг 24-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-24

Ашиглалтын бүсийн байгалийн ойн талбай, нөөц насны бүлгээр тархах нь

| Модны төрөл | Насны бүлэг | | | | | | | | Дүн | |
|---------------------------------------|-------------|------|---------------|--------|---------------------|--------|-------------------------|---------|--------|---------|
| | Залуу ой | | Дунд насны ой | | Болц гүйцэж яваа ой | | Болц гүйцсэн, хөгшин ой | | | |
| | талбай | нөөц | талбай | нөөц | талбай | нөөц | талбай | нөөц | талбай | нөөц |
| Ашиглалтын бүс - Ашиглалтын бүсийн ой | | | | | | | | | | |
| Шинэс | 147 | 4900 | 1945 | 189920 | 5754 | 634660 | 7820 | 1140730 | 15666 | 1970210 |

| | | | | | | | | | | |
|-----|-----|------|------|--------|------|--------|------|---------|-------|---------|
| Дүн | 147 | 4900 | 1945 | 189920 | 5754 | 634660 | 7820 | 1140730 | 15666 | 1970210 |
|-----|-----|------|------|--------|------|--------|------|---------|-------|---------|

4.2. Үйлдвэрлэлийн огтлолтын нас, огтлолтын арга

Үндсэн ашиглалтын огтлолтын нас гэдэг нь ойд үндсэн ашиглалтын огтлолт явуулж болох хамгийн бага насыг хэлнэ. Огтлолтын насыг тогтоох үндэслэл нь болцын нас боловч ойн болцын нас дотроо байгалийн, тооны, техникийн, сэргэн ургалтын гэх мэт олон янз байна. Үндсэн ашиглалтын огтлолтын насыг “Ойд үндсэн ашиглалтын огтлолт явуулах технологийн заавар”-ын 1.2-т заасны дагуу шилмүүст модонд 121, навчит модонд 61 жилээс дээш жилээр тогтоов. Ашиглалтын бүсэд огтлолтын насанд хүрсэн болон хөгшин модыг огтолж ашиглахыг ойн үндсэн ашиглалтын огтлолт гэнэ.

Үйлдвэрлэлийн огтлолтын арга: Уулын нөхцөлд үндсэн ашиглалтын огтлолт хийхэд модны насны бүтэц, газрын налуу, хөрсний элэгдэл үүсэх нөхцөл, ус чийгийн тогтонги байдал, үржил шимт хэсгийн зузаан, үлдсэн модны салхинд унах эсэх зэрэг олон үзүүлэлтийг харгалзан ямар аргаар огтлохыг сонгон авна. Үндсэн ашиглалтын огтлолтыг түүвэрлэх ба аажим огтлолт гэсэн 2 аргаар явуулна.

Нас, хэмжээ, чанарын хувьд огтлох шаардлагатай болсон модны тодорхой хувийг тодорхой жилийн давталттайгаар ойгоос байнга огтолж ашиглахыг түүвэрлэх огтлолт гэнэ.

Өсвөр мод, хоёрдогч ташингын залуу мод үүсэж бүрэлдэх нөхцөлийг тооцон мод бэлтгэх талбай дээрх болц гүйцсэн модыг насны нэг юм уу хоёр ангийн хугацаанд 2-4 давталттай огтолж ашиглахыг аажим огтлолт гэнэ.

Аажим огтлолтыг ижил насны нэг төрлийн мододтой 0-15 хэмийн налууд ургаж байгаа ойд сэргэн ургалтыг дэмжих, хөрс, ус хамгаалах чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор 3-4 удаагийн давталттайгаар явуулдаг. Жигд аажим огтлолтыг бэлтгэл, үндсэн, эцсийн гэсэн 3 үе шатаар явуулна.

Бэлтгэл огтлолтын үед шигүү ойг 0.6-0.7 өтгөрөлтэй болтол сийрүүлж, гэрлийн нөхцөлийг сайжруулан, модны үр өсөлт, үрийн соёлолтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Эхний огтлолтоор мод цагаалгын замыг оролцуулан огтлолтын эрчим 25-30 хувь байна. Тухайн ойн өтгөрлөөс хамаарч огтлолтын эрчим нь өөр өөр байж болно. Дараагийн огтлолтыг 6-8 жилийн дараа хийнэ. Гэхдээ ойд өсвөр модны тооллого явуулж, үнэлэлт өгсний үндсэн дээр дараагийн огтлолт хийх хугацааг нарийвчлан тогтооно. Ойн өтгөрөл 0.7-оос илүүгүй бол бэлтгэл огтлолт хийх шаардлагагүй.

Үндсэн огтлолтын зорилго нь мод ургах чөлөөтэй орон зайг нэмэгдүүлж, олон тооны өсвөр мод ургах, өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Ойн өтгөрлийг 0.4-өөс бууруулахгүйгээр ойн огтлох нөөцийн 20-25 хувийг огтолж авах боловч ойн өтгөрлөөс хамаарч огтлох эрчим өөр өөр байж болно. Бэлтгэл огтлолт хийгээгүй ойд цагаалгын замыг оруулан огтлолтын эрчим 40 хүртэл хувь байж болох бөгөөд огтлолтын дараах ойн өтгөрөл 0.4-өөс багагүй байна.

Дараагийн огтлолтыг 6-8 жилийн дараа нэг га талбайд жижиг өсвөр мод 4000-5000, дунд хэмжээний өсвөр мод 2500-3000, том хэмжээний өсвөр мод 1500-2000 ширхгээс цөөнгүй ургасан тохиолдолд хийнэ. Эцсийн огтлолтоор өсвөр болон залуу модыг гэмтээхгүйгээр болц гүйцсэн бүх модыг огтолж авна.

Түүвэрлэх огтлолтыг янз бүрийн мододтой ойд явуулах бөгөөд ойн өтгөрлийг 0.5-аас доош оруулахгүйгээр болц гүйцсэн, хөгшин модыг түүвэрлэн огтолно. Түүвэрлэх огтлолтыг сонгон түүвэрлэх, ойн аж ахуйн, үйлдвэрлэлийн зориулалттай түүвэрлэн огтлох гэж 3 ангилдаг. Энэ огтлолтоор ойн өтгөрлийг 0.5-аас доош бууруулахгүйгээр тухайн

талбайн болц гүйцсэн хөгшин ойн нөөцийг 15-30 хувийн эрчимтэй 20-30 жилийн давтамжтайгаар модыг жигд сийрүүлэн огтлоно.

Увс аймгийн ашиглалтын бүсийн ойн санд 0-15 хэмийн налуууд ургаж байгаа огтлолтын насанд хүрсэн ижил насны цэвэр ой бүртгэгдээгүй тул аажим огтлолт төлөвлөөгүй бөгөөд 0-25 хэмийн налуууд ургаж байгаа цэвэр болон холимог ойд түүвэрлэх огтлолтын аргыг төлөвлөж өгөв.

Мод бэлтгэлийн технологи: Огтлолтын үед мод бэлтгэх талбайг дунджаар 30-35 метр өргөн булхайн хэсгүүдэд хувааж тэдгээрийн голоор 4-5 метр цагаалгын зам гаргана.

Булхайн хэсэг дээрх модыг цагаалгын зам дагуу 5-35 хэмийн өнцгөөр үзүүрээр нь зам руу чиглүүлж унагаад мөчирлөсний дараа үзүүрээр цагаална. Мод бэлтгэлийн ажлыг гүйцэтгэхдээ өсвөр модыг хамгаалсан арга технологи хэрэглэх ба огтлолтын дараа ой байгалийн аясаараа нөхөн сэргэх нөхцөл боломж бүрдсэн байх ёстой. Мод бэлтгэлийн ажилд Ойн газрын даргын 2009 оны 88 тоот тушаалын I хавсралт “Ойд үндсэн ашиглалтын огтлолт явуулах технологийн заавар”-ыг мөрдөж ажиллана.

4.3. Тооцоот мод бэлтгэлийн хэмжээ

Түүвэрлэх огтлолт: Мод бэлтгэлийн технологийн зааврын дагуу ашиглалтын бүсийн 25 хэмээс бага налуууд ургаж байгаа 0.6 болон түүнээс дээш өтгөрөлтэй дан буюу холимог бүрэлдэхүүнтэй ижил биш настай шинэс зонхилсон 12090677 шоо метр нөөц бүхий 118256 га талбайд түүвэрлэх огтлолтыг төлөвлөж жилд бэлтгэх модны боломжит дээд хэмжээг тооцож 25-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-25

Жилийн тооцоот мод бэлтгэлийн хэмжээ (түүвэрлэх огтлолтоор)

| д/д | Сумын нэр | Модны төрөл | Үндсэн ашиглалтын огтлолт төлөвлөсөн | | Жилийн тооцоот мод бэлтгэлийн хэмжээ | |
|----------------------------|------------|-------------|--------------------------------------|---------------------|--------------------------------------|---------------------|
| | | | талбай (га) | нөөц м ³ | талбай (га) | нөөц м ³ |
| 1 | Зүүнхангай | Шинэс | 1790 | 282725 | 60 | 1523 |
| 2 | Малчин | Шинэс | 1667 | 303820 | 56 | 1691 |
| 3 | Түргэн | Шинэс | 1060 | 10923 | 35 | 364 |
| Аймгийн нэгдсэн дүн | | | 4517 | 597468 | 151 | 3578 |

Увс аймгийн ашиглалтын бүсийн ойгоос түүвэрлэх огтлолтоор жилд бэлтгэх модны боломжит хэмжээг тооцож үзэхэд 1 жилд 151 га талбайгаас 3578 шоо.метр мод бэлтгэж ашиглах боломжтой гэсэн тооцоо гарч байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭ

Ойн аж ахуйн арга хэмжээнд мод, сөөгийн үр, боргоцой бэлтгэх, боловсруулах, чанарын шинжилгээ хийх, тарьц, суулгац ургуулах, ойжуулалт, ой нөхөн сэргээлт, хамгаалалтын ногоон зурвас, модлог ургамлын цэцэрлэг байгуулах, ой зохион байгуулалт, ойн дагалт баялаг ашиглах, хөнөөлт шавж, өвчин, түймрээс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх зэрэг ажлууд орно.

Ой зохион байгуулалтын ажлын нэг зорилго нь ойн талбай, нөөц, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судалж тогтоосны үндсэн дээр ойн санд хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөж өгөх явдал юм.

5.1. Арчилгааны ажил

Арчилгааны огтлолт нь аж ахуйн өндөр ач холбогдолтой үнэт төрлийн мод зонхилсон ойг бий болгох, нэгж талбайгаас ашиглах модны нөөц болон нэг модноос гарах хэрэгцээний хэсгийн гарцыг нэмэгдүүлж, модлогийн чанарыг сайжруулах, түймрийн аюулыг багасгах, ойн ус зохицуулах, уур амьсгалын тохиромжгүй нөхцөлд тэсвэртэй ойг бий болгох, хөрс хамгаалах болон бусад ашигт шинж чанарыг дээшлүүлэх зорилгоор явуулдаг ойн аж ахуйн хамгийн чухал арга хэмжээ юм.

Арчилгааны ажлаар ойн хэвийн өсөлт хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор мод, сөөгийг үе шаттай сонгон огтлох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ойн сайн чанартай модонд өсөлт, хөгжилтийн тохиромжтой нөхцөл бүрдүүлэхийн тулд моддын титэм нийлэх үеэс эхлэн үндсэн ашиглалтын огтлолт хүртэлх хугацаанд ойн арчилгааны огтлолтыг явуулах ба залуу болон дунд насны I-IV ангийн ойд хэрэгжүүлнэ.

Ойн нас, өтгөрлийг харгалзан үзсэний үндсэн дээр арчилгааны огтлолтыг гэрэлтүүлэх, тохируулах, сийрүүлэх, завсрын гэсэн 4 хэлбэрээр явуулна. Огтлолт тус бүрийн нас, зорилгыг 26-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-26

Арчилгааны огтлолтын хэлбэр, зорилго

| д/д | Арчилгааны хэлбэр | Нас /жил/ | | Арчилгааны зорилго |
|-----|-------------------|-----------|-----------|--|
| | | шилмүүст | навчит | |
| 1 | Гэрэлтүүлэх | 20 хүртэл | 10 хүртэл | Холимог ойд моддын зохистой бүрэлдэхүүнийг тогтоох, дан ширэнгэ ойд гэрлийн хэмжээг нэмэгдүүлэх, моддын өсөлтийг түргэсгэх |
| 2 | Тохируулах | 21-40 | 11-20 | Өсвөр залуу модны байршлыг талбайд жигд болгох, өсөлтийн нөхцөлийг сайжруулах, модны төрлийн тоон харьцааг тохируулах |
| 3 | Сийрүүлэх | 41-60 | 21-40 | Ишний хэлбэр сайтай модыг сонгон үлдээж, модны титэм, иш зөв хэлбэржих, өсөлт нэмэгдэх, тохиромжтой нөхцөл бүрдүүлэх |

| | | | | |
|---|---------|----------------|----------------|--|
| 4 | Завсрын | 61-ээс дээш | 41-ээс дээш | Дунд насны модны цаг үеийн өсөлтийг эрчимжүүлэх, модны техникийн болцын насыг богиносгох |
|---|---------|----------------|----------------|--|

Арчилгааны гэрэлтүүлэх ба тохируулах ажлыг холимог ой түүнчлэн нэг төрлийн модтой хэт шигүү ойд хийнэ.

1. Гэрэлтүүлэх ажлаар холимог ойд моддын зохистой бүрэлдэхүүнийг тогтоох, дан ширэнгэн ойн гэрлийн хэмжээг нэмэгдүүлж моддын өсөлтийг түргэтгэх гол зорилгоор үндсэн үүлдрийн модны өсөлт хөгжилтөд саад болж байгаа навчит модыг голдуу огтолно.

2. Тохируулах ажлаар үндсэн үүлдрийн модыг талбайд жигд байрлуулах, өсөлтийн нөхцөлийг сайжруулах зорилгоор ойн модны үүлдрийн харьцааг зохицуулж, үндсэн үүлдрийн модны өсөлтөд саад болж байгаа дагалдах үүлдрийн мод төдийгүй өсөлтөөр муу болон шигүү ургасан бүлэг модны доторх бусдадаа саад болж байгаа үндсэн үүлдрийн зарим моддыг огтолно.

3. Сийрэгжүүлэх огтлолтоор титэм, ишний хэлбэр, өсөлт сайтай модыг үлдээж, титэм, иш зөв хэлбэрших, өсөлт нэмэгдэх тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хэлбэр муутай, согогтой модыг огтолно.

4. Завсрын огтлолтыг сайн модны тухайн үеийн өсөлтийг эрчимжүүлж, модны техникийн болцын насыг богиносгох зорилгоор хийнэ.

5.1.1. Арчилгааны огтлолт хийх шаардлагатай ой

Ойн өтгөрөл, шигүүрэл, бүрэлдэхүүн, моддын хоорондох харилцан нөлөөлөл, чансаа, эрүүл ахуйн байдал зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан тухайн ойд арчилгааны огтлолт хийх шаардлагатай эсэхийг 40 хүртэлх насны ойд модны титэм нийлэлтээр, 40-өөс дээш насны ойд өтгөрлөөр тогтооно.

Гэрэлтүүлэх арчилгааг 1.0 болон түүнээс дээш титэм нийлэлттэй хэт шигүү ургасан цэвэр ойд, навчит мод нь үндсэн үүлдрийн модны өсөлтийг саатуулж байгаа тохиолдолд ямар ч өтгөрөлтэй ойд хийнэ.

Тохируулах арчилгааг 0.9-өөс дээш өтгөрөлтэй цэвэр ой, 0.6-аас дээш өтгөрөлтэй холимог ойд хийх бөгөөд навчит мод нь үндсэн үүлдрийн модыг ихээр сүүдэрлэж байвал 0.6-аас бага өтгөрөлтэй ойд хийж болно.

Сийрэгжүүлэх ба завсрын огтлолтыг 0.8-аас дээш өтгөрөлтэй ойд хийнэ. Тухайн ойд аж ахуйн ач холбогдолтой модны үүлдрийн харьцаа алдагдаж, чанаргүй мод зонхилсон тохиолдолд огтлолтыг 0.7 өтгөрөлтэй ойд хийж болно.

Ой мод нь жигд биш бүлгээр байрласан, био бүлгийн өтгөрөл нь 0.8-0.9-өөс багагүй тохиолдолд, ойн ерөнхий өтгөрөл 0.8-аас бага байсан ч тухайн ойд арчилгааны огтлолтыг явуулах шаардлагатай. Энд бүлэг модыг сийрэгжүүлэх замаар огтолно.

Ойн арчилгааны огтлолт явуулах шаардлагатай эсэхийг тогтоохдоо өтгөрлөөс гадна модны шигүүрлийг (1 га талбай дахь модны тоо) харгалзан үзнэ. Өсөлтөөр хоцорсон, сул хөгжсөн хавчиг титэм бүхий модтой шигүү ойд арчилгааны огтлолт явуулах шаардлагатай байдаг. Навчит мод ихтэй ойд шилмүүст модны өсөлт эрс буурдаг тул холимог ойд арчилгааны огтлолт хийх шаардлага тулгардаг. Харин Ү, Үа чансаатай ойд арчилгааны огтлолт явуулах шаардлагагүй.

5.1.2. Арчилгааны огтлолтын давтагдах хугацаа, жилд огтлох модны хэмжээ

Ойн арчилгааны огтлолтын давтагдах хугацаа нь гэрэлтүүлэх ба тохируулах арчилгааны үед 5-8 жил, сийрэгжүүлэх огтлолтод 5-10 жил, завсрын огтлолтод 10-15 жил байна.

Ойн арчилгааны огтлолтын давтагдах хугацаа нь ойн модны өсөлт, огтлолтын эрчмээс хамаарна. Ойн модны өсөлт муу, огтлолтын эрчим өндөр байх тутам огтлолтын давтагдах хугацааг урт тогтооно. Арчилгааны огтлолтыг төлөвлөх үндсэн үзүүлэлт нь огтлолт явуулах шаардлагатай талбайн хэмжээ болно. Арчилгааны огтлолт хийх шаардлагатай талбайн хэмжээг ой зохион байгуулалтын материалд тулгуурлан тодорхойлно. Ойн арчилгааны огтлолтын хэлбэр тус бүрээр огтлолт явуулах шаардлагатай нийт талбайг тогтоож, огтлолтын давтагдах хугацаанд харьцуулж, нэг жилд хийх ажлын хэмжээ (огтлолт хийвэл зохих ойн талбай)-г тодорхойлно.

Ойн арчилгааны огтлолтын жилийн төлөвлөгөөг боловсруулахад огтлолтоос гарах модон материалыг борлуулах боломжийг судлах шаардлагатай. Гэрэлтүүлэх, тохируулах арчилгааны үед хэрэглээний мод гардаггүй учир борлуулалтыг харгалзахгүй төлөвлөгөө зохионо. Шаардлагатай тохиолдолд борлуулалтаас шалтгаалахгүйгээр сийрэгжүүлэх арчилгааны огтлолтыг ч хийнэ.

Ойн арчилгааны огтлолтын төлөвлөгөөнд огтлолт хийх нийт талбайн хэмжээ, огтлох модны нөөц, борлуулах нөөцийг нягт шоо метрээр тусгана. Огтлох модны нөөцийг огтлолтын төлөвлөгөөт эрчим, түүнчлэн өмнөх жилүүдийн огтлолтоор авч байсан модны нөөцийн бодит гарцаар тодорхойлно.

5.1.3. Арчилгааны огтлолтын арга, огтлох модыг сонгох, огтлолтыг эрчим

Ойн хэв шинж, моддын бүрэлдэхүүн, бүтэц, нас, бүтээмжээс шалтгаалан огтлолтын аргыг сонгоно. Ойн арчилгааны огтлолтын арга нь огтлох модыг сонгох, үлдэж байгаа модны байрлалыг тогтооход чиглэгдэнэ.

Гэрэлтүүлэх ба тохируулах арчилгааны үед дараах аргыг хэрэглэнэ. Үүнд:

1. Жигд огтлох огтлолтыг бүх талбайд жигд хийх бөгөөд хүн хүч хангалттай үед хэрэглэнэ.
2. Зурвасаар огтлох талбай дээрх модыг 2-4 метр өргөн зурвасаар сийрэгжүүлэн огтолж, тэдгээрийн хооронд арчилгааны огтлолт хийгээгүй 4-6 метр өргөн зурвас үлдээнэ. Зурвас дээрх дагалдах үүлдрийн модыг огтолно.
3. Бүлгээр нь огтлох үндсэн үүлдрийн мод хэсэг бүлгээр байрласан тохиолдолд эдгээр бүлэг болон түүнээс 2-3 метр зайд байрлах дагалдах үүлдрийн мод, мөн түүнчлэн цэвэр бүрэлдэхүүнтэй ойд үндсэн үүлдрийн модыг огтолно. Зурвас, бүлгээр огтлолт хийх аргыг хүн хүч, эдийн засгийн бололцоо муутай тохиолдолд хэрэглэнэ.

Сийрэгжүүлэх ба завсрын огтлолтын үед дараах 3 аргаар огтлолт хийнэ.

Үүнд:

1. Давжааг нь сийрэгжүүлж огтлох: Цэвэр бүрэлдэхүүнтэй ойд хэрэглэх ба ташингын доод хэсэгт байгаа модыг огтолно. Огтлолтын дараа моддын дундаж диаметр, өндөр нэмэгдэнэ.
2. Өндрийг нь сийрэгжүүлж огтлох: Холимог ойд хэрэглэх бөгөөд моддын ташингын дээд хэсэгт байгаа үндсэн үүлдрийн модны өсөлтийг саатуулж байгаа дагалдах үүлдрийн мод, зарим том хэмжээний үндсэн үүлдрийн модыг огтолно.
3. Хослуулан сийрэгжүүлж огтлох: Дээрх 2 аргыг хослуулан хэрэглэнэ. Энэ аргыг практикт ихэвчлэн хэрэглэдэг.

Огтлох модыг сонгох. Сонгосон талбайн модыг *сайн, туслах, огтлох мод* гэсэн гурван бүлэгт хуваана. Сайн, туслах модыг үлдээж, бусад модыг огтолно. Огтлох модыг мод хоорондын харилцан нөлөөлөл мэдэгдэхүйц илэрсэн био бүлэг бүрээс сонгоно. Ийм бүлэгт нэг буюу хэд хэдэн сайн модыг сонгон үлдээж, бусад модны ач холбогдлыг харгалзан тэдгээрийг огтлох эсэхийг шийдвэрлэнэ.

Сайн модонд ишний хэлбэр, модлогийн чанараар аж ахуйн шаардлагад бүрэн нийцсэн үндсэн үүлдрийн мод орно. Сайн мод нь мөчрөөсөө сайн цэвэрлэгдсэн, эрүүл, шулуун иштэй, жигд хэвийн хөгжилтэй, шовх оройтой, титмийн өсөлт нь жигд мод байна. Ногоон бүсийн ойд сайн модыг үйлдвэрлэлийн ач холбогдлоор нь биш, харин гоо үзэмж, гоёл чимэглэлийн үзүүлэлтээр нь тодорхойлно. Сайн модыг талбайд аль болох жигд байрлалтай үлдээнэ.

Туслах модонд сайн модны мөчрийн цэвэршилт, титмийн хэлбэр, өсөлтөд сайн нөлөө үзүүлж байгаа, ус зохицуулах, хөрс хамгаалах ач холбогдолтой мод хамрагдана. Ойн моддын ташингын аль ч хэсэгт байрлаж байгаа бүх үүлдрийн мод туслах мод байж болно.

Огтлох модонд дараах мод хамаарна. Үүнд:

1. Мөөгөн өвчин, хөнөөлт шавжид нэрвэгдсэн, хатаж байгаа, хугарсан, хатсан мод
2. Салаалсан, муруй тахир иштэй, бүдүүн мөчиртэй, саглагар титэмтэй, ишний нарийсал ихтэй, огтлоход ойн цоорхой үүсгэхгүй мод
3. Сонгон авсан сайн ба туслах модыг сүүдэрлэн тэдний титмийн хэлбэршилд муу нөлөө үзүүлж, өсөлтийг саатуулж байгаа аль ч үүлдрийн бүдүүн мод
4. Харьцангуй ижил модтой шигүү ургасан био бүлгээс сийрэгжүүлэх зорилгоор огтлогдох ганц нэг сайн мод
5. Туслах модонд хамрагдаагүй, аж ахуйн хувьд ашиг багатай мод

Ойн арчилгааны огтлолтын эрчим.

Огтлолтын эрчмийг ойн нөөц, моддын хөндлөн огтлолын талбайн нийлбэр, титэм нийлэлтийн бууралтын зэргээр тогтооно. Арчилгааны огтлолтын эрчмийн ангиллыг 27-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-27

Ойн арчилгааны огтлолтын эрчмийн ангилал

| Үзүүлэлт | Эрчмийн зэрэг | | | |
|--|---------------|-------|----------|----------|
| | Бага | Дунд | Их | Маш их |
| Модны нөөцийн хувь | 15 | 16-25 | 26-35 | 35-с их |
| Моддын хөндлөн огтлолын талбайн нийлбэр (хувь) | 20-оос бага | 21-30 | 31-40 | 40-60 |
| Модны титэм нийлэлтийн бууралт | 0.05-0.1 | 0.15 | 0.15-0.2 | 0.2-с их |

Ойн арчилгааны огтлолтын эрчмийг тогтооход огтлолтын зорилт, уулын хажуугийн зүг чиг, хөрсний зузаан, ойн бүрэлдэхүүн, шигүүрэл, нас, чансаа, ойн хэв шинж, өмнөх огтлолтын эрчмээс хамааруулж тогтооно. Хөрс зузаан, баялаг, чансаа дээгүүр, модны өсөлт сайн байх тутам огтлолтын эрчим өндөр байна.

Холимог ойтой харьцуулахад цэвэр бүрэлдэхүүнтэй ойд огтлолтын эрчим бага байна. Дунд ба болц гүйцэж байгаа ойг бодвол зулзаган ойд огтлолтыг илүү эрчимтэй хийнэ. Ойн арчилгааны огтлолт хийгээгүй хэт шигүү, залуу ойн модны иш нарийн, титэм цасанд

дарагдаж гулзайх аюултай байдаг учир огтлолтыг сул эрчимтэй хийх нь зүйтэй. Уулын хажуу налуу ихтэй, хөрс нимгэн байх тусам огтлолтын эрчим бага байна. Уулын хойд хажууг бодвол өмнө хажууд бага эрчимтэй огтлолт хийнэ. Нэг үүлдрийн модтой ойд арчилгааны огтлолт хийхэд ойн өтгөрлийг 20 хэм хүртэл налуу газар 0.7, 20 хэмээс дээш налуутай газар 0.8-аас доош бууруулж болохгүй. Үндсэн үүлдрийн модны өсөлт, хөгжилт нь навчит модонд хүчтэй дарагдаж байгаа тохиолдолд дээд ташингын өтгөрлийг 0.5-0.6 хүртэл, шаардлагатай үед 0.4 болтол бууруулж болно.

Нэг үүлдрийн модноос бүрэлдсэн 1.0 өтгөрөлтэй, бонитетийн I-II ангийн ойд нэг удаагийн огтлолтоор өтгөрлийг 0.3, II-III ангийн ойд өтгөрлийг 0.2-оос илүү бууруулж болохгүй. Огтлолтын эрчмийг сонгохдоо модны салхи, цасанд тэсвэрлэх байдлыг харгалзан үзэх шаардлагатай.

Ойн арчилгааны огтлолтыг давтан хийх тохиолдолд огтлолтын эрчмийг тохируулах ба сийрэгжүүлэх арчилгааны огтлолтын үед 30 хувь, завсрын арчилгааны огтлолтын үед анхны эрчмээс 50 хувиар бууруулж тогтооно.

5.1.4. Арчилгааны огтлолт явуулах хугацаа

Гэрэлтүүлэх ба тохируулах огтлолтыг ургамал ургалтын хугацаанд хавар, зун, намар хийнэ. Сийрэгжүүлэх болон завсрын огтлолтыг жилийн бүх улиралд хийж болно. Хүчтэй салхитай болон их хүйтэн үед огтлолт хийж болохгүй. Мод бэлтгэх бүх үйл ажиллагаа нь (унагах, хураах, цагаалах) үлдэж байгаа моддыг гэмтээхгүй байхаар дэс дараалалтайгаар явуулна.

Увс аймгийн ойн санд ойн арчилгаа хийх шаардлагатай 218240 шоо метр нөөц бүхий 1508 га талбай байгаагаас гэрэлжүүлэх хэлбэрээр 56 га талбайгаас 56 шоо метр, тохируулах хэлбэрээр 157 га талбайгаас 894 шоо метр, сийрүүлэх хэлбэрээр 343 га талбайгаас 7009 шоо метр, завсрын хэлбэрээр 952 га талбайгаас 24733 шоо метр нийт 1508 га талбайгаас 32692 шоо метр мод бэлтгэж ашиглах боломжтой ба жилд дунджаар 150 га талбайгаас 3269 шоо.метр модлог нөөцийг бэлтгэх боломжтой байна.

Тус аймгийн ойн санд хэрэгжүүлэх арчилгааны огтлолтын талбай, нөөцийн хэмжээг 28-р хүснэгтээр үзүүлэв.

28-р хүснэгт

Арчилгааны огтлолт

| Арга хэмжээний төрөл | Талбай (га) | Нийт нөөц (ш.м) | Огтлох нөөц (ш.м) |
|----------------------|----------------|--------------------|----------------------|
| Гэрэлтүүлэх | 56 | 560 | 56.0 |
| Тохируулах | 157 | 10430 | 894.0 |
| Сийрэгжүүлэх | 343 | 47910 | 7009.5 |
| Завсрын | 952 | 159340 | 24733.0 |
| Нийт дүн | 1508 | 218240 | 32692.5 |

Арчилгааны ажлыг ойн арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэх бөгөөд гэрэлтүүлэх, тохируулах огтлолтыг сум дундын ойн анги гүйцэтгэж болно.

Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/244 дугаар тушаалаар баталсан “Ойд арчилгаа,

цэвэрлэгээ хийх журам”-ыг баримтална. Ойн арчилгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2018 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/99 тушаалаар баталсан “Ойд арчилгаа хийх технологийн заавар”-ыг мөрдөж ажиллана.

Арчилгааны ажил явуулах шаардлагатай хэсэглэл, ялгарлын дугаар, талбай, нөөцийн хэмжээг үзүүлсэн “Арчилгааны огтлолтын түүвэр” хүснэгтийг сумдын ой зохион байгуулалтын ажлын тайланд хавсаргав.

Увс аймгийн ойн санд хэрэгжүүлэх арчилгааны огтлолтын хэлбэрийг сум тус бүрээр төлөвлөж 29-р хүснэгтээр үзүүлэв.

Арчилгааны огтлолт /сум тус бүрээр/

| № | Сумын нэр | Арчилгааны огтлолтын төрөл | | | | | | | | Нийт хэмжээ | | Жилд гүйцэтгэх | |
|----|---------------|----------------------------|--------------|----------------|---------------|----------------|---------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|---------------|
| | | Гэрэлжүүлэх | | Тохируулах | | Сийрүүлэх | | Завсрын | | талбай (га) | нөөц (м³) | талбай (га) | нөөц (м³) |
| | | талбай (га) | нөөц (м³) | талбай (га) | нөөц (м³) | талбай (га) | нөөц (м³) | талбай (га) | нөөц (м³) | | | | |
| 1 | Өндөрхангай | | | | | 89 | 13,130 | 478 | 77,470 | 567 | 90,600 | 56.7 | 9,060 |
| 2 | Бөхмөрөн | | | 100 | 6,520 | | | | | 100 | 6,520 | 10.0 | 652 |
| 3 | Баруунтуруун | | | | | 57 | 10,260 | | | 57 | 10,260 | 5.7 | 1,026 |
| 4 | Зүүнхангай | 56 | 560 | | | 73 | 10,490 | 48 | 6,880 | 177 | 17,930 | 17.7 | 1,793 |
| 5 | Малчин | | | | | | | 117 | 16,330 | 117 | 16,330 | 11.7 | 1,633 |
| 6 | Наранбулаг | | | | | | | 42 | 8,400 | 42 | 8,400 | 4.2 | 840 |
| 7 | Сагил | | | | | | | 149 | 30,520 | 149 | 30,520 | 14.9 | 3,052 |
| 8 | Түргэн | | | 20 | 2,000 | 124 | 14,030 | | | 144 | 16,030 | 14.4 | 1,603 |
| 9 | Тариалан | | | 37 | 1,910 | 45 | 7,310 | | | 82 | 9,220 | 8.2 | 922 |
| 10 | Цагаанхайрхан | | | | | | | 73 | 12,430 | 73 | 12,430 | 7.3 | 1,243 |
| | Дүн | 56 | 560 | 157 | 10,430 | 388 | 55,220 | 907 | 152,030 | 1,508 | 218,240 | 151 | 21,824 |

Ой зохион байгуулалтын ажлаар гэрэлтүүлэх болон тохируулах арчилгааны огтлолт зайлшгүй явуулах шаардлагатай талбайд төлөвлөлт хийгдээгүй үлдсэн тохиолдолд тухайн бүс нутгийг хариуцсан ойн анги газар дээр нь үнэлгээ хийж талбай тусгаарлан, хэмжилт тооллогын үр дүнгээр арчилгааны төрлийг тогтоож арчилгааны ажлыг гүйцэтгэж болно.

5.2. Цэвэрлэгээний огтлолт

Ойн аж ахуйн нэгэн чухал арга хэмжээ нь цэвэрлэгээний огтлолт юм. Ойн цэвэрлэгээ гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ юм. Цэвэрлэгээний ажлын үед унасан модны 30 хувийг талбайд үлдээж ойн амьтан, бичил организмын амьдрах орчин бүрдүүлнэ.

Цэвэрлэгээний ажил нь дараах хэлбэрээр хийгдэнэ.

1. Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг ойгоос гаргах цэвэрлэгээний ажил

2. Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж хатсан цаашид ургах чадваргүй болсон ойн модыг огтлох замаар ойг цэвэрлэх, ойг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн цэвэрлэгээний огтлолт

Ойн цэвэрлэгээг ашиглалтын болон хамгаалалтын бүсийн суларч доройтсон, хатсан модтой бүх насны ойд хийнэ. Ойн цэвэрлэгээний үед “Ойн цэвэрлэгээний болон үндсэн ашиглалтын огтлолт, арчилгаа, цэвэрлэгээнд тавигдах ерөнхий шаардлага” стандартыг мөрдөнө. Цэвэрлэгээний ажлаар түймэр, хөнөөлт шавж, салхи, цасны нөлөөгөөр их хэмжээгээр унасан мод, үзүүр, ёзоор, мөчир гишүүг авч ойг цэвэрлэнэ.

5.2.1. Цэвэрлэгээний огтлолтын хэлбэр

Ойн цэвэрлэгээний огтлолтыг түүвэрлэн огтлох, харьцангуй хавтгайруулан огтлох гэсэн 2 хэлбэрээр явуулна.

1. Цэвэрлэгээний түүвэрлэн огтлолт нь ойн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зорилгоор өвчин, хөнөөлт шавжид нэрвэгдэж доройтсон, хатаж байгаа болон хатсан модыг түүвэрлэн авах огтлолт юм.
2. Цэвэрлэгээний харьцангуй хавтгайруулан огтлолт гэж түймэр, хөнөөлт шавж, өвчин, хүчтэй салхи, цас зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдэн их хэмжээгээр үхэж, биологийн тогтворт байдлаа алдсан ой модыг бүрэн солих, нэлэнхийд нь ойжуулах зорилгоор хийх огтлолтыг хэлнэ.

Увс аймгийн ойн санд 30013 га талбайд 480990 м³ хатсан мод, 244540 м³ унанги мод бүртгэгдсэн байна. Үүнээс ойн цэвэрлэгээний ажлаар 1503 га талбайд 65680 м³ хатсан мод, 1156 га талбайд 19170 м³ хатсан модны нөөц ашиглахаар төлөвлөж өгөв. Цэвэрлэгээний ажлын талбай, нөөцийг сум тус бүрээр гаргаж 30-р хүснэгтээр үзүүлэв.

30-р хүснэгт

Цэвэрлэгээний ажлын хэмжээ сум тус бүрээр

| д/д | Сумын нэр | Хатсан модыг цэвэрлэх | | Унанги модыг цэвэрлэх | |
|-----|--------------|-----------------------|------------------------|-----------------------|------------------------|
| | | Талбай (га) | Нөөц (м ³) | Талбай (га) | Нөөц (м ³) |
| 1 | Баруунтуруун | 1093 | 44320 | 30 | 300 |
| 2 | Зүүнхангай | 46 | 2120 | 221 | 3760 |
| 3 | Өндөрхангай | 294 | 16410 | 344 | 5100 |
| 4 | Малчин | 14 | 520 | | |
| 5 | Сагил | 14 | 540 | 431 | 8620 |
| 6 | Түргэн | | | 2 | 20 |
| 7 | Улаангом | | | 63 | 630 |

| | | | | | |
|---|---------------|------|-------|------|-------|
| 8 | Цагаанхайрхан | 42 | 1770 | 65 | 740 |
| | Дүн | 1503 | 65680 | 1156 | 19170 |

Ойд цэвэрлэгээний ажил хийснээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн хэрэгцээний болон түлшний хэрэгцээг хангах боломжтой. Ойн цэвэрлэгээний ажлыг арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, иргэн гэрээ байгуулан хийж гүйцэтгэнэ. Харин ойн цэвэрлэгээний огтлолтыг зөвхөн арчилгаа, цэвэрлэгээний эрх бүхий ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Тухайн жилд хийх арчилгаа, цэвэрлэгээний ажлын хэмжээг “Ойн менежмент төлөвлөгөө”-г үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл тус бүрээр тогтооно. Аймаг, нийслэлийн Байгаль хамгаалах газар тогтоосон хэмжээнд багтаан тухайн жилд хийх арчилгаа, цэвэрлэгээний ажлын талбай, огтлолтын хэлбэрийг хэсэглэл, ялгарал тус бүрээр сонгож төлөвлөнө. Арчилгаа, цэвэрлэгээний ажлын түүвэр хүснэгтийг хэсэглэл ялгарлаар гаргаж сумдын ой зохион байгуулалтын ажлын тайланд хавсаргав.

5.3. Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээ

Ойжуулалт ойг нөхөн сэргээх арга хэмжээний зорилго нь ойн нөөцийг арвижуулах, ойн удмын санг хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, ойн хамгаалалтын ач холбогдлыг алдагдуулахгүй байх явдал юм. Үүний тулд ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн болон мод бэлтгэсэн талбайд нэн түрүүнд мод тарьж ургуулах, нөхөн сэргээх ажлыг хийх хэрэгтэй. Ойг нөхөн сэргээх арга хэмжээг зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах гэсэн 2 хэлбэрээр хийдэг.

5.3.1. Ойжуулалт

Ойд их хэмжээний талбайг хамруулан огтлолт хийснээс болон түймрийн улмаас хөрсний гадаргын температур өндөр болж, хөрсний өнгөн хэсгийн чийгийн хангамж үлэмж хэмжээгээр багасах, өвслөг ургамал ихээр урган өсвөр ургац шинээр гарч ирэхэд саад учруулснаас ойн сэргэн ургах үйл явц удааширч бараг ахиж сэргэхгүй байдалд хүрдэг.

Ой зохион байгуулалтын ажлаар ойжуулалт хийх талбайг тогтоодог бөгөөд энд тармаг модтой талбай, шатсан талбай, мод бэлтгэсэн талбай хамаарна.

Тооцооноос үзэхэд тус аймгийн хэмжээгээр ойжуулалт хийх шаардлагатай ойгоор бүрхэгдээгүй 31536 га талбай бүртгэгдсэн байна. Үүнийг газрын төрөл тус бүрээр авч үзвэл түймэрт нэрвэгдсэн 1134 га, мод бэлтгэсэн талбай 2009 га, тармаг мод 25681 га, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай 2712 га байна.

Эдгээрээс эхний ээлжид байгалийн аясаар сэргэн ургалт явагдаагүй буюу хангалтгүй ургалттай мод бэлтгэсэн болон шатсан талбайг сонгож ойжуулалт хийх нь зүйтэй байдаг.

Увс аймгийн ойн санд 3928 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах, 1105 га талбайд ойжуулалт хийх арга хэмжээг төлөвлөж өгөв.

Ойжуулалт, нөхөн сэргээх арга хэмжээний түүвэр хүснэгтийг сум тус бүрийн тайланд хавсаргав.

Увс аймгийн ойн санд ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээг сум тус бүрээр гаргаж 31-р хүснэгтээр үзүүлэв.

Ойн аж ахуйн арга хэмжээ (талбай га)

| д/д | Сумын нэр | Ойжуулалт хийх | Байгалийн сэргэн ургалтад туслах |
|-----|-----------------|----------------|----------------------------------|
| 1 | Баруунтуруун | 251 | 1730 |
| 2 | Бөхмөрөн | 19 | |
| 3 | Зүүнхангай | 207 | 46 |
| 4 | Өндөрхангай | 313 | 1642 |
| 5 | Малчин | 55 | 60 |
| 6 | Наранбулаг | 29 | |
| 7 | Сагил | 12 | 132 |
| 8 | Түргэн | 113 | 105 |
| 9 | Тариалан | | 26 |
| 10 | Хяргас | | 2 |
| 11 | Цагаанхайрхан | 106 | 185 |
| | Нийт дүн | 1105 | 3928 |

5.3.2. Ойн байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээ

Мод бэлтгэсэн, ойн түймэр, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойд үлдсэн болон түүний зэрэгцээ ойгоос үр цацагдах буюу хожуулаас ургал эрхтнээр дахин ой бий болох явцыг ойн байгалийн сэргэн ургалт гэх бөгөөд байгалийн аясаар сэргэх боломжгүй газарт ойг нөхөн сэргэхэд үзүүлэх хүний зориудын дэмжлэгийг ойн байгалийн сэргэн ургалтад туслах ажил гэнэ. Энэ ажлыг дараах хэлбэрээр явуулна.

- Ойн зах, мод бэлтгэсэн, шатсан талбайд модны цухуйлц өсөж томроход өвслөг ургамлын өрсөлдөөнийг арилгах зорилгоор анжсаар шан татах. Ийм газарт модны үр байгалийн аясаар унаж чөлөөтэй ургах нөхцөл бүрдэнэ.

- Мод бэлтгэсэн, шатсан талбайд гараар үр цацаж орших.

- Мод бэлтгэсэн, шатсан талбайд гар аргаар 40x40 см-ээс 1x1 метр хэмжээтэй талбарын ширэг бүхий хөрсний өнгөн хэсгийг хуулж модны үр цацах буюу байгалийн аясаар үр унаж ургах нөхцөлийг бүрдүүлэх.

-Хөгшин мод ихтэйгээс тэжээлийн талбай хүрэлцээгүй болж ойн дараачийн үр удмыг бүрдүүлэх цухуйлц зулзаган мод гарч ирэхгүй үед хөгшин модноос тодорхой хэмжээний цэвэрлэгээний огтлолт хийнэ.

-Мөн дунд насны шигүү модонд сийрэгжүүлэх арчилгаа хийх замаар дараагийн насны ойн байгалийн сэргэн ургалтад туслах

-Мод бэлтгэлийн талбайд үрийн мод үлдээх нь ойн сэргэн ургалтад туслах ажлын нэг чухал хэсэг болно.

-Хөрсний гадаргууг хагалан бэлтгэх. Үр тархан ургах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд их үрийн жилийг угтуулан хөрсийг хагалан боловсруулна.

Ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлын гол зорилго нь ойн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай болон мод бэлтгэсэн талбайн ойн орчны нөхцөл өөрчлөгдөхөөс өмнө уг ойн аясаараа сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.

5.4. Ой хамгааллын арга хэмжээ

Ойг хамгаалах арга хэмжээнд ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагаа хамаарна.

5.4.1. Ойн түймэр

Монгол орны ойн экосистемд сөрөг нөлөө үзүүлдэг томоохон хүчин зүйл нь ой хээрийн түймэр юм. Иймээс ойн санд ихээхэн хэмжээний экологийн болон эдийн засгийн хохирол учруулж байгаа ойн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Увс аймгийн ойн санд 1134 га талбай ойн түймрийн нөлөөгөөр доройтолд орсон байна.

Ойг түймэрт өртөх байдлыг харгалзан шаталтын зэрэг тогтоодог. Ой, хээрийн түймрийн шаталтын зэрэглэлийг зөв тогтоох нь түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, учирсан хохирлыг тооцох, шуурхай арилгах, шатсан ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлого боловсруулж хэрэгжүүлэх үндэслэл болдог.

Түймрийн эрчмийг тодорхойлохдоо нэг талаас модны гэмтлийн зэрэг нөгөө талаас галын ул мөрийг тооцоолон сул, дунд, хүчтэй, нэн хүчтэй эрчимтэй гэсэн 4 бүлэгт хувааж тус бүрийнх нь хамарсан талбай модны төрлийг тогтооно.

- Сул эрчимтэй түймэрт өвслөг болон сөөглөг ургамлын ихэнх хувь нь шатахаас гадна 1 метр хүртэлх өндөртэй зулзаган модод өртдөг. Түймэрт нэрвэгдсэн ойн талбайн модны нөөцийн 15 хүртэл хувь цаашид ургах боломжгүй шатсан ой хамаарна.
- Дунд эрчимтэй түймэрт дээрх өвслөг, сөөглөг ургамал, зулзаган моддоос гадна 5-6 метр хүртэлх өндөртэй ширэнгэ, том моддын титмийн өндрийн хагас хувь хүртэл шатдаг байна. Модны нөөцийн 16-45 хувь шатсан ой хамаарна.
- Хүчтэй эрчимтэй түймэрт өвслөг, сөөглөг ургамал, зулзаган мод, ширэнгэн ташинга шатахаас гадна модны нөөцийн 46-45 хүртэл хувь шатсан ойн талбай хамаарна.
- Нэн хүчтэй эрчимтэй түймэрт том мод оройгоо хүртэл шатаж мөхдөг байна. Модны нөөцийн 75-аас дээш хувь нь шатсан ойн талбай хамаарна.

Ойн түймрийн шаталтын зэрэглэлийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны 106 дугаар тушаалаар батлагдсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ыг баримтална.

Ойн түймрээс урьдчилан сэргийлэх: Орон нутгийн удирдлага ойн түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллана.

Түймрийн аюултай үе болох жил бүрийн 3 сарын 20-ны өдрөөс 6 сарын 10-ны өдөр, 9 сарын 20-ны өдрөөс 11 сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд ил задгай гал түлэхгүй байх, зайлшгүй тохиолдлоор түлсэн гал, асаасан чүдэнз, татсан тамхины гал, цог нурмыг бүрэн унтраах.

Гал түймрийн аюултай үед ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, аялал зугаалгаар явах, бусад ажлыг гүйцэтгэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчид мэдэгдэж гал түймэр гаргахгүй байх талаар баталгаа өгөх.

Ойн гал түймрийг илрүүлсэн, гал түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол сумын болон багийн засаг дарга нар өөрийн хүч хэрэгслийг зохион байгуулан бага дээр нь даруй

унтраах арга хэмжээ авах, холбогдох байгууллагад мэдэгдэх. Ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлж, ухуулга, сурталчилгааны ажлыг эрчимтэй явуулах.

Харлуулсан зурвас татах: Түймрийн аюул ихтэй залуу, зулзаган мод бүхий галын онц аюултай объектын дагуу 1-2.5 метр өргөн түймрийн хамгаалалтын харлуулсан зурвас татна.

Харуулын цамхаг байгуулах: Энэ нь ойд гарсан түймрийг илрүүлэх зорилгоор тухайн газар нутгийн байдлыг ажиглахын тулд хийгддэг өндрийн байгууламж юм. Ийм цамхгийг мод ба төмрөөр хийнэ. Ойн түймэр их гардаг түймрийн аюул ихтэй газруудад түймрийн цамхаг босгох хэрэгтэй. Уулын биш харьцангуй тэгш газрын ой доторх цамхгийн өндөр 25-35 метр байх хэрэгтэй.

Харин уулын ойд нутаг дэвсгэрийн хамгийн өндөрлөг цэг дээр 10 метр хүртэл өндөртэй цамхаг байгуулна. Цамхаг хоорондын зай ойролцоогоор 10-12 км буюу 10-20 мянган га талбай тутамд 1 цамхаг байвал тохиромжтой. Ажиглалтын цамхагт газар нутгийн схем зураг, холбооны хэрэгсэл, дуран, цаг бүртгэлийн дэвтэр зэрэг байна.

Машин ба морин эргүүл: Түймрийн аюултай хавар, намрын хуурайшилтын үед зам харилцааг судалсны үндсэн дээр чиглэл чиглэлд тусгай маршрут гарган машин болон морин эргүүл ажиллуулах нь чухал юм.

Сурталчилгааны ажил: Хүн ам ихээр суурьшсан газар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлсэн анхааруулга, сэрэмжлүүлэг, сурталчилгаа бүхий самбар хийж байрлуулах нь чухал юм.

- Зөвлөмж, санамж хэвлэж тараах
- Түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, семинар зохион байгуулах
- Түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг хүн бүрд хүргэж түймэртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах хэрэгтэй.
- Ой хээрийн түймэртэй тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслээр хангагдах хэрэгтэй.

Түймрийг илрүүлэх арга: Хавар намрын гал түймрийн аюултай үед байнгын жижүүр, морин болон машин эргүүл гаргаж тэднээс болон ард иргэдээс ойн түймэр илрүүлсэн тухай мэдээ авсан тохиолдолд сум, багийн засаг дарга богино хугацаанд хүн хүчийг зохион байгуулж түймрийг унтраах, холбогдох байгууллагад яаралтай мэдээлэх хэрэгтэй.

Түймрийг унтраах арга хэмжээ: Түймрийн мэдээг хүлээн авсан засаг дарга нь өөрийн эрхийн хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг зохион байгуулж түймэр унтраах төлөвлөгөө, шийдвэр гаргасан байна.

Түймэр унтраахад түймрийн тархалтыг зогсоох, цурванд оруулах, цурванд оруулсан галыг унтраах, цурваас дахин гал гарахаас сэргийлж харуул манаа ажиллуулах гэсэн үе шатаар тэмцэх хэрэгтэй.

Түймрийн тархалтыг зогсоох: Энэ үе шат нь шаталтын дөлийг цохиураар цохих, шороо, ус цацах, цурванд оруулах гэх мэт олон янзын аргаар түймрийн давшилтыг зогсооно.

Түймрийг тусгаарлах буюу цурванд оруулах: Түймрийн дөлийг зогсоосны дараа шатсан талбайг тойруулан 0.3-0.5 метр өргөн харлуулсан зурвасаар түймрийг тусгаарлана.

Цурванд оруулсан галыг унтраах: Хамгаалах зурвас татсаны дараа цурав дотор шатаж байгаа мод, хожуул, бут, сөөг зэрэг галын эх үүсвэрийг цурвын захаас эхлэн төв рүү нь гал унтраагч багаж, хүрз болон бусад гар багажаар унтраана.

Түймрийг дахин сэргэхээс сэргийлж харуул, манаа тавих: Энэ нь шатсан талбайн захаар 10 метр орчим өргөн газарт хяналт тавьж зурвас давж унасан оч, галыг унтраана.

5.4.2. Ойн хөнөөлт шавж

Ойн сан буурахад нөлөөлж буй томоохон хүчин зүйлийн нэг бол мод, бут, сөөгийн навч шилмүүс, иш холтос, модлог, үр жимс, үндсээр хооллодог төрөл бүрийн шавжуудын хэт олшрол юм. Ихэнх тохиолдолд хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр ойн экологийн тэнцвэрт харьцаа алдагдсанаас харьцангуй цөөн зүйлийн шавжийн тоо толгой хэт олширч тэдгээрээс хамгаалах тухай асуудал үүсдэг байна.

Шавжийн аймгийг судлах нь шинжлэх ухаанд тэдгээрийн ангиллын нэгж зүйлийн бүрэлдэхүүнийг зөв тогтоохоос эхэлдэг. Үүний дараа тэдгээрийн биологи, үржил, хөгжил, эдийн засгийн болон байгаль дах ашиг тусыг мэдэж илрүүлэх, хэрвээ бэлчээр, таримал ургамал, ойд хөнөөл учруулдаг шавж бол түүнтэй тэмцэх арга ажиллагааг боловсруулдаг. Олон зүйлийн шавжийн хоорондын төрлийн холбоог зөв тогтоож, тэднийг төрлийн онцлог шинжээр ангиллын янз бүрийн нэгжид хамааруулан нийлүүлж, тогтоож тодорхойлох нь ангилал зүйн гол зорилго юм. Шавжийн нэрийг тодорхойлохдоо олон улсад нийтлэг нэг нэр хэрэглэх зорилгоор зүйл, төрөл болон ангиллын бусад нэгжийн нэрийг латин нэрээр нэрлэж байна. Жишээ нь:

| | |
|-----------------------|------------------------------|
| Сибирийн хүр эрвээхэй | <i>Dendrolimus sibiricus</i> |
| Бургасны хүр эрвээхэй | <i>Leucoma salicis</i> |

Өндөг, авгалдай, бие гүйцсэн “имаго” гэсэн үе шатыг дамжин хөгждөг шавжийг бүрэн бус хувиралтай, өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцэх гэсэн үе шатыг дамжин хөгждөг шавжийг бүрэн хувиралтай гэж нэрлэнэ. Бүрэн бус хөгжилтэй шавжийн хамгийн түгээмэл төлөөлөгч бол царцаа юм. Бүрэн бус хөгжилтэй шавжийн авгалдай хөгжлийн 4-6 шат дамжин хөгжиж, бие гүйцсэн шавж болдог ба авгалдайн биеийн төрх хэлбэр бие гүйцсэн шавжтайгаа төсөөтэй байдаг.

Бүрэн хувиралтай шавжийн авгалдай бие гүйцсэн шавжаасаа эрс өөр хэлбэр дүрстэй байдаг. Авгалдай нь далавчгүй, ихэнхдээ мэрэх амны эрхтэнтэй байдаг. Бүрэн хувиралтай шавжийн үе удмын хөгжил хооллодоггүй тайван шат байдаг. Үүнийг хүүхэлдэйн үе шат гэж нэрлэнэ.

Өндөг: Өндөг төрүүлж хөгжих нь шавжийн ангийн биологийн нэг онцлог юм. Эмэгчин шавж өндгөө нэг нэгээр нь эсвэл хэсэг хэсгээр нь ургамлын навч, ишний гадарга болон дотор, хөрсний зай завсраар өндөглөдөг. Зарим шавж өндөглөхдөө тусгай бортогонд өндгөө гаргадаг.

Авгалдай: Өндөгнөөс дөнгөж гарсан авгалдайн бие цайвар цагаан өнгөтэй, нимгэн хальсан бүрхүүлтэй байдаг. Хальсан бүрхүүл, эд эрхтнүүд нь хэд хэдэн цаг, хэдэн өдрийн дараагаар хатуурч бараан өнгөтэй болон идэвхтэйгээр хооллон тухайн шатны өсөлт хөгжилтөө хангана. Хөрс ургамлын эд эрхтэн доторх авгалдайн өнгө цайвар шаргал, цагаан өнгөтэй байдаг.

Хайрсан далавчтаны багийн шавжийн өндөгнөөс гарсан үр удмыг хүрэнцэр гэж нэрлэж заншсан байдаг. Хүрэнцэр идэвхтэй хооллосны дараа биеийн шинэ залуу эс, эд

эрхтнүүдийн хөгжил нэмэгддэг. Гэвч гаднах бүрхүүл нь өсөж томордоггүй, сунадаггүй учраас гаднах хальсаа гуужиж гээдэг. Гуужилт явагдсанаар хүрэнцрийн эд эрхтнүүдийн өсөн томрох бололцоог бий болгоно. Шавжийн өсөлтийн авгалдайн үе шат ой модонд хамгийн их хөнөөл учруулдаг. Учир нь дараагийн шатны авгалдайн гуужилт, өсөлт хөгжилтийг бүрэн явуулах биеийн доторх шимт бодисын хуримтлалыг бий болгохтой шууд холбоотой.

Хүүхэлдэй: Бүрэн хувиралтай шавжийн хүүхэлдэй бие гүйцсэн шат хоорондоо бүтцээрээ эрс ялгаатай. Хүүхэлдэй шатнаас бие гүйцсэн шатыг дамжихдаа эд эрхтнээ өөрчилдөг. Хүүхэлдэйн шатанд эрхтнүүдийн задралт явагдахын зэрэгцээ бие гүйцсэн шатны эрхтнүүд шинээр үүсэж хөгжиж бий болдог. Хүүхэлдэйг хэлбэр дүрсээр нь дөрөв ангилдаг.

Чөлөөт хүүхэлдэй



Бүрхүүлт хүүхэлдэй



Гэрт хүүхэлдэй



Гаднаас нь харахад сахал, далавч, хөл нь биед нь наалдсан байдалтай, тусгайлсан бүрхүүлгүй, чөлөөтэй хөдөлдөг.

Хэлбэр дүрс нь зуувандуу байхын зэрэгцээ гадна талаараа авгалдайн төгсгөлийн шатны дотоод шүүрлийн булчирхайгаас ялгаруулсан шүүрэл хатуурч бүрхүүл үүсгэдэг. Ийм хүүхэлдэйг гаднаас харахад далавч, сахал, хөл нэвт харагдах боловч хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байдаг.

Хайрсан далавчит багийн шавжийн хүрэнцэр төгсгөлийн шатандаа доод уруулдаа байрладаг мяндаслас шүүрэл гаргадаг булчирхайн тусламжтайгаар торгомсог гэр бэлтгэж, хүүхэлдэй шатанд шилждэг.

Монгол оронд 28 багийн 193 овог, 847 төрөлд хамаарах 14 мянга орчим зүйлийн шавж тэмдэглэгдсэнээс мод, бут, сөөгийн навч шилмүүс, иш холтос, модлог, үр жимс, үндсээр хооллон хөнөөл учруулдаг 8 баг 62 овог, 316 зүйлд хамаарах 737 зүйлийг эрдэмтэд, судлаачид илрүүлээд байна. Шавжийн идэш тэжээлийн эх үүсвэр нь болж өгдөг ургамал,

амьтан тэдгээрийн амьдран оршиход онцгой ач холбогдолтой. Шавжийн хооллох идэш тэжээлийн хэлбэр төрлийг харгалзан дараах янзаар нэрлэдэг /Хүснэгт 31/.

Хүснэгт-31

Ойн хөнөөлт шавжийг идэш тэжээлийн ангилал

| № | Экологийн бүлэглэл | Баг | Овог | Төрөл | Зүйл | Эзлэх хувь |
|-------------|--------------------------------|----------|-----------|------------|------------|------------|
| 1 | Үр боргоцойгоор хооллогч | 6 | 15 | 19 | 22 | 3 |
| 2 | Нахиа найлзуураар хооллогч | 5 | 2 | 5 | 5 | 1 |
| 3 | Навч, шилмүүсээр хооллогч | 7 | 35 | 181 | 363 | 49 |
| 4 | Иш, холтос, модлогоор хооллогч | 6 | 23 | 134 | 332 | 45 |
| 6 | Үндэсээр хооллогч | 3 | 6 | 13 | 15 | 2 |
| НИЙТ | | 7 | 62 | 316 | 737 | 100 |

Шавжийн дийлэнх хэсэг нь ургамлаар хооллодог ба шавжийн хоол тэжээл болдоггүй ургамал гэж бараг байдаггүй. Ургамалаар хооллогч шавж нь өөрсдийн хоол тэжээл болдог ургамлыг харилцан адилгүй сонгож хооллодог учир энэхүү байдлыг харгалзан идэш тэжээлээр нь доор дурдсан байдлаар нэрлэнэ.

- Монофаг: Ганц зүйлийн ургамлаар хооллодог шавж
- Олифаг: Нэг овог, төрөлд хамаарах ургамлаар хооллодог шавж
- Полифаг буюу элдэв идэшт: Олон овог, төрөл зүйлийн ургамлаар хооллодог шавж
- Пантофаг буюу олон янзын идэшт: Ургамал, амьтны гаралтай тэжээлээр хооллогч

Манай улсад тэмдэглэгдсэн ойн хөнөөлт шавжууд дотроос их хэмжээний газар нутаг хамран тархсан Сибирийн хүр, Якобсоны төөлүүрт, Бургасны бийрэн сүүлт, Эгэл бийрэн сүүлт, Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй, Шинэсний холтосч том цох, Алтайн ба нарийн сахалт эвэрт цох, Шинэсний урын ялаа, Зургаан шүдэт холтосч цох, Нарсны мөлгөр цох, Нарсны үрийн давирхайч, Сибирийн хатан ногоон жулга, Шинэсний шөвгөр хошуут зэрэг 40 гаруй зүйлийн онцгой аюулт гоц хөнөөлт шавж Хангай, Хэнтий, Хөвсгөл, Алтайн уулархаг мужийн аль их ойтой хэсэгт тархаж чийг, хур тунадсаар дутмаг, хуурайшилт ихтэй жил богино хугацаанд үй олноороо үржин их хэмжээний ой модыг хөнөөн сүйтгэсээр байна.

Ойн хөнөөлт шавжийн голомтыг тогтоох: Агаарын температур, дулаан, хүйтний нөхцөл бүрэлдэн тогтсон, нарны илч хангалттай хүрэлцэхүйц, сийрэг хөрстэй, хөвд ихтэй, чийг тунадас хүрэлцээтэй, махчин, шимэгч шавжийн бүрдэл, тоо толгой бага, ойн өтгөрөл бага, залуу зулзаган мод ихтэй, идэш тэжээл хүрэлцэхүйц байдаг орчин зүйн таатай нөхцөл бүрэлдсэн ой нь ойн хөнөөлт шавжийн анхдагч буюу үндсэн голомт болно.

Ойн хөнөөлт шавж хоол тэжээл дутагдсан үедээ тус үндсэн голомтоос тал бүр тийшээ салбарлаж тархан туслах голомтыг үүсгэдэг. Туслах буюу хоёрдох голомт нь үндсэн голомттой харьцуулахад хөнөөлт шавжийн тоо толгой цөөн, амьдрах нөхцөл тааруу, идэш тэжээл хүртээмж муу байдаг. Энд цөөн тохиолдолд ойн хөнөөлт шавж олшрон ой модонд хөнөөл учруулдаг. Ийм ойг хөнөөлт шавжийн туслах голомт гэж нэрлэнэ.

Эдгээр голомтуудаас гадна бас нүүдлийн голомт гэж байдаг. Өрөөсгөл хүр, сибирийн хүр, яacobсоны төөлүүр, шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэйн хүрэнцэр үндсэн ба туслах голомтоос мөлхөх буюу салхины урсгалаар хол зайд хаягдаж нүүдлийн голомт үүсгэдэг. Эрвээхэйнүүд нисэж, эмэгчин эрвээхэй өндгөө тохиромжтой орчинд шахах зэргээр тархалтын голомт тэлэгддэг боловч үндсэн голомтоосоо хол тасарч бүрэн чаддаггүй.

Хөнөөлт шавжийн голомт үүсэж болох газруудад судалгааг тогтмол явуулж хөнөөлт шавж ой модны навч, шилмүүсийг идэж сүйтгэж байгаа байдал, хөнөөлийн түвшин, тэдгээрийн тархалтын цар хүрээг тогтоож тэмцэх арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байдаг.

Модны хөнөөлт шавжид идэгдэж, гэмтэж хөнөөгдсөн байдалд үнэлэлт өгөхдөө дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- нийт навч, шилмүүсний 50-75 хувь нь идэгдсэн бол их;
- нийт навч шилмүүсний 25-50 хувь нь идэгдсэн бол дунд;
- нийт навч шилмүүсний 25 хувь түүнээс бага хэмжээтэй идэгдсэн бол бага нэрвэгдсэн гэж үздэг.

Ойн хөнөөлт шавжийн голомтыг илрүүлж ой зохион байгуулалтын материал ашиглан талбайн хэмжээг тооцож, тархалтыг гарган зураглал хийж цуглуулна.

Хөнөөлт шавжийн тооны хөдлөл зүй, хэт олиролтыг тогтоох арга: Ойн хөнөөлт шавжийн байгальд үржих, олшрох тооны хөдлөл зүйг дөрвөн үе шатанд хувааж үздэг. Үүнд:

Эхэн үе: Ой модны гол хөнөөлт шавжийн үрждэг амьдралын хамгийн тохиромжтой нөхцөл бүрэлдэж буй болоход сибирийн хүр, өрөөсгөл хүр, шинэсний шилмүүс хуйлагч, яacobсоны төөлүүр, бийр сүүлт зэрэг эрвээхэйнүүд үй олноороо нисэж эвцэлдээнд орж хамгийн дээд хэмжээгээрээ өндөг гаргана. Өндөгнөөс анхны хүрэнцэрүүд гаран ой модыг төдийлөн их хэмжээгээр идэж шарлуулж чаддаггүй. Энэ үеийг хөнөөлт шавжийн тооны өсөлтийн үе буюу эхэн үе гэж нэрлэдэг.


Хоёрдугаар үе: Хөнөөлт шавж цаашид үржин олшрох энэ үед байгаль дахь шимэгч болон махчин шавжийн тоо цөөн, ойн шувуудын нөлөө зохих хэмжээнд хүрэхгүй, өвчин үүсгэгчид бараг байхгүй байдаг бөгөөд ойн хөнөөлт шавжийн хөгжилд тохиромжтой цаг агаарын нөхцөл бүрэлдсэн тохиолдолд ой модонд асар их хөнөөл учруулж эхэлдэг.

Хөнөөлт шавжийн тоо толгой дээд цэгтээ хүрч нэг модонд дунджаар 4000-25000 хүртэл олширч модны навч, шилмүүс, нахиа, найлзуур зэрэг бүх эрхтнээр хооллож ой модыг ахар богино хугацаанд хувхайлан идэж хатаана. Энэ үе нь 1-3 жил үргэлжилдэг боловч хөнөөлт шавжийн зүйл бүрт өөр өөр байна.

Энэ үед тухайн хөнөөлт шавжаар хооллогч ашигтай шавж, шувууд үржин олширч элдэв халдварт өвчин дэлгэрэх тул тэдгээрийн цаашдын тархалтын цар хүрээ, тоо толгой эрс хязгаарлагдана. Нөгөө талаас идэш тэжээлийн нөөц хүрэлцэхгүй болж эхэлдэг. Энэ үеийг үй олноор үржих үе буюу хоёрдугаар үе гэж нэрлэнэ.

Гуравдугаар үе: Навч, шилмүүс, нахиа, найлзуур, залуу мөчрийг хүртэл идэж дуусгасны улмаас хөнөөлт шавжид идэш тэжээлийн хомсдол бий болж өлсгөлөн байдалд орно. Мөн тэдгээрээр хооллогч махчин, шимэгч зэрэг ашигтай шавж, шувуу болон өвчин ихээр гардаг тул цаашид үржих боломжгүй болж үржлийн уг голомт бууралтанд орно. Энэ үе 1-2 жил үргэлжилнэ.

Дөрөвдүгээр үе: Хөнөөлт шавжийн тоо толгой байгалийн тэнцвэрт байдалдаа хүртэл буурах тул ой модонд хор уршиг тарихаа больж, идэгдсэн ургамал бараг үзэгдэхээ болино. Энэ үеийг дөрөвдүгээр үе буюу популяци хэвийн байдалдаа орсон үе гэнэ. Энэ үед хортон цөөрч үүнийг даган түүгээр хооллогч шавж, шувууд хомсдон, өвчин эмгэг эрс багасна. Тооны хөдлөл зүйн эхний хоёр шатанд оновчтой хугацааг сонгож тэмцлийн ажлыг явуулдаг. Ойн хөнөөлт шавжийн тооны хөдлөл зүй аль шатандаа явааг популяцид тооны болон чанарын шинжилгээ хийж тогтоодог.



Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох судалгааны ажилд тухайн салбарын шинжлэх ухаанд нийтээр хэрэглэгддэг, хүлээн зөвшөөрч, шалгагдаж батлагдсан арга барил буюу судалгааны арга зүйг ашигладаг. Судалгааны арга зүйн ач холбогдол нь дахин давтагдах, харьцуулах, нотлох, дүгнэх боломжоор хангахад оршино. Судалгааны ажилд тухайн бүс нутагт ашиглахуйц, мэдээллийг харилцан солилцох боломжтой, энгийн хэрэглэхэд хялбар, эсвэл шинжлэх ухааны салбарын байгууллагаар хэлэлцэгдэж батлагдсан, нийтээр хүлээн зөвшөөрсөн судалгааны хуудас, тооллого, бүртгэлийн хуудас, баримтыг ашиглана. Арга зүйн дагуу гүйцэтгэсэн судалгааны үр дүнг тухайн зүйлийн хөнөөлт шавжаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд ашиглана. Тухайлбал:

Ажиглах (Тоо толгой өсөлт, бууралт)

Хамгаалах (тоо толгой өсөж эхэлбэл хязгаарлах)

Судалгаанд хамрагдах талбай, байршил нутгийг тодорхойлохдоо хэлэлцэж тохирсон эсвэл санаандгүй байдлаар дээж талбайнуудыг сонгож, тэндээ байнгын судалгааны замналуудаар гүйцэтгэдэг. Судалгааны ажлын давтамж нь жилд, улиралд, сар бүр эсвэл долоо хоног бүр нэг удаа тодорхой ижил хугацаанд эхэлж дуусгана. Судалгаанд тухайн бүс нутагтаа эсвэл хариуцан хамгаалж буй нутгийнхаа нийт талбайг бүрэн хэмжээгээр хамарч чадах боломжоор хомс байдаг тул төлөөлж, илэрхийлж чадах тодорхой газрыг сонгон авч судалдаг. Судлаачид үүнийг мэргэжлийн түвшинд сорилын талбай гэж нэрлэдэг. Дээж талбайг сонгохдоо санаандгүй эсвэл зорилготойгоор сонгож авдаг.

Увс аймгийн ойн санд навч, шилмүүсний хөнөөлт шавжийн зүйлийн бүрэлдэхүүн, тархалтын цар хүрээ, биологи-экологийн онцлогийг тогтоох судалгааны ажлыг 2011-2020 онуудад жил бүр хавар намрын гэсэн 2 үе шаттайгаар явуулсан байдаг. Судалгааны ажлын үр дүнд ойн хөнөөлт шавжийн тархалттай, голомт үүсгэж байгаа талбайн хэмжээг тодорхойлж, тоо толгой нягтшилыг бууруулах тэмцлийн ажлыг тохирох арга технологийн дагуу гүйцэтгэж байсан. Сүүлийн арван жилийн дунджаар улсын төсвийн хөрөнгөөр Увс аймгийн ойн сан бүхий 13 суманд жил бүр 1.0-28.0 мян.га талбайд ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох тоймчилсон судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн /Хүснэгт 32/.

Хүснэгт-32

Ойн хөнөөлт шавжийн судалгаанд хамрагдсан талбайн хэмжээ, га

| № | Судалгаанд хамрагдсан он | Судалгаанд хамрагдсан сумын нэр | Судалгаа явуулах төлөвлөгөө (га) | Судалгаанд хамрагдсан талбай (га) |
|------------|--------------------------|---------------------------------|----------------------------------|-----------------------------------|
| 1 | 2011 он | Баруунтуруун | 10000 | 1000 |
| 2 | | Зүүнхангай | 5000 | 4569 |
| 3 | | Малчин | 5000 | 2077 |
| 4 | | Наранбулаг | 3000 | 2000 |
| 5 | | Өндөрхангай | 5000 | 1000 |
| 6 | | Түргэн | 5000 | 500 |
| 7 | | Улаангом | 1000 | 500 |
| 8 | | Ховд | 1000 | 1000 |
| 9 | | Хяргас | 5000 | 2595 |
| 10 | | Цагаанхайрхан | 2000 | 1630 |
| Дүн | | | 42000 | 16871 |
| 1 | 2012 он | Баруунтуруун | 10000 | 10000 |
| 2 | | Бөхмөрөн | 1000 | 826 |
| 3 | | Зүүнхангай | 10000 | 10000 |
| 4 | | Малчин | 7000 | 6801 |
| 5 | | Наранбулаг | 1000 | 10000 |
| 6 | | Өндөрхангай | 15000 | 15000 |
| 7 | | Сагил | 15000 | 12265 |
| 8 | | Түргэн | 10000 | 10000 |
| 9 | | Хяргас | 10000 | 9037 |
| 10 | | Цагаанхайрхан | 15000 | 15000 |
| Дүн | | | 112000 | 115117 |
| 1 | 2013 он | Баруунтуруун | 15000 | 12368 |
| 2 | | Бөхмөрөн | 3000 | 1697 |

| | | | | |
|------------|---------|---------------|---------------|---------------|
| 3 | | Зүүнхангай | 20000 | 18399 |
| 4 | | Малчин | 10000 | 8889 |
| 5 | | Наранбулаг | 10000 | 6743 |
| 6 | | Өндөрхангай | 20000 | 15187 |
| 7 | | Сагил | 15000 | 13228 |
| 8 | | Түргэн | 20000 | 18879 |
| 9 | | Улаангом | 5000 | 4051 |
| 10 | | Хяргас | 10000 | 9361 |
| 11 | | Цагаанхайрхан | 20000 | 15879 |
| Дүн | | | 148000 | 124681 |
| 1 | 2014 он | Баруунтуруун | 10000 | 13400 |
| 2 | | Зүүнхангай | 10000 | 1565 |
| 3 | | Малчин | 10000 | 4000 |
| 4 | | Наранбулаг | 7000 | 130 |
| 5 | | Өндөрхангай | 15000 | 3468 |
| 6 | | Хяргас | 10000 | 9361 |
| 7 | | Цагаанхайрхан | 10000 | 66 |
| Дүн | | | 62000 | 31924 |
| 1 | 2015 он | Баруунтуруун | 10866 | 12601 |
| 2 | | Зүүнхангай | 22939 | 13625 |
| 3 | | Малчин | 7356 | 7729 |
| 4 | | Наранбулаг | 6541 | 12833 |
| 5 | | Өндөрхангай | 10000 | 9234 |
| 6 | | Сагил | 10000 | 5623 |
| 7 | | Түргэн | 10000 | 12892 |
| 8 | | Хяргас | 9378 | 8808 |
| Дүн | | | 87080 | 83345 |
| 1 | 2016 он | Баруунтуруун | 10866 | 19493 |
| 2 | | Зүүнхангай | 22939 | 3443 |
| 3 | | Малчин | 7356 | 8090 |
| 4 | | Наранбулаг | 6541 | 600 |
| 5 | | Өндөрхангай | 10000 | 4586 |
| 6 | | Сагил | 10000 | 10000 |
| 7 | | Түргэн | 10000 | 16820 |
| 8 | | Улаангом | 13540 | 20 |
| 9 | | Ховд | 13539 | 160 |
| 10 | | Хяргас | 9378 | 902 |
| 11 | | Цагаанхайрхан | 13538 | 966 |
| Дүн | | | 127697 | 65080 |
| 1 | 2017 он | Баруунтуруун | 20000 | 27608 |
| 2 | | Бөхмөрөн | 3000 | 3000 |
| 3 | | Зүүнхангай | 25000 | 26000 |
| 4 | | Малчин | 13000 | 28000 |
| 5 | | Наранбулаг | 12000 | 12000 |
| 6 | | Өндөрхангай | 25000 | 28500 |
| 7 | | Сагил | 15000 | 15000 |
| 8 | | Түргэн | 20000 | 27000 |
| 9 | | Улаангом | 2000 | 2000 |
| 10 | | Ховд | 9000 | 9000 |
| 11 | | Хяргас | 15000 | 18000 |
| 12 | | Цагаанхайрхан | 5000 | 5000 |

| | | | | |
|------------|---------|---------------|---------------|---------------|
| Дүн | | | 164000 | 186708 |
| 1 | 2018 он | Баруунтуруун | 15000 | 7739 |
| 2 | | Бөхмөрөн | 3000 | 3000 |
| 3 | | Зүүнхангай | 20000 | 6098 |
| 4 | | Малчин | 10000 | 3662 |
| 5 | | Наранбулаг | 8000 | 4299 |
| 6 | | Өндөрхангай | 20000 | 6285 |
| 7 | | Сагил | 10000 | 1000 |
| 8 | | Түргэн | 15000 | 5000 |
| 9 | | Улаангом | 2000 | 2000 |
| 10 | | Ховд | 5000 | 5000 |
| 11 | | Хяргас | 15000 | 6044 |
| 12 | | Цагаанхайрхан | 5000 | 2726 |
| Дүн | | | 128000 | 52853 |
| 1 | 2019 он | Баруунтуруун | 15000 | 3800 |
| 2 | | Бөхмөрөн | 3000 | 3000 |
| 3 | | Давст | - | 5000 |
| 4 | | Зүүнхангай | 20000 | 4000 |
| 5 | | Малчин | 10000 | 4525 |
| 6 | | Наранбулаг | 8000 | 5200 |
| 7 | | Өндөрхангай | 20000 | 15000 |
| 8 | | Сагил | 10000 | 8000 |
| 9 | | Түргэн | 15000 | 15000 |
| 10 | | Улаангом | - | 3000 |
| 11 | | Ховд | - | 3000 |
| 12 | | Хяргас | 10000 | 4500 |
| 13 | | Цагаанхайрхан | 2000 | 1000 |
| Дүн | | | 113000 | 75025 |
| 1 | 2020 он | Баруунтуруун | 15000 | 10000 |
| 2 | | Бөхмөрөн | 3000 | 3000 |
| 3 | | Давст | 20000 | 4000 |
| 4 | | Зүүнхангай | 10000 | 8000 |
| 5 | | Малчин | 8000 | 6000 |
| 6 | | Наранбулаг | 20000 | 11000 |
| 7 | | Өндөрхангай | 10000 | 8000 |
| 8 | | Сагил | 0 | 1000 |
| 9 | | Түргэн | 10000 | 15000 |
| 10 | | Улаангом | 2000 | 3000 |
| 11 | | Ховд | 5000 | 3000 |
| 12 | | Хяргас | 15000 | 10000 |
| 13 | | Цагаанхайрхан | 5000 | 2000 |
| Дүн | | | 123000 | 84000 |

Увс аймгийн ойн санд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг тогтоох , тэмцлийн ажил явуулах талбайг сонгох судалгааны ажлын дүнгээс үзэхэд сүүлийн арван жилд дунджаар 83.5 мян.га талбай судалгаанд хамрагдсан байна. Судалгааны дүнг нэгтгэн үзэхэд навч, шилмүүсний хөнөөлт шавжийн тархалттай гэж тогтоогдсон талбай сүүлийн арван жилийн дунджаар 27.9 мян.га байна. Навч шилмүүсний хөнөөлт шавжийн голомт үүссэн сүүлийн арван жилийн дунджаар 19.8 мян.га талбай байна. /Хүснэгт 33/.

Хүснэгт-33


Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомттой талбайн хэмжээ

| № | Судалгаанд хамрагдсан он | Судалгаанд хамрагдсан талбай (га) | Тархалттай талбай (га) | Голомттой талбай (га) | Шавжийн зүйлийн нэр |
|-----------------|--------------------------|-----------------------------------|------------------------|-----------------------|--|
| 1 | 2011 | 16871 | - | 17553 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Erannis jacobsoni</i> Djak <i>Orgyia antiqua</i> L |
| 2 | 2012 | 115117 | 3948 | 19054 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L |
| 3 | 2013 | 124681 | 91183 | 27530 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L |
| 4 | 2014 | 31924 | 19485 | 22020 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L <i>Erannis jacobsoni</i> Djak |
| 5 | 2015 | 83345 | 61070 | 8566 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Orgyia antiqua</i> L <i>Erannis jacobsoni</i> Djak |
| 6 | 2016 | 65080 | 17764 | 13484 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L <i>Erannis jacobsoni</i> Djak |
| 7 | 2017 | 186708 | 31500 | 25000 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L <i>Erannis jacobsoni</i> Djak |
| 8 | 2018 | 52853 | - | 25301 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Orgyia antiqua</i> L |
| 9 | 2019 | 75025 | 35773 | 18981 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L |
| 10 | 2020 | 84000 | 18575 | 20927 | <i>Coleophora sibirica</i> Flkv <i>Dendrolimus superans sibiricus</i> Tschetv <i>Orgyia antiqua</i> L |
| Нийт дүн | | 835604 | 279298 | 198416 | - |

Увс аймгийн ойн санд сүүлийн арван жилийн хугацаанд навч шилмүүсний хөнөөлт шавжууд дотроос Шинэсний дугтуйт эрвээхэй /*Coleophora sibirica* Flkv/, Сибирийн хүр эрвээхэйн /*Dendrolimus sibiricus* Tschetv/, Эгэл бийрэн сүүлт эрвээхэйн /*Orgyia antiqua* L/, Якобсоны төөлүүрч эрвээхэй /*Erannis jacobsoni* Djak/ зэрэг хөнөөлт шавжууд голомт үүсгэн хөнөөл учруулж байгааг нь судалгааны ажлын дүнд тогтоогдсон болно. Эдгээр навч

шилмүүсний хөнөөлт шавжийн хэт олшролын үе 2012-2014 он, 2016-2018 онуудад тохиосон бөгөөд 2021 оноос олшрол дахин тохиолдох магадал байгааг судалгааны ажлын үр дүнд тогтоогоод байна. /График-11/

График-11



Увс аймгийн ойн санд зонхилон хөнөөл учруулж буй навч шилмүүсний хөнөөлт шавжийн хөгжил, учруулж буй хор хөнөөл, тэмцлийн ажил явуулах оновчтой хугацаа, хөгжлийн хуанли зэргийг доор оруулав.

Сибирийн хүр эрвээхэй (*Dendrolimus superans sibiricus*)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг хүр эрвээхэй (Lasiocampidae)-н овогт орно. Өмнөд далавч нь саарал өнгөтэй, дээд талдаа хар хүрэн судлуудтай, түүний хоёр нь далавчны үзүүрт ойрхон байрладаг. Далавчны дээд хэсэгт муруй тахир судал байх ба голын хэсэгтээ цагаан толботой.



Зураг-16. Сибирийн хүр эрвээхэйн хөгжлийн үе шат, хөнөөл учруулах байдал

Эрвээхэйн бие үнсэн саарал ба хар саарал үсээр бүрхмэл юм. Эрэгчний сахал нь дэл хэлбэртэй, эмэгчнийх богинохон дэл хэлбэртэй байдаг. Далавчны дэлгэмэл эмэгчнийх 65-90 мм, эрэгчнийх 50-80 мм урттай.

Нэг эмэгчин эрвээхэй дунджаар 250-330 ширхэг өндөг гаргадаг бөгөөд өндөгнөөс 15-25 хоногийн дараагаар хүрэнцэр бий болж 2-3 удаа гуужин томорч, биеийн урт 0.1-0.5 см болохын хамт 9-р сарын эхээр хөрсний өнгөн хэсэгт 2-6 см-ийн гүнд орж ичдэг. Дараа жилийн хавар 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр ичээнээс гарч модонд авиран, намар орой болтол 3-4 удаа гуужиж, өсөж томорсны эцэст 53.3 мм орчим урттай болж, дахин хөрсөнд орж ичдэг.

Дараа жилийн хавар ичээнээс гарсан хүрэнцэр богино хугацаанд хэд хэдэн удаа гуужиж, хөгжин 8.5 см хүртэл өсдөг ба 5-р сарын дунд үеэс 6-р сарын сүүлч хүртэл 35-40 хоногийн дотор модны шилмүүсийг асар богино хугацаанд идэж сүйтгэдэг. Өөрөөр хэлбэл 3-дахь жилдээ ичээнээс гарсан хүрэнцэр нь хүүхэлдэй, бие гүйцсэн эрвээхэй болоод эвцэлд

орж өндгөө шахаад үхэх хүртэлх хугацаандаа хэрэглэгдэх идэш тэжээл бүхий энергиэ нөхөн авдаг.

Нас гүйцсэн хүрэнцрийн хоёр, гуравдугаар цагариг дээр хөхөвтөр туяатай, хөндлөн хар судалтай, богинохон үстэй, харин 3, 4-р үеүд дээр хар хөх өнгийн багц үс бий. Биеийн бүх гадаргуу нэлээд урт үсээр бүрхмэл ба нуруун талынх хар өнгөтэй, хажуу талынх мөнгөлөг саарал өнгөтэй. Хүүхэлдэй хар хүрэн буюу хар өнгөтэй, 40-60 мм урт. Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр бүх төрлийн модонд хөнөөл учруулдаг. Гэхдээ ихэвчлэн Шинэс, Хушны шилмүүсээр хооллодог. 7-12 насны залуу шилмүүст модонд 10-24 ширхэг хүрэнцэр ноогдвол уг мод нөхөн ургах чадвараа 100 хувь алддаг байна. Идэш тэжээл хүрэлцэхгүй үед модны залуу мөчир, холтос, боргоцой зэргээр хооллодог байна.

Тэмцэх хугацаа: Хамгийн оновчтой хугацаа нь хүрэнцэр шилмүүсээр хооллож байх үе буюу эхний жил хавар 5-сарын 25-аас 6-р сарын 20-ны хооронд, намар 8-р сарын 10-аас 10-р сарын 01-ны хооронд, хоёр дахь жил 5-р сарын 25-аас 10-р сарын 01-ны хооронд байдаг.

Өрөөсгөл хүр эрвээхэй (Lymintria dispar L.)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг Оргид (Orgyidae)-ийн овог.

Өрөөсгөл хүр эрвээхэйн эмэгчин эрвээхэй нь 8-р сарын сүүлч, 9-р сарын эхээр эвцэлдээд орж, 350-450 ш өндгийг хад асга ихтэй бартаатай, тогтмол гэрэл гэгээтэй байдаг, байшингийн нүүр, төмөр замын буудал, модны ан цав завсар зэрэг янз бүрийн газар өндөглөнө. Өндөг үе шатандаа ил өвөлждөг. Өвөлжсөн өндөгнөөс хавар 5-р сард хүрэнцрүүд гарч ирэхийн хамт модны аль залуу шилмүүс, навч нахиагаар хооллож, эхлэх бөгөөд их олширсон жилдээ модонд нэг ч навч, шилмүүс үлдээлгүй иддэг, ойн гол аюултай хөнөөлт шавж юм.

Хүрэнцэр 40-50 хоногийн туршид амьдрах хугацаандаа эр хүрэнцэр 5 удаа, эм хүрэнцэр нь 6 удаа гуужиж өсдөг. Хүрэнцэр нь 7-р сарын дунд үеэс эхлэн хүүхэлдэйн хөгжилд шилжиж, улмаар 15-20 хоногийн дараагаар эрвээхэй болно. 8-р сарын дундуур тогтуухан дулаахан өдөр Өрөөсгөл хүр эрвээхэй үй олноороо нисэж эвцэлдээд орон өндөглөнө. Хад асган дахь өндөгнөөс хавар эрт анхны хүрэнцэр бий болохын хамт хэд хэдээрээ нийлж шүлсээрээ томоохон тор нэхдэг. Ингээд нэхсэн торны хамтаар алс газар хаягдан шинэ шинэ голомтуудыг үүсгэдэг. Хавар эрт уул хад асга цагаан цайвар тороор бүрхэгдсэн байвал тэд Өрөөсгөл хүр эрвээхэйн хүрэнцэр байна гэсэн шинж тэмдгийг заахаас гадна уг торыг цуглуулан авч шатаах буюу устгаснаараа цаашид үржин олшрох замыг хааж болдог механик арга байдаг. Уг эрвээхэйн хүрэнцэр мод, модлог ургамлуудын навч, шилмүүсээр хооллоод зогсохгүй 300 гаруй зүйлийн ургамлаар хооллодог хөнөөлт шавж юм. Тэмцэх хугацаа: Тэмцэл явуулах хамгийн оновчтой хугацаа нь хүрэнцэр ид хооллож байх үе болон өндгөн үе шатандаа байх үе буюу 5-р сарын 25-аас 8-р сарын 1-ний хооронд болно. Ялангуяа хад асга байшин барилга, байгууламжийн ан завсраар гэрэлд татагдан ирж өндгөө шахсан өндгийг гараар түүж устгаж тэмцэл явуулах нь илүү үр дүнтэй байдаг бөгөөд намар 9-р сарын 10-аас 10-р сарын 20-ны хооронд, хавар 4-р сарын 15-аас 5-р сарын 20-ны хооронд тэмцэл явуулж болно.



Зураг-17. Өрөөсгөл хүр эрвээхэйн хөгжлийн үе шат, хөнөөл учруулах байдал

Якобсоны төөлүүрч эрвээхэй (Erannis jacobsoni Diak)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг төөлүүр (Geometridae)-ийн овог.

Бие гүйцсэн эрвээхэйн биед хүйсийн ялгаа буюу бэлгийн демофизм тод илэрдэг. Өөрөөр хэлбэл, эр, эм эрвээхэй өөр хоорондоо гадаад бүтэц, хэлбэрээрээ эрс ялгаатай байдаг.

Хүрэнцрийн бойжилт буюу гуужилтын тоо нь газар зүй ой ургамалжилтын онцлогоос шалтгаалж, тархсан газар бүрд харилцан адилгүй байна. Хүрэнцэр нь идэвхтэй, идэвхгүй гэсэн орон зайд шилжих хөдөлгөөн хийдэг. Биеийн булчин, махбод хөлийн тусламжтайгаар идэш тэжээл хэрэглэхийн тулд төөлөх хэлбэрийн идэвхтэй хөдөлгөөн хийдэг. Ийм шинж уг овгийн хүрэнцэр түгээмэл тул төөлүүр эрвээхэйн овог гэж нэрлэсэн. Эрэгчин нь тод цайвар өнгийн далавчтай түүний дэлгэмэл урт 2.5-2.8 см хүрдэг, өмнөд далавч нь бараан өнгийн хөндлөн судалтай, сам хэлбэрийн утаслаг сахалтай, эм эрвээхэй далавчгүй бөгөөд хар, цагаан өнгийн үсээр битүү хучигдсан тул энгийн нүдээр алаг өнгөтэй харагддаг. Биеийн урт

2 см. Тод шар өнгөтэй зууван хэлбэртэй, барзгар гадаргуутай, урт нь 10 мм, өргөн нь 6-6.5 мм байдаг. Уг эрвээхэйн өндөг модны холтосны ан завсар байрладаг.



Зураг-18. Якобсоны төөлүүрч эрвээхэйн хөгжлийн хүрэнцрийн үе шат, ойд хөнөөл учруулсан байдал

Шүлсний тусламжтай модны оройгоос доош буюу нэг мөчрөөс нөгөө мөчирт босоо чиглэлийн дагуу идэвхгүй шилжих хөдөлгөөн хийдэг. Хүрэнцэр нь 4-5 удаа гуужсаны дараа хүүхэлдэйн шатанд шилждэг. Хүүхэлдэйн бие нь гялалзсан тод хүрэн өнгөтэй, гаднаа уутан бүрхүүлгүй чөлөөт хэлбэртэй, биеийн төгсгөл нь сэрээ хэлбэртэй хурц байна. Биеийн урт нь эр, эм хүүхэлдэйд ижил байдаг боловч биеийн өргөн нь эм хүүхэлдэйд эрийнхээс 0.3 мм-ээр, биеийн жин 10 мгр-аар илүү байдаг. Эмэгчний биеийн жин нь ойролцоогоор 89.3 мгр, эрэгчнийх 79.3 мгр байна. Хүүхэлдэй нь хөрсний өнгөн давхраанд толгойн хэсэг нь доош

харан байрлана. Якобсоны төөлүүрч эрвээхэйн хүрэнцэр шинэсний шилмүүсийг үгүйртэл идэж амьдралын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг.

Тэмцэх хугацаа: Тэмцэл явуулах хамгийн оновчтой хугацаа нь төөлүүр эрчимтэй хооллож байх үе буюу 5-р сарын 25-аас 7-р сарын 15-ны хооронд.

Эгэл бийрэн сүүлт эрвээхэй (Orgyia antiqua L.)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг, Оргид (Orgyidae)-ийн овог. Эрэгчин эрвээхэй бор шаргал зүстэй, өмнөд далавчны хойд зах орчимд таслал маягийн тод цагаан толботой, дэл хэлбэрийн сахалтай, дэлгэмэл далавчны урт 25-30 см, эмэгчин эрвээхэйн далавч дөнгөж мэдэгдэм төдийхөн байдаг тул нисэж чаддаггүй, харин хөлийн хөгжил сайн, бүдүүн махлаг биетэй, бор саарал өнгөтэй байдаг. Өндөг нь бөөрөнхий хэлбэртэй хоорондоо нягт наалдсан, бүдэг сааралдуу өнгөтэй.

Хүрэнцэр бор хүрэн өнгөтэй, хэвлийнхээ төгсгөлд нэг, толгойн хойд хэсэгт ба хэвлийн хоёр хажууд нэг хос бор өнгийн бийр хэлбэрийн багц үстэй, хэвлийн 4-8-р цагариг дээр шар өнгийн сойз хэлбэрийн багц үстэй, биеийн урт 30-35 мм байдаг. Хүүхэлдэй нь гялалзсан хар бараан өнгөтэй, 15-18 мм урт, биеийнхээ төгсгөлд гох дэгээтэй бөгөөд түүний тусламжтайгаар модны мөчрөөс зүүгдэн байрлана.

Эрвээхэй 7-р сарын сүүлч, 8-р сарын эхээр эвцэлд ороод уг сарын дундуур өндөглөнө. Эмэгчин эрвээхэй өндгөө багц багцаар 230-300 ш өндгийг модны мөчир, холтос, ишний ан цав завсарт гаргадаг. Намар гарсан өндөг өвөлжиж дараа жилийн хавар мод нахиалах үеэр өндөгнөөс хүрэнцэр бий болж, модны залуу навч, шилмүүсээр хооллодог. Хүрэнцэр амьдралынхаа туршид 5 удаа гуужиж хөгжсөний эцэст хүүхэлдэйн шатандаа шилждэг. Хүүхэлдэйнээс 7-14 хоногийн дараагаар эрвээхэй гарч эвцэлд орно. Бийр сүүлт эрвээхэйн хүрэнцэр шинэс, хус, бургас, гацуур, жодоо зэрэг модны навч, шилмүүсээр хооллодог. Увс, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий зэрэг аймгийн нутагт тархсан байна. Тэмцэх хугацаа: Тэмцэх хамгийн оновчтой хугацаа нь хүрэнцэр шилмүүсээр хооллож байх үе буюу 5-р сарын 25-аас 7-р сарын 25-ны хооронд болно.



Зураг-19. Эгэл бийрэн сүүлт эрвээхэйн хөгжлийн үе шат, хөнөөл учруулах байдал

































Шинэсний дугтуйт эрвээхэй (Coleophora sibirica Flkv)

Сибирийн дугтуйт эрвээхэй нь ангилал зүйн хувьд Coleophoridae овогт хамаарна. Дугтуйт эрвээхэйн хөнөөлийн голомтыг алсаас харвал цас орсон мэт харагдана. Өндөг хагас бөмбөлөг хэлбэртэй, оройноосоо үл мэдэг нарийссан бөгөөд оройнхоо товгороос тал тал руугаа салаалсан хянгануудтай. Өндөгний хөндлөн огтлол 0.5 мм орчим байдаг. Дөнгөж шахагдсан өндөг шаргалдуу өнгөтэй, цаашдаа бараантана. Эм эрвээхэй өндгөө ганц ганцаар шилмүүст моддын шилмүүс дээр 6-7 сард шахагдана. Хүрэнцрийн бие 5-6 мм урт, улбар-

бор өнгөтэй, толгой хар, дагзны ар тал ба бамбайн цар бараан, голоороо цайвар өнгийн шулуунаар зааглагдана. Хүрэнцэр цээжиндээ 3 хос хөлтэй /Хүснэгт-34/.

Хүснэгт-34

Хөгжлийн хуанли

| 5-р сар | | | 6-р сар | | | 7-р сар | | | 8-р сар | | | 9-р сар | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 |
| | | |  |  |  |  | | | | | | | | |
| | | | | | |  |  |  |  |  |  |  |  |  |
|  |  |  | | | | | | | | | | | | |
| | |  |  |  | | | | | | | | | | |
|  |  | | | | | | | | | | | | | |
|  |  | | | | |  |  |  |  |  |  |  |  |  |



Хүрэнцрүүд 8 мм орчим урт хонгионцорт амьдарна. Хүрэнцэр шинэс модны шилмүүсэнд хаван үүсгэж 6 сарын эхэн үеэс намар хүртэл хооллож, модны ан цаваар орж өвөлжинө. 4 сарын сүүл 5 сарын эхээр холтосны ан завсраар тор татан өвөлжсөн хүрэнцрүүд гарч ирэн, хүүхэлдэйлж, 5 сарын сүүлээс 6 сарын эхээр ниснэ. Эвцэлдсэний дараа өндгөө шинэс модны шилмүүс дээр шахаж, хүрэнцэр шилмүүсний үзүүрээс хооллож, гандуу өнгөтэй болгоно /Зураг 3/. Тэмцлийн ажлыг агаарын хөлөг, үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар зохион байгуулдаг.



Зураг-20. Шинэсний дугтуйт эрвээхэйн хөнөөл

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Ойг хамгаалах арга хэмжээний салшгүй нэг чухал хэсэг нь ойн хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх тэдгээртэй тэмцэх ажил байдаг. Ойн хөнөөлт шавжаас хамгаалах араг хэмжээг урьдчилан сэргийлэх, тэмцэх гэсэн 2 хэлбэрээр явуулдаг. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ техник ажиллагааны хувьд:

1. Зохион байгуулалт
2. Судалгаа
3. Ойн аж ахуйн
4. Агротехникийн гэсэн 4 аргад хуваагдана.

Ойн хөнөөлт шавжийн хэт олшролт, хөнөөлийн байдал зэргийг цаг алдалгүй тооцоолж мэдэх, улмаар цаашдын арга хэмжээг төлөвлөх, тэмцлийн ажлыг зохион байгуулахад судалгааны арга чухал ач холбогдолтой байдаг.

Зохион байгуулалтын арга: Ой хамгааллын арга хэмжээний ойрын ба хэтийн төлөвлөгөөний дагуу ой зохион байгуулалтын үед төвлөрсөн төслийг хэрэгжүүлэх, боловсон хүчин бэлтгэх, хуваарилах, ой хамгааллын талаарх сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр зохиож сургалт, зөвлөгөө өгөх ажлууд орно.

Судалгааны арга: Судалгааг дотор нь ажиглалт, тоймчилсон, нарийвчилсан судалгаа гэж ангилна. Манай орны ойн аж ахуйн практикт эдгээр судалгааг хэрэгжүүлэх нь ойг хөнөөлт шавжаас хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Ажиглалт судалгааг ойн хөнөөлт шавж, өвчний тархалт, голомт үүсэж болзошгүй ойг байнгын хяналтдаа авч байх зорилгоор орон нутгийн байгаль орчны мэргэжилтэн, инженер, техникч, байгаль хамгаалагч нар гүйцэтгэж хөнөөлт шавж, өвчин илэрсэн нөхцөлд мэдээлэл өгнө.

Орон нутгаас ирсэн мэдээллийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-аас шуурхай арга хэмжээ авч ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Тоймчилсон судалгааны ажлыг тодорхой маршрутаар хэд хэдэн аймаг, сумдын нутгийг хамруулан явуулна.

Тоймчилсон судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд хуурайшилт, ойн түймэр зэргээс шалтгаалан хөнөөлт шавж, өвчний хуучин голомтууд сэргэн тархалт тэлэгдэх хандлагатай байна. Судалгааны ажлыг ойн хөнөөлт шавж, өвчний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд жил бүр зохион байгуулах шаардлагатай.

Нарийвчилсан судалгааг ойн зонхилогч хөнөөлт шавжийн биологийн онцлог шинж, тархалтын цар хүрээ, олшролын үе шатыг тогтоон улмаар ойн хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээг өөрийн орны цаг уурын онцлогт тохируулан боловсруулах зорилгоор явуулдаг. Манай орны хувьд хөнөөлт шавжийн үржин олширч, хор хөнөөл учруулах экологийн нөхцөл харьцангуй өндөр байгаа юм.

Судалгаанаас үзэхэд ойн хөнөөлт шавж нь гол төлөв 10-30 хэмийн налууд ургасан 16-20 метр өндөр, 20-28 см диаметртэй, ГҮ-Ү бонитетийн, 0.5-0.6 өтгөрөлтэй шинэсэн ойд үлэмж хэмжээгээр тархан хохирол учруулж байна. Ойг хөнөөлт шавжаас хамгаалах ойн аж ахуйн арга хэмжээ нь ойг хамгаалах үндсэн арга юм. Ойн аж ахуйн арга хэмжээнд дараах ажлууд орно. Үүнд:

- Үрийн модыг зөв сонгож, үр бэлтгэх байнгын талбайг сонгон тусгаарлаж үрийг технологийн дагуу түүх, хадгалах
- Шинжилгээгээр баталгаажсан үрийг тариалалтад бэлтгэх
- Хөнөөлт шавж өвөлждөг бут, сөөгийн эргэн тойрны хөрсийг эргүүлэх

-
- Тарьц, суулгац, зулзаган мод, өсвөр модыг хамгаалах
 - Ойн үндсэн ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг технологийн дагуу гүйцэтгэх
 - Бэлтгэсэн модыг удаан хугацаагаар хадгалахгүй байх

Эдгээр арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх нь хөнөөлт шавжаас ойг хамгаалах, илэрсэн голомтыг устгах ажлын үр дүнг дээшлүүлнэ.

Агротехникийн арга: Энэ аргад агротехникийн холбогдолтой арга хэмжээ багтах бөгөөд ургамлын өсөлт хөгжилтийг сайжруулахад чиглэгдсэн байдаг тул хөнөөлт шавжтай тэмцэхэд илүү зардал гаргадаггүй ашигтай арга юм. Агротехникийн аргыг хэрэглэн зөв зохион байгуулж чадвал хөнөөлт шавж ихээр үржих нөхцөлөөс ойжуулсан талбай болон мод үржүүлгийн газрыг урьдчилан сэргийлж болно.

Тэмцлийн арга хэмжээ: Нэгэнт гарсан хөнөөлт шавжийн тархалтыг хязгаарлах, хөнөөлийг багасгах, голомтыг арилгах зорилгоор тэмцлийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тэмцлийн арга хэмжээг гүйцэтгэх аргыг дотор нь агротехник, хими, биологи, физик-механик, хорио цээрийн гэж ангилна.

- Агротехникийн буюу агро экологийн арга нь тарьц, суулгацыг ургуулах үед хөнөөлт шавжид тохиромжгүй нөхцөл бүрдүүлж, ургамлын өсөлт хөгжилтөд тохиромжтой нөхцөлийг бий болгоно. Энэ аргыг мод үржүүлгийн газарт болон ойжуулалтын ажлын үед хэрэглэдэг. Тархсан хөнөөлт шавжийн зүйл ангийг тогтоосны үндсэн дээр дээрх ажлыг явуулна.
- Химийн арга нь ихэвчлэн янз бүрийн химийн бодисыг ашиглан их хэмжээгээр гарч ирсэн хөнөөлт шавжийг богино хугацаанд тархалтыг хязгаарлахад зориулагдана. Одоогоор химийн аргыг хэрэглэхээс нийтээр татгалзаад байна.
- Физикийн арга нь цахилгаан энерги, их бага температур, өндөр хүчдэл зэргийг хэрэглэн хөнөөлт шавжийн орчныг хувиргах юм уу хөнөөлт шавжийг шууд устгах зориулалттай байдаг.
- Механик арга нь янз бүрийн механик ажиллагаагаар хөнөөлт шавжтай тэмцэх явдал юм. Жишээлбэл: цох баригч, хүрэнцэр баригч, наалдуулах бүслүүр гэх мэт.
- Биологийн арга нь хөнөөлт шавжийн байгалийн дайсан паразит ба махчин шавж идэштэн шувуу, сүүн тэжээлтэн, шавжид өвчин үүсгэгч нян вирус, мөөг мэтийг хэрэглэн тэмцэх юм.
 - Хорио цээрийн арга хэмжээ нь аюултай хөнөөлт өвчин, шавжийг гадаад орноос өөрийн оронд нэвтрүүлэхгүй байх, орон нутаг дотор нөгөөд тархаахгүй байх арга хэмжээ орно. Манай оронд ойн навч, шилмүүсний хөнөөлт шавжтай тэмцэхэд хими, механик, биологийн аргыг хэрэглэдэг. Үндсэн голомт илэрсэн нутгуудад суурин ба нарийвчилсан судалгааг явуулж хөнөөлт шавжийн тоо толгойн хэлбэлзэл, улирлын ба хоногийн идэвх, хөгжлийн үе шатыг нарийвчлан тогтоож цаашид дэс дараалалтай тэмцэл хийх зохион байгуулалтын арга хэмжээний төсөл төлөвлөгөө боловсруулна. Юуны өмнө хөнөөлт шавжийн хөгжлийн үе шат, өсөх буурах хандлага, ашигтай шавжийн үйлчилгээний хэмжээ, цаг уурын урьдчилсан мэдээ, хүйсийн харьцаа зэрэг чухал үзүүлэлтийг тогтоосны үндсэн дээр дараагийн жилүүдийн тэмцэх ажлын төлөвлөгөөг боловсруулна.

Увс аймгийн ойн сан бүхий зарим сумдын ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын 2011-2020 онуудын гүйцэтгэлээс үзэхэд 2.0-11.0 мян.га талбайд үүргийн шүршигч багажаар, 4.0-6.0 мян.га талбайд онгоцоор тэмцлийн ажил гүйцэтгэсэн байна.

Хүснэгт-35

Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажлын гүйцэтгэл 2011-2020 он

| № | Тэмцлийн ажил гүйцэтгэсэн он | Улсын төсвийн хөрөнгөөр | | | |
|----|------------------------------|-------------------------|---------------------|--|---------------------|
| | | Талбайн хэмжээ, га | Тэмцлийн ажлын арга | Гүйцэтгэгч аж ахуйн нэгж | Санхүүжилт, мян.төг |
| 1 | 2011 | 6400 | Үүргийн шүршигч | “Гранд форест” ХХК | 34,816.00 |
| 2 | 2012 | 11054 | Үүргийн шүршигч | “Баян-Онон” ХХК | 75,087.23 |
| 3 | 2013 | 7500 | Үүргийн шүршигч | “Тайгын шинэс” ХХК | 50,950.24 |
| 4 | 2014 | 2000 | Үүргийн шүршигч | “Гранд форест” ХХК | 59,809.60 |
| | | 6000 | Онгоц | | |
| 5 | 2015 | 3996 | Үүргийн шүршигч | “Ойн таксац” ХХК | 24,660.85 |
| 6 | 2016 | - | - | - | - |
| 7 | 2017 | 4000 | Онгоц | “Сайхан ойн төлөө” ХХК | 124,355.00 |
| 8 | 2018 | 19500 | Онгоц | “Сайхан ойн төлөө” ХХК, “Гранд форест” ХХК | 1,154,400.00 |
| 9 | 2019 | 12968 | Онгоц | “Хатант форест” ХХК “Сайхан ойн төлөө” ХХК “Залуу төгөл” ХХК | 335,858.50 |
| 10 | 2020 | 1100 | Үүргийн шүршигч | “Гранд форест” ХХК | 13,100.00 |

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын үр дүн

“Тэмцлийн ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу тэмцлийн ажлын эдийн засгийн үр ашгыг 2011-2020 оны улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг тооцож гаргасан болно.

Тэмцлийн ажлын эдийн засгийн үр ашиг

Тэмцлийн ажилд зарцуулагдаж байгаа зардлын хэмжээг тэмцлийн ажлын дараа ой сэргэн ургаж байгаа эдийн засгийн ач холбогдолтой харьцуулан гаргасан үзүүлэлтийг эдийн засгийн үр ашиг гэж тодорхойлдог. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/176 тоот тушаалын 2-р хавсралтаар батлагдсан ойгоор бүрхэгдсэн нэг га талбайн экологи-эдийн засгийн үнэлгээг бодох аргачлал, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны

А-325 тоот тушаалаар ойн мужлалыг шинэчлэн тогтоосны дагуу 2011-2020 онд ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажлын гүйцэтгэлээр эдийн засгийн үр ашгийг тооцож гаргав. /Хүснэгт-36/

Хүснэгт-36

Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажлын эдийн засгийн үр ашиг

| № | Тэмцлийн ажил хийгдсэн он | Тэмцэл хийгдсэн талбай (га) | Зарцуулсан төсөвт өртөг (мян.төг) | Мужлалын ангилал | 1 га талбайн экологи-эдийн засгийн үнэлгээ /мян.төг/ | Тэмцэл хийгдсэн талбай. (га) | Нийт үнэлгээ (мян.төг) |
|-----------------|---------------------------|-----------------------------|-----------------------------------|------------------|--|------------------------------|-------------------------|
| 1 | 2011 | 6400 | 34,816.00 | II | 50,971.54 | 6400 | 50,971,540.00 |
| 2 | 2012 | 11054 | 75,087.23 | | | 11054 | - |
| 3 | 2013 | 7500 | 50,950.24 | | | 7500 | - |
| 4 | 2014 | 8000 | 59,809.60 | | | 8000 | 117,234,542.00 |
| 5 | 2015 | 3996 | 24,660.85 | | | 3996 | - |
| 6 | 2016 | - | - | | | - | - |
| 7 | 2017 | 4000 | 124,355.00 | | | 4000 | - |
| 8 | 2018 | 19500 | 1,154,400.00 | | | 19500 | 152,914,620.00 |
| 9 | 2019 | 12968 | 335,858.50 | | | 12968 | 76,457,310.00 |
| 10 | 2020 | 1100 | 13,100.00 | | | 1100 | 25,485,770.00 |
| Нийт дүн | | 74518 | 1,873,037.00 | | | 74518 | 3,798,297,217.72 |

Увс аймгийн ойн сан бүхий зарим сумдад ойн хөнөөлт шавжаас хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээнд сүүлийн арван жилд улсын төсвийн хөрөнгөөс 1,873,037,00 төгрөг төгрөг зарцуулж 3,798,297,217,720 төгрөгний экологи-эдийн үнэлгээ бүхий ойн санг навч, шилмүүсний хөнөөлт шавжийн хөнөөлөөс хамгаалсан байна.

Увс аймгийн ойн сан бүхий зарим сумдын ойн санд ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг болон үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэхэд зарцуулсан бэлдмэл бодисын хэмжээ, зарцуулагдсан төсөвт өртгийг доорх хүснэгтээр харуулав. /Хүснэгт-37/

Хүснэгт-37

Ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд шаардагдсан бэлдмэл бодис

| № | Тэмцлийн ажил хийгдсэн он | Тэмцлийн ажил явуулсан талбай (га) | | Тэмцлийн ажилд хэрэглэсэн бэлдмэл бодисын нэр төрөл | Зарцуулсан бодисын хэмжээ (литр) | Зарцуулсан төсөвт өртөг (мян.га) |
|---|---------------------------|------------------------------------|-----------------|---|----------------------------------|----------------------------------|
| | | Онгоцоор | Үүргийн шүршигч | | | |
| 1 | 2011 | - | 6400 | Карате 5% | 1536 | 16,896.00 |
| 2 | 2012 | - | 11054 | Тиаклоприд 2% | 2651 | 36,398.23 |
| 3 | 2013 | - | 7500 | Тиаклоприд 2% | 1799 | 24,700.27 |
| 4 | 2014 | 6000 | 2000 | Тиаклоприд 2% | 1992 | 10,059.96 |
| 5 | 2015 | - | 3996 | Тиаклоприд 2% | 950 | 13,043.50 |
| 6 | 2016 | - | - | - | - | - |
| 7 | 2017 | 4000 | - | Лепидоцид СК | 12000 | 80,355.00 |

| | | | | | | |
|----|------|-------|------|--------------|-------|------------|
| 8 | 2018 | 19500 | - | Лепидоцид СК | 58500 | 906,750.00 |
| 9 | 2019 | 12968 | - | Карате 5% | 2000 | 48,000.00 |
| | | | | Лепидоцид СК | 15600 | 105,602.00 |
| | | | | ЕМ-5 | 2400 | 13,344.00 |
| 10 | 2020 | - | 1100 | Карате 5% | 225 | 5,400.00 |

5.5. Ойн дагалт баялгийн ашиглалт

Ойн баялаг гэж ойн модны нөөц, түүний дагалт баялгийн нөөцийг хэлэх бөгөөд ойн дагалт баялагт ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвх зэрэг ойгоос ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг хэлнэ.

Байгалийн баялаг түүний дотор ой, модноос үйлдвэр, аж ахуй, ард иргэд мод модон материалыг авч ашиглах төдийгүй ойн сангаас самар, жимс, үр боргоцой, хүнсний мөөг, эмийн олон зүйлийн ашигт ургамлыг ашиглаж болно.

“Ойн тухай” хуульд иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ойн дагалт баялгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр заасан газраас, тогтоосон хэмжээгээр авч ашиглаж болохыг заасан байдаг.

Манай орны ард иргэд ойн сангийн талбайд мал бэлчээх, хадлан хадах, ан амьтан, шувуу, зөгий үржүүлэх, холтос хөвх бэлтгэх, шүүс давирхай авах зэрэг туслах аж ахуйг эрт дээр үеэс ашигласаар ирсэн.

Жимс, жимсгэнэ: Жимс, жимсгэнийн ургамал жил бүр баялаг ургацтай байдаггүй бөгөөд жимсний үүсэлтээс болц гүйцэх үе хүртэл хугацаанд гэнэтийн хүйтрэлт, аадар бороо, мөндөр, нойтон цас зэрэг цаг уурын тохиромжгүй нөлөөлөл болон гал түймэр, хортон шавжийн хөнөөлийн улмаас ургац алдах явдал олонтоо тохиолддог.

Ойн мөөг

Манай орны ойд хүнс тэжээлийн ач холбогдолтой олон зүйлийн мөөг ургадаг. Ойн мөөгийг төдийлөн их хэрэглэж заншаагүй боловч сүүлийн жилүүдэд төв, суурин газрын зарим оршин суугчид ойд ургадаг хүнсний мөөгийг түүх, анхны боловсруулалт хийх, хоол хүнсэндээ хэрэглэх аргыг эзэмшиж байна. Ойд ургадаг хүнс тэжээлийн мөөгийг зөв таньж түүж бэлтгэх, хэрэглэх аргыг эзэмших явдал чухал юм.

Мөөгний ургац ихтэй жил 1 га талбайгаас 100 кг хүртэл хэмжээгээр түүж бэлтгэх боломжтой. Ихэнх зүйл мөөг богино насалдаг бөгөөд чийгийн тохиромж бүрдсэн үед барзгар хусандай, хагархай сархиаг, шар хусандай зэрэг мөөг хөрсний гадаргууд цухуйсныхаа дараахан 2-3 хоногт бүрэн боловсордог.

Түүх арга: Мөөг түүх ажлыг хур бороогүй сэрүүн үед өглөө оройн цагаар буюу манан будантай өдөр түүний малгайн хэсэг буюу шилбэний заримыг оролцуулан үндсийг гэмтээлгүйгээр түүх хэрэгтэй.

Хэрэглэх арга: Мөөгийг шууд хүнсэнд хэрэглэхээс гадна даршлах, давслах, хатаах аргаар боловсруулан удаан хугацаагаар хадгалан хэрэглэнэ. Мөөгийг чанахын өмнө цэвэр устай саванд 30 орчим минут байлгаад хог шороог усаар хэд хэдэн удаа зайлж арилгасны дараа чанана. Ойн зарим мөөгний биологийн онцлогийг оруулав.



Тосондой (Suillus S.F.Gray): Малгай нь голчоороо 3-10 см, махлаг, бөмбөгөр юм уу хавтгайдуу оройтой, гялгар салслаг гадаргуутай, хар хүрэн, бор шарга, бор ногоондуу өнгөтэй. Малгайн салс гялгар хуурдаг. Малгай нь эгэл дугариг амсар бүхий шаргал гуурстай. Шилбэ 3-10 см өндөр, 1-2 см бүдүүн, бортгорхуу хэлбэртэй, хүрээтэр эсвэл ягаавтар цагаригтай. Махлаг эд шаргал өнгөтэй. Шинэсэн ойд шинэсний орог тосондой ургадаг. Тэдгээрийг 7 сарын дунд үеэс 9 сарын эх хүртэл түүж бэлтгэнэ. Боловсруулахаас өмнө малгайн хальсыг хуулж угаагаад шарж цуужуулж хэрэглэнэ.



Сархиаг (Lactarius S.f.Gray): Малгай голчоороо 3-12 см, хотгор, юүлүүр хэлбэртэй. Зах нь дотогшоо хумьсан, зарим зүйлийн зах нь сахлаг. Ихэнхдээ салбан нь шилбэ рүүгээ доошоо орж бэхлэгддэг. Малгай улбар шар эсвэл ягаан өнгөтэй, тод өнгийн цагаригтай. Гялгар юм уу үслэг гадаргуутай. Салбан шилбэ хоёр ялимгүй цайвар өнгөтэй. Шилбэ голоороо хөндий юм уу цул. Огтлоход цагаан буюу ягаан шүүс гардаг. Шинэсэн ойд ургадаг. Манайд цайвар сархиаг ургадаг ба хоол хүнсэнд шидмэгийн төрлийн мөөгтэй адил усанд дэвтээж хэд дахин зайлсны дараа чанаж болгоод шарж эсвэл давсалж боловсруулж хэрэглэнэ.

ДҮГНЭЛТ

- Увс аймгийн ойн сангийн талбай 210407 га гэж тогтоогдсон бөгөөд энэ нь Монгол орны нийт ойн сангийн 1.13 хувийг эзэлж байна. Ойгоор бүрхэгдсэн талбай 175656 га байгаа бөгөөд үүнийг Монгол Улсын хойд бүсийн навч, шилмүүст ойн талбайтай харьцуулж үзэхэд 1.26 хувийг эзэлж байна.
- Ойн сангийн өөрчлөлтийг гаргахад 2005, 2010, 2015, 2020 оны Landsat хиймэл дагуулын тоон мэдээнд боловсруулах хийх аргаар ойн бүрхэвчийн өөрчлөлтийг үнэлсэн нь газрын төрлийн өөрчлөлийг нарийвчлан гаргахад чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.
- Хээрийн хайгуул судалгааны ажлаар 586 дээж талбай байгуулж 4102 модны цээжний өндрийн диаметр, 1193 модны өндөр, 105 хожуулын хэмжилт, 528 ширхэг унанги, 235 сэргэн ургалтад хэмжилт хийж эх мэдээг цуглуулсан байна.
- Увс аймгийн ой бүхий 18 сумын ойн санг 389 хэсэглэлийн 13415 ялгаралд хувааж газрын төрөл болон таксацын дундаж үзүүлэлтийг тогтоож үнэлгээ өгөв. Ойн тархалтын зураглалын ажилд Засгийн газрын 2009.01.28-ны “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” 25-р тогтоолын дагуу Олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATER) тусгагийг хэрэглэж талбайг тодорхойлсон ба өмнөх ой зохион байгуулалтын 12421 ялгаралд проекцын засвар хийж газрын төрлийн өөрчлөлтийг гаргав.
- Увс аймгийн ойн санг Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны 325-р тушаалын хавсралтад заасны дагуу хамгаалалтын бүсийн ойг I муж, ашиглалтын бүсийн ойг II мужид хамааруулж Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2020 оны 03-р сарын 16-ний өдрийн А-176 дугаар тушаалын хавсралтын дагуу тооцож үзэхэд Увс аймгийн ойн талбайн нийт экологи эдийн засгийн үнэлгээ 11 865 564 066 659 (Арван нэгэн их наяд найман зуун жаран таван тэрбум таван зуун жаран дөрвөн сая жаран зургаан мянга зургаан зуун тавин ес) төгрөг, ойн нөөцийн экологи эдийн засгийн үнэлгээ 9 451 372 702 142 (Есөн их наяд дөрвөн зуун тавин нэгэн тэрбум гурван зуун далан хоёр сая долоон зуун хоёр мянга нэг зуун дөчин хоёр) төгрөгөөр үнэлэгдэж байна.
- Ашиглалтын бүсийн ойд үндсэн ашиглалтын төрөл, арга, нас, жилийн тооцоот мод бэлтгэлийн хэмжээ зэргийг 0-25 хэмийн налууд ургаж байгаа шинэсэн ойд түүвэрлэх огтлолтоор жилд бэлтгэх модны боломжит хэмжээг тооцож үзэхэд 1 жилд 151 га талбайгаас 3578 шоо.метр мод бэлтгэж ашиглах боломжтой гэсэн тооцоо гарч байна.
- Увс аймгийн ойн санд арчилгааны ажлыг хэрэгжүүлсэнээр 1508 га талбайгаас 32692 шоо метр мод авч ашиглах боломжтой байгаа бол цэвэрлэгээний ажлаар 65680 шоо метр нөөц бүхий 1503 га талбайд хатсан мод цэвэрлэх, 19170 шоо метр нөөц бүхий 1156 га талбайд унанги мод цэвэрлэх ажлыг хийх боломжтой байна.

ЗӨВЛӨМЖ, САНАЛ:

- Ойг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг шинжлэх ухааны үндэстэйгээр явуулахын тулд ой зохион байгуулалтын тайлан, төсөл зурагт тулгуурлан сум, аймгийн “ОЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-г шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх
- Ойн аж ахуйн арга хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд ойн ангиудын инженер техникийн ажилтнуудыг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах
- Байгалийн сэргэн ургалт хангалтгүй байгаа, түймэр, хөнөөлт шавжид нэрвэгдэж ургах чадвараа алдсан ой, байгалийн болцондоо хүрсэн хэт хөгшин ой зонхилох болсон газруудад шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлдэг байх.
- Ойд гарсан түймрийг шуурхай цаг алдалгүй унтрааж байх. Олон удаагийн түймэр болон ойн хөнөөлт шавжийн нөлөөгөөр хатаж хуурайшин дахин сэргэх чадвараа алдсан модыг өмхөрч муудахаас нь цэвэрлэж нөхөн сэргээх.
- Увс аймгийн ойн сангийн нөөц нь хүрч ажиллахад бэрхшээлтэй газруудад байгаагаас ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байна. Иймд ойн санд бүрэн хэмжээгээр хүрч ажиллаж чадахуйц дэд бүтцийг бий болгох.
- Ой зохион байгуулалтын төсөл зургийг ашиглах талаар сум орон нутагт сургалт зохион байгуулж, сумын удирдлага, холбогдох албан тушаалтанд ойн санг мөнгөн үнэлгээгээр нь танилцуулж, үнэ цэнийг нь олон нийтэд ойлгуулах ажлыг зохион байгуулах.
- Ойн санд орсон өөрчлөлт, ойн санд хийгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний ажлын бүртгэл маягтыг тогтмол хөтлөх. Энэ нь ой зохион байгуулалтын ажлын дараа дараагийн шатны ажлын үр дүнг дээшлүүлэхэд их хувь нэмэр болох юм.

ГАРЧИГ

| | |
|---|----|
| ОРШИЛ | 1 |
| Монгол орны ой түүний үүрэг, ач холбогдол | 2 |
| Ерөнхий бичлэг | 3 |
| 1. Ой зохион байгуулалтын ажлын зорилго | 3 |
| 2. Ойн сангийн судлагдсан байдал..... | 3 |
| 3. Ой зохион байгуулалтын техникийн тодорхойлолт | 3 |
| 4. Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх үндэслэл | 4 |
| 5. Ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэсэн хугацаа | 4 |
| 6. Ой зохион байгуулалтын ажлын аргазүй..... | 4 |
| 7. Хяналт, баталгаажуулалт | 8 |
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ | 9 |
| УВС АЙМГИЙН БАЙГАЛЬ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ | 9 |
| 1.1. Газар зүйн байрлал | 9 |
| 1.2. Уур амьсгал..... | 10 |
| 1.3. Ус зүйн нөхцөл | 10 |
| 1.6. Нийгэм эдийн засгийн нөхцөл..... | 12 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ | 14 |
| ОЙН САН | 14 |
| 2.2. Ойн сангийн үзүүлэлт | 19 |
| 2.2.1. Талбай..... | 19 |
| 2.2.2. Нөөц..... | 28 |
| 2.3. Ойн таксацын дундаж үзүүлэлт | 32 |
| 2.4. Ойн нас, насны анги, насны бүлэг..... | 32 |
| 2.4.1. Ойн насны анги..... | 32 |
| 2.4.2. Насны бүлэг | 48 |
| 2.5. Бонитет (чансаа) | 54 |
| 2.6. Өтгөрөл | 56 |
| 2.7. Ойн ургамалжил, ойн хэв шинж..... | 60 |
| 2.8. Аж ахуйн хэлбэр..... | 60 |
| 2.9. Ойн сангийн экологи-эдийн засгийн үнэлгээ | 67 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ | 75 |
| ОЙН САНГИЙН ӨӨРЧЛӨЛТ | 75 |
| 3.1. Ойн сангийн талбайн газрын төрлийн өөрчлөлт..... | 75 |
| 3.2. Байгалийн ойн насны бүлгийн өөрчлөлт | 83 |
| 3.3. Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт | 85 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ | 87 |
| ОЙН САНГИЙН ҮНДСЭН АШИГЛАЛТ | 87 |
| 4.1. Ашиглалтын бүсийн ойн сан | 87 |
| 4.2. Үйлдвэрлэлийн огтлолтын нас, огтлолтын арга | 88 |
| 4.3. Тооцоот мод бэлтгэлийн хэмжээ..... | 89 |
| ТАВДУГААР БҮЛЭГ | 90 |
| ОЙН АЖ АХУЙН АРГА ХЭМЖЭЭ | 90 |

| | | |
|--|--|------------|
| 5.1. | Арчилгааны ажил | 90 |
| 5.1.1. | Арчилгааны огтлолт хийх шаардлагатай ой | 91 |
| 5.1.2. | Арчилгааны огтлолтын давтагдах хугацаа, жилд огтлох модны хэмжээ | 92 |
| 5.1.3. | Арчилгааны огтлолтын арга, огтлох модыг сонгох, огтлолтыг эрчим | 92 |
| Ойн арчилгааны огтлолтын эрчим..... | | 93 |
| 5.1.4. | Арчилгааны огтлолт явуулах хугацаа | 94 |
| 5.2. | Цэвэрлэгээний огтлолт | 97 |
| 5.2.1. | Цэвэрлэгээний огтлолтын хэлбэр..... | 97 |
| 5.3. | Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээ | 98 |
| 5.3.1. | Ойжуулалт | 98 |
| 5.3.2. | Ойн байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээ | 99 |
| 5.4. | Ой хамгааллын арга хэмжээ | 100 |
| 5.4.1. | Ойн түймэр..... | 100 |
| 5.4.2. | Ойн хөнөөлт шавж..... | 102 |
| Тэмцлийн арга хэмжээ..... | | 120 |
| 5.5. | Ойн дагалт баялгийн ашиглалт..... | 123 |
| ДҮГНЭЛТ | | 125 |
| ЗӨВЛӨМЖ, САНАЛ: | | 126 |